

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-61
1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	7-52
2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	52-60
3.Хуулийн төслийг эцэслэн батлах	60-61
4.Баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсох	61

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 31-ний өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ё.Баатарбилэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Ц.Цэрэнпунцаг;

Тасалсан: Ц.Анандбазар;

Хоцорсон: Ш.Адъяаа- 02 минут, А.Адъяасүрэн- 02 минут, С.Амарсайхан- 02 минут, Ж.Батсуурь- 15 минут, Б.Баттөмөр- 06 минут, Б.Бейсен- 01 минут, Д.Ганбат- 05 минут, Н.Ганибал- 16 минут, Б.Дэлгэрсайхан- 12 минут, Г.Мөнхцэцэг- 06 минут, Х.Нямбаатар- 15 минут, С.Одонтуяа- 50 минут, Д.Өнөрболор- 03 минут, Д.Сарангэрэл- 07 минут, Б.Саранчимэг- 03 минут, Ж.Сүхбаатар- 05 минут, Ч.Ундрэм- 59 минут, Д.Цогтбаатар- 03 минут, О.Цогтгэрэл- 01 минут, Б.Энх-Амгалан- 11 минут, Н.Энхболд-03 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Б.Пүрэвдорж нараас албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар
2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, мөн сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 13 цаг 54 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Д.Ганбат, Д.Өнөрболор, Б.Энх-Амгалан, С.Чинзориг, Ц.Туваан, М.Оюунчимэг, С.Ганбаатар, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Ц.Сандаг-Очир, Ш.Адъяа, Б.Баттөмөр, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 14 цаг 42 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Б.Пүрэвдорж, Д.Ганбат нар үг хэлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Төслийн 1 дүгээр зүйл буюу Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан зургаан гишүүнийг олныг төлөөлөх, тавин гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно.” гэснийг “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 5
Бүгд: 68
92.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг бүхэлд нь уншиж танилцуулав.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 6
Бүгд: 68
91.2 хувийн саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Н.Учрал, Б.Дэлгэрсайхан, Ж.Батсуурь нар санал хураалтын дүнг дэмжсэнээр тэмдэглэлд тусгуулах санал гаргав.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Н.Учрал, Б.Дэлгэрсайхан, Ж.Батсуурь нарын саналыг оруулж тооцвол 66 гишүүн дэмжиж, 97.0 хувийн саналаар дэмжигдсэнд тооцогдохыг хэллээ.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, мөн сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ш.Раднаасэд, О.Цогтгэрэл, Ч.Хүрэлбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ үг хэлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 2
Бүгд: 67
97.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал бүрэн эрхээ хэвээр хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 1
Бүгд: 67
98.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг үндэслэн олныг төлөөлөх /мажоритар/, хувь тэнцүүлэн хуваарилах /пропорциональ/ тогтолцоог хослуулан явуулах зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэснийг “2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 25-ны дотор, холбогдох бусад хууль тогтоомжийн өөрчлөлтийг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 3
Бүгд: 67
95.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, мөн сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 1
Бүгд: 67
98.5 хувийн саналаар хууль батлагдлаа.

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 6
Бүгд: 66
90.9 хувийн саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар эцсийн найруулгатай холбогдуулан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./15:52/

2.“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцав./15:52/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн үйл ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн студи, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг, MNB телевиз, Live TV, MN25 телевиз, Өнөөдөр сонин, Өдрийн сонин, gogo.mn, news.mn, МОНЦАМЭ агентлаг, mpa.mn, 24 tsag.mn, ubn.mn, ergelt.mn, zogii.mn, zarig.mn, eguug.mn, see.mn, dens.mn, time.mn, Парламент ТВ сайт зэрэг хэвлэл, мэдээллийн байгууллагын зураглаач, гэрэл зурагчид сурвалжлав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, Э.Сувд-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан нарийн бичгийн дарга М.Номиндулам нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 47 минут үргэлжилж, 73 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 93.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 31-ний
өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их Хуралдай” танхим
12 цаг 06 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 4 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулна,

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна, Зарчмын зөрүүтэй 3 саналтай,

Хуулийн төсөл эцэслэн батална. Нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл,

Дөрөвдүгээрт, баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулгыг сонсоно. Энэ 4 асуудал байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хэлэлцэхээр тогтсон асуудалтай холбогдуулж асуудлын дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлсэн саналаа 17 цагаас өмнө өмнөх өдрийн ирүүлнэ гэж заасны дагуу 3 гишүүн ирүүлсэн байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Бөхчулууны Пүрэвдорж, Балжиннямын Баярсайхан нарын гишүүд ирүүлсэн байна. Жамбын Батсуурь гишүүн. Батсуурь гишүүн байна уу?

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Гишүүдийн өнөөдрийн амар амгаланг айлтгая. Тэгэхээр би та бүхэнд болон Монголын ард түмэнд энэ 5 сарын 5-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн анхны хэлэлцүүлэг дээр энэ ард түмэндээ хандаж хэлж байсан үгийг бас дахин сонсоё. Одоо нэг дэх өдрөөс эхлээд Их Хурлын гишүүд тойрогтоо ажиллана. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг яагаад хийж байгаа талаар тайлбарлана. Тэгэхээр нэгэнт ард түмэн энэ одоо гишүүд кнопоороо асуудал шийдэх учраас та нарын саналыг авсан болоод 152-оосоо нэг жоохон хассан болоод энэ одоо асуудлаа шийдэх байх.

Тийм учраас зүгээр нэг зүлгэн дээр гэр барьж болохгүй ээ. Ард түмэн очиход нь энэ хүмүүсээс 7 биш 5 жилээр тэтгэврээ тогтоо гэдэг энэ хуулийг явуулахыг шаард.

Дээрээс нь хүүхдийн мөнгийг 100 хувь олгоё гэдгийг шаард.

Гуравдугаарт нь, цалин, тэтгэврээ нэмж байж Үндсэн хуулийн өөрчлөлт дээр та нар өөрсдөө эрх мэдлээ ав гэж шаард. Ийм шаардлага тавьж байсан.

Тийм учраас Их Хурлын гишүүд 2 хэлэлцүүлгийн дундуур тойрогтоо явж ажилласан байгаа. Ард түмэн хүчтэй гэдгийг бас харуулж энэ шаардлагын дагуу ард түмний шаардлагын дагуу өнөөдөр Засгийн газар Их Хурал, Их Хурлын дарга бас төсвийн тодотгол хийхийг бас шаардаж байсан. Үүний үр дүнд бас энэ төсвийн тодотголыг 7 сарын 1-нээс өмнө хийж хүүхдийн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

мөнгийг 100 хувь олгохоор мөн түүнчлэн цалин тэтгэврийг одоо нэмэхээр шийдвэр гаргасан байна. Тэгэхээр ард түмэн хүчтэй гэдгийг харуулсан та бүхэндээ талархаж байна.

Өнөөдрийн энэ эрх мэдлийг зүгээр нэг өгч болохгүй. Бид нар бас энэ ард түмэн сонгуулиар бүх асуудлыг шийдвэрлэдэг гэдгийг бас харуулсан та бүхэндээ баярлалаа.

Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Батсуурь гишүүн байхгүй байна.

Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн батлах гэж байгаа энэ түүхэн өдөртэй давхацсан маргааш олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр тохиож байна. Энэ өдрийг угтан 0-18 насны бүх хүүхдэд хүсэлтийг нь үндэслэн хүүхдийн мөнгийг олгох нөхөн олгох шийдвэр гаргасан. Монгол Улсын Засгийн газартаа мянга мянган ээжүүд, хүүхдүүд, гэр бүлүүдийн өмнөөс талархал илэрхийлж байна. Энэ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, алсын хараа 2050 буюу хүний хөгжлийг хөгжлийн гол төвөө болгосон зорилгод нийцсэн шийдвэр болсонд талархаж байна.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр улс орны Засгийн газрууд хүүхдийн дээд эрх ашгийг бүх түвшинд хангах үүрэг амлалтаа биелүүлж чадаж байгаа эсэхээ үнэлж дүгнэдэг өдөр юм. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг Монгол Улс 1990 оны 7 дугаар сарын 5-нд соёрхон баталж хүүхдийн салшгүй хуваагдашгүй эрхийг хүүхэд бүрийн хувьд цогцоор хангах үүрэг хүлээсэн ийм улс орон. Өөрөөр хэлбэл аливаа шийдвэр гаргагчийн гаргаж байгаа шийдвэр бүр аливаа үйл ажиллагаа бүр нь хүүхдийн дээд язгуур эрх ашигт нийцэж байна уу гэдгийг нягтлан үзэж шийдвэрээ гаргах ёстой. Гэсэн хэдий ч

хүүхдийн эрхийг хангах асуудал салбар дундын уялдаа холбоогүй байдлаас болж илт цалгардаж хүүхдийн эсрэг гарч байгаа хүчирхийлэл гэмт хэргийн тоо буурахгүй байгаад сэтгэл түгшиж байна.

Би өнөөдөр 2 асуудалд та бүгдийн анхаарлыг хандуулахыг хүсэж байна. Нэгдүгээрт, насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн ялыг чангатгах ёстой гэсэн байр сууриа дахин дахин илэрхийлж байна. 2002 оны Эрүүгийн хуулиар бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийллийн хэргүүдийг шийдвэрлэхдээ гэмт этгээдэд дунджаар 22.2 жилийн хугацаагаар хорих эсвэл цаазаар авах ял оногдуулж байсан 2015 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэсэн дээрх төрлийн гэмт хэрэгт дунджаар 14.2 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж байгаа нь өмнөх хуультай харьцуулахад ялын бодлого 8 жилээр суларсан байна.

Хоёрдугаарт, Монгол Улс хүүхэд залуусын орон. Үндэсний статистикийн хорооны 2022 оны тоон мэдээгээр Монгол Улсын нийт хүн амын 45.4 хувийг хүүхэд 0-24 насны хүүхэд залуучууд эзэлж байна. Бид боомт түгжрэл зэрэг цаг үеийн шинжтэй олон асуудалд онцгой анхаарч төрийн сайдыг хүртэл томилсон. Гэтэл Монгол Улсын хамгийн үнэт эрдэнэ болсон хүүхэд энэ улс орныг авч явах залуу үед чиглэсэн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх агентлаг нь нийгмийн хамгийн том эмзэг асуудлуудыг хамаардаг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны доор хавсарга шинжтэй явж ирсэн нь хүүхэд залуучууд руу хандсан бодлого хэрэгжихгүй үр дүнгээ төдийлөн өгөхгүй байгаагийн суурь шалтгаан болж байна гэж харж байна.

2025 онд Монгол Улсад хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой болно. Энэ цаг хугацаанаас өмнө гэр бүл хүүхдийн асуудал хариуцсан Хүний хөгжлийн яамтай болох санаачилгыг дэвшүүлж байна. Төсөвт ямар ч дарамт учруулахгүйгээр одоо

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байгаа агентлагийн бүтэц, эрх хэмжээ, цар хүрээг нь өөрчлөх замаар энэ асуудлыг амархан шийдэж болохоор байна.

Миний бие хүүхдийн эрхийн төлөөх сэтгүүлч хуульчдын хамтарсан клубийг байгуулах санаачилга гаргаж өчигдөр хамгийн анхны уулзалтаа амжилттай зохион байгууллаа. Энэ таирамд хүүхдийн төлөө ажилладаг хүүхдэд хайртай сэтгүүлч, хуульчдад талархал илэрхийлье.

Мөн Монгол хүүхдийн төлөө энэ салбарт хүнд хүчрийг үүрч яваа чин сэтгэлээсээ зүтгэж байгаа төрийн албан хаагчдадаа баярлалаа. Монгол хүүхдийн хөгжил хүүхдийн эрхийг хангахын төлөө тууштай ажиллаж байгаа олон улсын байгууллагууд төрийн бус байгууллагууддаа талархал илэрхийлж байна. Одоо хүүхдийн эрхийг хангахад нэн шаардлагатай байгаа Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гэр бүлийн тухай хууль мөн Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Нийгмийн ажлын тухай хуулиудыг нэн даруй батлах шаардлагатай байна.

Та бүхэндээ Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн мэндийг хүргэе. Монгол хүүхэд бүр аз жаргалтай, гэр бүл болгон амар тайван, төр улс маань түвшин сайхан байг.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний 4-ний 3-аас доошгүй ирцтэй түүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж заасан. Ирц 82.2 хувь буюу нийт 73 гишүүний 60 гишүүн оролцож байна. Ирц Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд танилцуулна. Индэрт урьж байна.

Т.Доржханд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2023 оны 38 дугаар тогтоолыг баталсан.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг хийж Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг танилцуулж байна.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2023 оны 38 дугаар тогтоолын дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Хурлын Тамгын газар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг иргэдэд тайлбарлан таниулж тэдний санал бодлыг сонсох ажлыг 2023 оны 05 дугаар сарын 22-30-ны өдрүүдийн хооронд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Энэ хугацаанд Улсын Их Хурлын 57 гишүүн 18 аймгийн 129 сум нийслэлийн 9 дүүрэгт ажиллаж 27983 иргэнд мэдээлэл хүргэж 25868 иргэнээс санал авсан болно. Төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2, 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг 2020, 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдөр эрдэмтэн судлаачид болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл Үндсэн хууль тогтоогчдын зарим төлөөллийг оролцуулан өргөтгөсөн бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгийг санал хурааж шийдвэрлэсэн. Монгол Улсын Их Хурал 1 танхимтай, 126 гишүүнтэй байна.

Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 76 гишүүнийг олныг төлөөлөх 50 гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно гэсэн саналыг Монгол Улсын Их Хурал нэг танхимтай 126 гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна.

Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж өөрчлөн найруулах саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах

өөрчлөлтийн төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үед төслийн 1 дүгээр зүйл буюу 21 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн Монгол Улсын Их Хурал нь нийт 1 танхимтай 126 гишүүнтэй байна.

Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 76 гишүүнийг олныг төлөөлөх 50 гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно гэснийг Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж өөрчлөн найруулах саналыг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүйн саналаар дахин санал хурааж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэйгээр дэмжсэн болно оо.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний 4-ний 3-аас доошгүйн саналаар дэмжигдсэн саналыг төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбар болон 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт болон саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Бямбажавын Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Барсүрэнгийн Баасандорж, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Үүрцайхын Амарбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чулуунбаатарын Дондогмаа, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хуулийн багийн ахлах зөвлөх Чойжилсүрэнгийн Ариунхур, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Нинжбатын Ууганбаатар, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Дагва-Очирын Бумдарь.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Жамбын Батсуурь гишүүнээр тасаллаа.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрбье. Одоо бид нар бас түүхэн хариуцлагатай ийм шийдвэрийг гаргах гэж байна. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөхдөө сонгогчдынхоо нийтийн ашиг сонирхлыг эрхэмлэн Үндсэн хуулийг дээдлэн сахина гэж ингэж тангараг өргөдөг. Тийм учраас одоо бид нар Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудал дээр маш анхааралтай хандах ёстой ийм зүйл. Би 2 удаа тойрогтоо ажиллалаа. Энэ тойрогтоо ажиллах хугацаанд бол 11

уулзалтыг хийлээ. Нийтдээ бараг одоо 900 гаруй хүнтэй уулзсан. Дийлэнх нь Үндсэн хуулийн өөрчлөлтөд орж байгаа гишүүдийн тоо нэмэхийг бол дэмжсэнгүй ээ мөн намын жагсаалтыг одоо бас дэмжсэнгүй. Намын жагсаалтад бол одоо олонд нэр хүнд муутай янз бүрийн хэрэг төвөгт холбогдсон сонгогдох боломжгүй ийм улсууд одоо гарч ирэх нэг шалтгаан болно гэж ингэж үзэж байна.

Тийм учраас иргэдийн маань одоо дийлэнх олонх тэгж үзсэн учраас миний хувьд бол одоо Үндсэн хуулийн өөрчлөлтийг дэмжих боломжгүй. Би бол одоо бас нэг талаар Улсын Их Хурлын гишүүн олон түмний төлөөлөл. Би тэд нарын мандатын эрхийг хэрэгжүүлж байгаа ийм хүн.

Тийм учраас би бас одоо энэ үүргээ биелүүлэх ёстой. Нийт уулзсан иргэд дотор ер нь нэг 5, 6 хүн л одоо гишүүдийн тоон дээр эргэлзсэн байр суурь илэрхийлж байгаа байхгүй юу. Тийм учраас одоо би энэ иргэдээсээ, сонгогчдоосоо сонгуулиар очих бүрдээ одоо би та нарын төлөө ясаа дундартал зүтгэнэ гэж ингэж ярьчихаад өнөөдөр би одоо тэд нарын сонгох эрхэд халдаж чадахгүй. Яагаад гэвэл Үндсэн хуулийн журмын тухай хуулийн 5.4.2-т байдаг юм. Үндсэн хуульд өөрчлөлт оруулахдаа нам бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн байж болохгүй гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл иргэдийн одоо сонгох эрх буурч байгаа учраас би энийг хэлж байгаа юм. Одоогийн Үндсэн хуульд бол иргэд сонгох эрх нь давуу. Шууд сонгодог гишүүдээ.

Тийм учраас энэ намын эрх мэдэл сонирхол илэрхийлэгдэж байна гэж ингэж харж байгаа юм. Нөгөө талаар Журмын тухай хуулийн 5.4.3-д Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хүний үндсэн эрхийг дордуулж болохгүй гэж байгаа юм.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Тэгэхээр иргэний үндсэн эрх сонгох эрх. Тэр тусмаа одоо Улсын Их Хурлын гишүүнээ шууд сонгох эрх. Тэгэхээр энэ эрхийг бол одоо дордуулж болохгүй ээ гэж энэ Үндсэн хуультай ижил үйлчилж байгаа ийм хууль байгаа учраас би одоо ийм хуулийн заалтыг бол зөрчиж болохгүй ээ гэж ингэж үзэж байна. Тэгээд ер нь яах вэ иргэдийн нэг хэлж байгаа асуудал бол 3 жилд 3 удаа өөрчлөлт орох гэж байна гэж байгаа юм. 2019 онд орсон. Саяхан бид бас одоо давхар дээлтэй Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн дагуу 2 дахиа оруулчихсан. Одоо 3 дахиа.

Тэгэхээр энэ бол Үндсэн хуулийн би зүгээр үүнийг хэлж байгаа юм. Хожим хожмын нэг өдөр бас одоо Үндсэн хуульд өөрчлөлт оруулах гээд ийм яриа гарах байх гэдэг дээр л бодож хэлж байгаа юм шүү.

Өнөөдрийн биднээр энэ Монголын төр зогсчихгүй. Дараа дараагийн үеүд гарч ирнэ. Тэд нар мөн л одоо арай л дутуу байсан юм одоо гүйцээе гээд л ингээд л ханцуй шамлаад унаж бас би магадгүй гэж бодож байгаа учраас би үүнийг хэлж байгаа юм.

Энэ төрийн албаар би бараг хөдөлмөрийнхөө бүх насыг элээлээ. Тийм учраас би энэ төрийн албаны ялангуяа төрөө дээдлэх энэ ёс журмаас бол би 2 нүүр гаргаж чаддаггүй. Хууль юу гэж бичигдсэн байна би тэрийг л дагадаг. Намайг янз бүрээр гүтгэдэг. Тэглээ ч гэсэн яаж ч чаддаггүй юм би хууль дагаж байсных. Ер нь төрийн албаны ёс зүй хуулийг л дагадаг байх ёстой. Хуулиа дагахгүй болоод тэр тусмаа Үндсэн хуулиа ингээд хүндэтгэхгүй болоод ингээд ирвэл Монголын төр хямарна. Хэн нэгэн улс төрийн хүчин цааш цаашидаа өөрийнхөө ашиг сонирхолд Үндсэн хуулийг өөрчилдөг ийм байдал руу явна. Бас л болоогүй гээд л ингээд л явна. Би тэрэнд ерөөсөө эргэлзэхгүй байна. Би зүгээр энэ бүгдийг хэлэхдээ бас улс орны маань цаашдын хувь заяа доголдохгүй байгаасай гэсэндээ хэлж байгаа юм.

Би өөрийгөө бодвол дуугүй байгаад байж болно. Би нэлээн бодлоо. Ер нь хүн бол хэлсэн үгэндээ эзэн, үерхсэн нөхөрлөлдөө үнэнч байж байх хэрэгтэй. Би тэгж л явж ирсэн. Тийм учраас би одоо тэр намайг сонгосон олон түмнийг бол би 2 нүүр гаргаж үнэхээр чадахгүй. Тэд дургүй байгаа бол одоо би тэрийг нь илэрхийлэхээс өөр надад ямар ч арга байхгүй. Ер нь зүгээр би бол юу гэж бодож байна гэвэл цаашидаа бол энэ хууль батлагдсаны дараа нөгөө иргэд 7 дордууллаа гэж ярьдгаасаа л доор юм ярих болов уу л гэж би бодож байна. Тэгэхдээ цаг хугацаа шүүнэ ээ, цаг хугацаа биднийг бүгдийг шүүнэ. Бидний бүх юм хязгаартай. Энэ 2 бол үнэн. Цаг хугацаа шүүнэ. Бүх юм хязгаартай.

Тийм учраас нэг өдөр бол түүхийн үнэнтэй бид нар нүүр тулна аа. Та нар улс орныхоо хувь заяаг өнөөдөр шийдэх гэж байна. Янз бүрийн л тайлбар хэлээд байгаа л даа. Хэрвээ би та бүгдийн тайлбарт итгэл үнэмшил төрсөн бол би ингээд суухгүй. Төрөхгүй байгаа учраас би өнөөдөр ингэж хэлж байгаа юм. Энэ Их Хурал сульдана, доройтно. Одоо бол манай Их Хурал бол их ардчилсан Их Хурал байхгүй юу. Бүгд үгээ хэлж чаддаг, илэрхийлж чаддаг, ард түмнийхээ үзэл бодлыг илэрхийлж чаддаг. Цөөхүүлээ учраас. Бусад орны парламентуудтай би танилцаж л байсан юм. Ийм ардчилсан парламент бол цөөхөн байдаг. Төлөөлөөд л 1, 2 хүн нь үг хэл гээд л намын бүлэг нь шийдчихдэг. Цаашидаа тийм болох байх. Парламент нэлээн сулдах байх. Парламент сулдана гэдэг чинь бол бидний төрийн дархлаа суларна л гэсэн үг.

Тэгээд өнөөдөр бол та бүхний одоо мэргэн оюун ухаан шийдэг. Тэгэхдээ энэ бол хөнгөхөн бодож шийдэх асуудал биш. Улс орны тэр дотроо олон түмний хувь заяа энд багтаж байгаа. Ингэж бодож хандаасай гэж бодож байна. Тэрнээс биш амьдрал үргэлжилдгээрээ л үргэлжилнэ. Өнөөдрийг ерөөсөө бодож болохгүй.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга ажлын хэсэг хариулах уу? Асуулт хариулт явж байна.

Асуулт хариултын цаг шүү дээ. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасны дагуу 2, 3 дахь хэлэлцүүлгийн хооронд гишүүд орон нутагтаа тойрогтоо ажиллаж, иргэдтэй уулзаж, саналыг нь авах ажлыг зохион байгуулах, Улсын Их Хурлын даргын захирамж, чиглэл гарч гишүүд тойрогтоо ажилласан. Үндсэн хуульд оруулах өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуулийг дээдлэн сахих Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хамгаалах ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах, бодитой, ил тод байх нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасан байдаг.

Төслийг хэлэлцэхдээ энэ зарчмыг бид байнга санаж ягштал мөрдөж хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцож, идэвхтэй оролцох учиртай гэж сануулж хэлье.

Одоо ингээд Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Нэгдүгээрт, бид нар одоо сүүлийн нэг жил ямар засаглалтай яваад ирэв ээ? Уул нь Үндсэн хуулиараа бид нар парламентын засаглалтай. Тэгтэл өнөөдөр өнөөдрийг хүртэл сүүлийн нэг жил парламентын засаглал үндсэндээ байхгүй болчихлоо шүү дээ гэж ойлгож

байна. Манай Улсын Их Хурлын гишүүдийн тал нь Засгийн газарт ороод суучихсан. Энэ олонхын бүлгийн нөгөө засаглал хуваах зарчим бие даасан, хараат бус шүүх, нөгөө гүйцэтгэх засаглал, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалд хяналт тавих энэ бүх юм байхгүй. Өнөөг хүртэл явлаа. Тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг жилийн өмнө хийсэн 8 сард хийсэн өөрчлөлтөөр Үндсэн хуулийг манадаг манаачтай нийлээд Үндсэн хуулиа хулгайлсан энэ олонх. Энд одоо идэвхийлэн олин намын нөхдүүд тухайн үедээ бараг дагуул нам болчих шахсан манай хэдэн нөхдүүд, ингээд оролцоод ийм муухай юм хийсэн. Гэтэл өнөөдөр одоо олон Үндсэн хууль судлаачид, хуульчид байгаад байдаг. Хэн нь ч юу ч дуугардаггүй. Их харамсалтай байгаа юм л даа. Үндсэн хуулийн хэлэлцүүлэг яаж явагддаг юм бэ гэдгийг бол саяын өнгөрсөн 5 сарын 3-аас хойших энэ хугацаанд харагдаж байна. Нэг дэх, 2 дахь, 3 дахь хэлэлцүүлэг. Өнөөдөр 3 дахь хэлэлцүүлэг явагдаж байна. Энэ бол хуулийнхаа дагуу явж байна. Тойрогтоо 2 удаа очиж ард иргэдтэйгээ санал бодлоо солилцлоо. Мэдээжийн хэрэг энэ талаар сонсох ч дургүй байна хүмүүс бол. Яагаад вэ? Энэ ард түмний амьдрал үнэхээр доройтсон байна. Энэ хулгай зэлгий, энэ гэмт хэрэг энэ бүх юмтай чинь туйлдсан байна шүү дээ.

Юмны үнэ ханишийн өсөлт. 8 жил одоо 65, 62 суудал өгөөд явуулчихсан тэгээд энэ 8 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил нь ердөө л энэ. 3 хүний 2 нь ядуу болчихсон. Ийм л байдалтай байгаа. Тэгээд ингээд анхааралтай сайн ажиглах юм бол ерөөсөө л юу байгаа шүү дээ. Энэ намууд чинь төлөвшихгүй байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ одоо засаглал хуваах харилцан хяналттай байх энэ зарчим чинь алдагдчихсан байна. Энэ бүх юмаа засаж залруулах гээд л нэг иймэрхүү маягтай л бараг сар ажиллаж байна шүү дээ. Ахиад энэ маягаараа ахиад нэг жил болох юм шиг байна. Тэгээд 2024 оны 6

сараас хойш сонгууль явагдсаны дараа арай өөр байдалтай явах юм уу гэж ойлгож байна. Тэгээд Засгийн газар энэ хуулийг санаачлаад л оруулж ирэхэд нь би тухайн үед нь асууж байсан, хэлж байсан, ярьж байсан.

Та бүхэн ард түмэн дээр очиж тайлбарла. Ард түмэн маань бас одоо энэ зүүний чиглэлтэй намууд олон жил засгийн эрх барьсаар байгаад би яриад байгаа шүү дээ. Тэр халамжийг нь хэтрүүлээд, хавтгайруулаад ингээд явчихсан. Хажуугаар нь хулгай энэ авлига гаарсан эрх баригчдын. Ийм л нөхцөл байдалтай байна. Тэгээд энэ Үндсэн хуулиа ингэж өөрчилснөөрөө тоо нэмэгдээд, холимог систем орж ирснээрээ энэ бүхэнд одоо өөрчлөлт орж чадах уу? Энэ зүйлийг би удаа дараа асууж байгаа. Очиж ард түмнээ гэгээрүүлээч ээ. Тэр хүнсний талон тараагаад байхаа болиоч ээ. Тэр очих ёстой хүмүүст нь халамжийг нь өг. Татвар төлөгчдийн мөнгийг үр дүнтэй зарцуул. Энэ олон сангуудыг дээрэмдсэн, хулгайлсан. Энэ тендер, энэ бүх авлигын систем, энэ бүх юм чинь одоо ард түмэн бол энэ Улсын Их Хурлын гишүүдийг сонсохооргүй тийм байдалд оруулчихсан байна шүү дээ. Тэгээд яаж байна вэ? Өнөөдөр нэг хулгайтай тэмцэж байгаа дүр үзүүлж байна. Ямар ч арга хэмжээ авч байгаа ийм юм алга. Уриа лоозон хурлаар ийм юм хийдэггүй юм. Хууль хяналтын байгууллагууд тогтмол ажиллаж байх ёстой. Яг хуулийг дээдэлж ажиллах ёстой. Гэтэл тийм юм алга байна шүү дээ. Одоо намын жагсаалт. Энэ намын жагсаалтыг одоо ямар янзаар яаж хийх юм бэ. Ядаж одоо намын жагсаалтдаа Улсын Их Хуралд нэг удаа ард түмнээр сонгогдсон ийм хүмүүсээ оруулах хэрэгтэй.

Ард түмний амьдралыг мэддэг. Тэгэхгүй бол одоо яг удаа дараа иймэрхүү юмнууд болж байсан. Баахан болсон болоогүй хэдэн сөөсгөр банди нар, годгор охид ингэж оруулж ирээд яг улаан хамгаалагчид одоо Хятад Улсыг яаж

самарсан. Манай бошгыг халах эвлэл Монгол Улсыг яаж самарсан. Яг ийм маягаар ажиллаж болохгүй шүү. Энийг зөв хийвэл зөв байх. Буруу хийвэл бүүр нөгөө тийшээ явж болно шүү дээ. Энийг би бас анхааруулчихъя. Тэр Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн намын ил тод байдлын тухай санхүүжилтийн хууль энэ бүхэн юм ярих ёстой. Тэгэхгүй бол энэ намууд чинь одоо бүгдээрээ л нэг ял наймаалцдаг хэдэн хулгайчид бүлэглэлүүдийн гарт орчихсон байна шүү дээ. Энд чинь л ард түмэн дургүйцээд байна. Энэ дээр яаж цэг тавих юм. Улсын Их Хурал бол өнөөдөр одоо бүтэн нэг жил энэ Монгол Ардын намын хэсэг бүлэг этгээдүүдийн хуулийн хэлтэс шиг л улаан булан шиг нь л ажиллаж байна шүү дээ. Ийм л байна.

Ер нь одоо тэгээд зөв зүйтэй юмыг олонх дэмждэггүй юм даа. Тухайн үед би алтны татварыг 2 хувь болгоод л оруулж ирж байсан. Бүгд дэмжихгүй байсан. Сайн ухуулаад, яриад, толгойд нь оруулаад өгөхөөр дэмждэг юм. Тэрний хүчинд одоо 4 тонн алт авдаг байсан манай Монгол Улс эргээд 22 тонн л алт авдаг болсон шүү дээ. Энэ хуулийг би санаачилж би батлуулсан юм. Ганцхан өгүүлбэр. Би яагаад энийг ярьж байгаа юм. Би бол цөөнхийн цөөнх болчихоод байгаа хүн. Гэхдээ ийм хуулийг зөв батлаад зөв явуулж чадвал энэ одоо 3 сая 500 мянган хүнтэй, энэ 70 сая малтай тэр 60, 70 хувь нь одоо залуучуудад хийгдэж байгаа англи хэлээр одоо бараг 60, 70 хувь нь ярих гэж байгаа ийм улс орон бол амархан л хөгжинө шүү дээ. Тэр зах зээлийн систем зарчмаар нь одоо хар л даа. Энэ төрийн оролцоогоо. 40, 50-д нь хүрчихсэн. Хувийн хэвилийн ажиллах орон зай гэж юу ч байхгүй. Баялаг бүтээгчид байхгүй. Тэр 30, 40, 50 хувийн ноолуурыг дэлхийн зах зээл дээр Монгол Улс гаргадаг. Гэтэл үнэ цэн нь ямар байна? Малчдын амьдрал ямар байна. Энэ уул уурхай чинь тамтгаа алдсан. Үгүй ээ, нэг сумд 40, 50 лиценз байна шүү дээ. Нэг баг дээр 20, 30 лиценз. Ийм юман дээр

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

одоо хэмжээ хязгаар тогтоохгүй болохгүй байна.

Өнөөдөр сөрөг хүчин гэж байхгүй байна. Тэгээд сөрөг хүчин байх ёстой хаачив гээд байх юм. Үгүй ээ, тийм юм байхгүй байх нь нэг талдаа сайн шүү дээ. Олонх зөв зүйтэй юмаа хийгээд ажиллаад явах ёстой шүү дээ чадахгүй л байна та нар, харамсалтай л байна.

Тэгээд ард түмэн маань энд их бухимдаж байна шүү. Тэгээд хийх гэж байгаа бол хийсэн юм шиг хий л дээ. Хийж чадахгүй бол яришиг тэр 76-аараа явъя л даа. Тэгээд энэ олонх нь ч одоо тэгээд бүлгээрээ яриад олонх болж чаддаггүй ийм л завхарсан Улсын Их Хурал.

Г.Занданшатар: Ажлын хэсэг хариулах уу? Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Одоо парламентын засаглалтай болоод л өнөөдөр Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг парламентаараа хэлэлцээд байж байна гэж бодож байгаа биз. Өөр хэн ч хэлэлцдэггүй асуудал.

Засгийн газраас санаачилж оруулж ирсэн хуулийнхаа төслийг тойроод л бид нар ярьж байгаа. Их Хурал 2 удаа хэлэлцүүлгээ хийчихсэн, 2 удаа дэмжчихсэн. Завсарт нь явсан. Хэлэлцүүлгүүдийн дүнг харгалзаад зарим өөрчлөлтүүд оруулчихсан.

Дээр нь Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намууд суудалгүй намууд ийм саналыг харгалзаж үзээд бас зарим анхнаасаа орж ирсэн төслөөсөө арай жоохон өөрчлөлт оруулчихсан. Ийм л Үндсэн хуулийн өөрчлөлтийн төслийг өнөөдөр бид нар 3 дахь хэлэлцүүлгээ хийж байна.

Оруулж ирсэн төслийн гол санаа бол сая Ганбат гишүүний яриад санаа нь зовоод байгаа төрийн байгууллагууд байх байх. Байрандаа байдаг зөв тогтолцоогоор бүрэлддэг. Тэр нь одоо

бид нарын 30 жил явж ирсэн амьдралын алдаа сургамжаас санаа аваад, тэрийгээ сууриар нь яаж өөрчилбөл зохих вэ гэдэг асуултад хариу өгөх гээд сүүлийн одоо зүгээр зөвхөн Их Хурал дээр ярилцсаныг нь тооцвол 2008 оноос эхлээд Их Хурал дээр ажлын хэсгүүд байгуулагдаж, удаа дараа ярьж байсан асуудлуудыг ярьж байгаа.

Нөгөө талаар ер нь анх Засгийн газар саналаа оруулж ирэхдээ ч хэлсэн. Хэлэлцүүлгийн явцад манай гишүүд ч хэлж байгаа. Үндсэндээ тэр гучаад жил яригдаж байгаа зүйлүүдийг л нэг мөсөн хийж чадахгүй санал хүрэхгүй явсаар байгаад л одоо нэг гүйцээх асуудлууд үлдээд байна гэж тэр нь эргээд өнөө маргаашийн асуудал гэхээсээ илүү Монгол Улсын наад зах нь ирээдүйн 30 жилийн төрөө яаж бүрэлдүүлэх вэ төр нь яаж ажиллаж байх вэ гэдэг зарчмуудыг бас алдаа сургамжаасаа хичээл аваад засаж залруулах ийм санал оруулж ирээд одоо үндсэндээ өнөөдөр эцсийн хэлэлцүүлэг явж байна л гэж ойлгож байгаа. Байнгын хороон дээр ч ийм агуулгаар яригдсан.

Ер нь бол эцсийн хэлэлцүүлэг дээр миний одоо ойлгож байгаагаар дэгээр Байнгын хорооноос оруулж ирсэн санал, дүгнэлт 2 дугаар хэлэлцүүлгээс хойш 2 дугаар хэлэлцүүлгээр дэмжсэн саналууд дээрээ орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар гол нь цагаа зарцуулж ярьж асуувал дэгтэй юм. Тэр нь ч хэрэгтэй болов уу л гэж бодож байна. Баярлалаа.

Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Баярлалаа. Ер нь бол одоо тэр жагсаалтаар 48, тойргоос 78 хүн сонгогдох юм байна. Энэ одоо ямар юман дээр үндэслэж гарч байгаа тоо вэ? Нэг хэсэг 152, 76, 76 гээд байсан. Дараа нь 50, 70, 76 гээд байсан. Яагаад ингэж өөрчлөгдөж байгаа юм бэ? Энэ яг зохистой харьцаа мөн үү гэдэг зүйлийг асууя.

Нөгөө талаар цаашидаа үгүй ээ, яах вэ, би ер нь энэ нэг цөөхөн нэр цэвэр

гишүүдийн нэг л дээ. Ямар нэгэн юманд орооцолдоогүй. Ийм хүний нэг. Ямар нэгэн барьцаанд ороогүй.

Тийм учраас би асуугаад байгаа юм л даа. Асууж чадаад байгаа юм. Тийм учраас та нарыг шүүмжилж чадаад байгаа юм. Би цаашидаа мэдээж хэрэг энэ одоо тогтвортой явах уу, үгүй юү та нар ахиад бас одоо сонгууль нь болоогүй байсаар байтал жилийн хугацаа үлдэж байна. Энэ Улсын Их Хурал 4 жилийн бүрэн эрхтэй гэж би ойлгож байгаа. Ард түмэн тэгж сонгосон. Тэрний наана бас ахиад өөрчлөх үү, үгүй юү, ямар байгааг. Хэн дуртай нь ингээд өөрчлөөд байдаг тоо байдаг юм уу эсвэл наад одоо судалгаа шинжилгээ, одоо тийм тооцоо энэ тэр байдаг юм уу, үгүй юм уу? Тэгээд төлөөлөл гээд байгаа. Янз янзын төлөөлөл оруулж ирэх вий. Үгүй ээ төлөөлөл гэвэл биеэ үнэлэгчдийн төлөөлөл ч орж ирж болно шүү дээ. Бас нууц амрагуудын юм уу? Та бүхний төрөл төрөгсдийн юм уу, хүүхэд шуухдынхаа ийм жагсаалт болгочих вий. Ийм нэр дэвшилт болох вий. Та нар тэрийг яах вэ? Намуудынхаа хуулиар хааж өгөх үү яах вэ? Ямар байх юм.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга хариулъя. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч хариулна.

Н.Энхболд: Ер нь судалгаа тооцоо, шинжлэх ухааны үндсэн дээр энэ асуудлуудыг ярьж байх ёстой гэдэгтэй санал нэг байна. Бүрэн дүүрэн санал нэг байгаа. Сэтгэлийн хөдөлгөөнөөр биш тэр талаас нь хараад үзвэл Засгийн газраас анх оруулж ирсэн хувилбар бол яах вэ? 152 гэсэн тоо нь л 2 дахин харагдаж байсан болохоос биш бусад улс орнуудад хэрэглэж ирсэн манайхаас олон жилийн түүхтэй парламентууд хэрэглэж ирсэн газар нутаг, хүн ам, аюулгүй байдал, бүх л юмаа тооцож байгаад Их Хурлын гишүүдийнхээ тоог гаргадаг тэр томъёолол аргачлалаар гаргаад ирсэн тоо нь тэр байсан, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нөгөө танаас сая асууж байгаа энэ харьцааны хувьд гэвэл бас ер нь хамгийн одоо тохиромжтой зөв зохистой харьцаа нь бол холимог системийн үед 50, 50 байх ёстой гэдгийг бас л одоо онол талаасаа ч хэрэглэгдэж ирсэн бусад орнуудад, практик талаасаа ч. Хэрэв холимог байвал хамгийн тохиромжтой харьцаа нь энэ гэсэн байдлаар орж ирсэн. Тэгээд бид нар бол одоо нэг хэлэлцүүлэг хийгээд 2 дахь хэлэлцүүлэг хийгээд энэ явцдаа бас өнөөдрийн нөхцөл байдал, нийгмийн уур амьсгал, намуудын хоорондын одоо ойлголцол ямар ч байсан энэ асуудлынхаа цаана гаръя гэсэн нэг тийм эрмэлзэл энэ бүх үндсэн дээр ярьж байгаа.

Дээр нь, ер нь одоо иргэдээс уулзалт хийгээд явж байхад голлож гарч байсан нэг санал гэвэл газар нутаг, хүн амынхаа төлөөллийг манайх шиг ийм жижиг бага хүн амтай, том газар нутагтай улсын хувьд энийгээ заавал хадгалж байх нь зүйтэй, 1 дүгээрт.

Хоёрдугаарт, ер нь энэ харьцааны энэ тал нь давамгайлж байх нь зүйтэй гэсэн ийм саналууд дийлэнх нь гарч байсан учраас 60, 40 гэдэг хувилбарыг Ардчилсан намын зүгээс гаргасан гэж гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа.

Г.Занданшатар: Өөр минут байхгүй юм байна. 8 минут асуугаад, 2 минут тодруулаад, 3 дахь хэлэлцүүлэг явах журмын дагуу зааснаар.

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Улсын Их Хурлын гишүүд энэ 2 хэлэлцүүлгийн өмнө одоо бүгд тойрогтоо ажиллаад ирсэн. Тэгээд Сэлэнгийн нийт санал өгсөн иргэдийн 90 гаруй хувь нь өнөөдөр тоо нэмэгдүүлэх асуудал дээр бол маш эмзэг хандаж байна шүү. Хэдийгээр өнөөгийн энэ тэгш бус байдал,

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

авлига хээл хахууль, тогтворгүй засаглал, мөнгөний сонгууль гээд л гал унтраах байдлаар аргацааж ирсэн энэ тогтолцоог засахын төлөөх Засгийн газрын санаачилгыг сонгуулийн тогтолцооны хувьд нь дэмжиж байгаа болов ч энэ өндөр тооны ард илүү шударга, илүү ёс зүйтэй, улс орныхоо эрх ашгийг эрэмбэлж чаддаг ёс суртахуунтай ийм төлөөлөгчийг сонгох ийм хүсэлтэй байгаагаа бол иргэд хатуу шаардаж байна.

Нөгөө нэг асуудал нь бол энэ ард иргэд холимог тогтолцоог дэмжиж байгаа болов ч энэ жагсаалтын цаана нөгөө л нэг болохгүй бүтэхгүй одоо улс орноо тоносон, дээрэмдсэн, янз бүрийн энэ улсуудын ёс зүйгүй улсуудын төлөөлөл орж ирэх үү гэдгээс бол маш болгоомжилж хандаж байна. Бүр тэр байтугай итгэхгүй байгаагаа ч гэсэн хатуу шаардаж хэлж байна. Бас нэг асуудал нь энэ Улсын Их Хуралд суудалгүй намууд жагсаалтаа эрэмбэлж худалддаг. Ийм мөнгөний сонгууль болох эрсдэл байгааг ч бас хэлж бас шүүмжилж байгаа байна.

Тэгэхээр ер нь иргэд энэ сонгох эрхээ, сайхан амьдрах боломжоо, үр хүүхдээ, энэ улс орныхоо ирээдүйг, дахиад энэ бусдад энэ боломжоо алдах вий дээ гэхээс бол маш их эмээж байна гэдэг маань юу гэж байна гээд тэгэхээр иргэд, төр 2-ын хоорондын итгэлцэл бол маш ан цав үүссэн байна. Энэ итгэлцэл бол үндсэндээ бас алдагдсан байгааг бид анхаарах ёстой.

Уул нь Ерөнхий сайд энд байсан бол энэ иргэдийн бас ажил хэрэгч нэг асуултыг би бас асууя гэж бодсон юм. Ер нь Засгийн газар энэ хуулийг санаачилсныхаа хувьд намын даргын хувиар ч гэсэн одоо бас энэ асуултыг бол асууя. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт ер нь энэ сонгуулийн хууль журам Улс төрийн намын хуулийн шинэчлэл, нэр дэвшилтээс ихээхэн хамаарч тийм ээ, энэ Үндсэн хуулийн өөрчлөлт явагдана.

Тэгэхээр энэ Үндсэн хуулийн яг энэ өөрчлөлтийг тайлбарлаад байгаа шигээ энэ үзэл баримтлалыг нь яг ингээд амилуулах баталгааг иргэд өнөөдөр асуугаад бас нэхээд байгаа байхгүй юу. Энэ дээр би бас байр суурийг нь сонсъя гэж бодсон юм. Ер нь цаашид энэ Сонгуулийн болон энэ Улс төрийн намын хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор хэлэлцэх үед бол бас миний бие энэ ард иргэдээс ирж байгаа олон асуудлуудын хариу шийдлүүдийг бас нэхэж шаардсаар ажиллана гэдгийг бас хэлье.

Дараагийн нэг асуудал нь бол энэ иргэд олон түмэн ер нь сүүлийн 30 гаруй жилд ер нь энэ манай улс чинь ер нь засаглалтай байсан юм уу?

Хэрэв төр засаг ярьдаг шигээ үнэхээр сайн засаглалтай байсан бол энэ хулгай, дээрэм, луйвар ер нь болох байсан юм уу. Дэлхий дээр ер нь энэ ардчиллын илэрхийлэл болсон ард түмний элч төлөөлөгчдийг өнөөдөр Монгол Улсад хулгайч гэдэг нэр цолтой болох хэмжээнд хүрэх байсан юм уу. Өнөөдөр албан тушаалтнууд, хууль тогтоогчид ард түмнийхээ өмнө хэлэх үг учирлан ойлголцох ийм боломжгүй болсон, болох хүртлээ ийм ичгүүртэй нөхцөл байдал болох байсан юм уу гэдэг ийм асуудал байгаа. Өнгөрсөн хугацаанд энэ Хөгжлийн банкны асуудал, ЖДҮ, Боловсролын сангийн зээл болон энэ олон сангууд бол тоногдсон ийм байдалтай байна. Тэгээд энд болохлоор чинь бол сүүлийн энэ 20, 30 жил мэдээлэлд ойр, эрх мэдэлтэй манаач намын, тэр намын, энэ намын гэх аргагүй маш олон улсууд оролцсон байх юм. Тэгээд сүүлийн өнгөрсөн 7 хоногт болж өрнөсөн энэ Боловсролын зээлийн сан дээр л аваад үзэхэд чинь манай намын гишүүд, Ардчилсан намын гишүүд, дээрээс нь дарга нь тэр байтугай Хун нам Доржханд гишүүн тээ даргыг нь би бол энэ Доржханд гишүүний улс орны хөгжил өөрчлөлтийн талаарх зөв зүйтэй асуудлыг нь бол дэмждэг юм.

Харин энэ тэр хүний энэ байгаа энэ мораль, энэ этик, энэ ёс зүйг танаас өөрөөс чинь олж харахгүй байгааг бол үзэж хараад үнэхээр таагүй мэдрэмж төрж байна. Энийг бол залуучууд ч бүгдээрээ мэдэж, ойлгож байгаа. Тэгээд би энийг яагаад ярьж байна гээд тэгэхлээр энэ хариуцлагагүй, ёс зүйгүй, чадварлаг боловсон хүчингүй болсон энэ төрийн механизмыг ер нь шинэчлэхдээ энэ бүхнийг төрүүлээд бий болгоод байгаа энэ намын шинэчлэлтэй салиггүй холбоотой юм.

Тэгээд үүнийг нь удирдаж байгаа хүмүүсийн улс төрийн соёл, ёс зүйн манлайлал бас их чухал үүрэг гүйцэтгэнэ. Энийг бол улс орнуудын жишгээс бол хардаг даа. Бид нар мэдэж л байгаа шүү дээ. Тэгээд үнэхээр л энэ улс орныхоо төлөө энэ шинэчлэлийг хийх гээд байгаа юм бол энэ улс орон яг энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр улс орон дэвжих нь үнэн л юм бол яг энэ торгон мөч дээр яг энэ түүхэн энэ цаг үед ядаж хамгийн наад захын улс төрийн соёл болох ард түмнээсээ ядаж уучлалт гуйчих энэ алхмыг энэ дарга нар хийж болдоггүй юм уу.

Тэгэхлээр би бас энэ тал дээр энэ намын дарга нараас бас байр суурийг нь сонсёе гэж бодож байна. Ер нь иргэд, сонгогчидтой энэ хийсэн уулзалтууд дээр бол өмнө нь бол шийдэл хайсан, бас төсөл хөтөлбөр ярьсан, асуудалд чиглэсэн бас ийм сайхан уулзалтууд болдог байжээ. Одоо бол үндсэндээ бол иргэдтэй уулзана гэдэг бол төрд бухимдсан бухимдлаа илэрхийлсэн ийм л талбар болсон байна. Үүн дээр бол бид нар анхаарлаа хандуулах ёстой гэж бодож байна.

Эдийн засаг сэргэх төлөвтэй орлоо, үзүүлэлтүүд нь сайжирч байна гээд яамнуудын сайд нар бол бас мэдээлэл хийж байгаа. Гэтэл иргэдийн яг гар дээр очдоггүй энэ эдийн засгийн өсөлтийг хүмүүс өсөлт гэж үзэхгүй байна шүү дээ. Хүмүүс өсөлт гэж үзэхгүй байна. Энэ үүнийн өсөлтөд айл өрх бүр үнэхээр

туйлдаж байна. Одоо амь амьжиргаа нь өдрөөс өдөрт доройтож байна. Цалин нэмнэ гэхэд баярлахын хажуугаар бол айх зэрэгцэж байна шүү дээ. Яагаад гэхлээр ер нь дагаад юмны үнэ өсдөг. Тэгээд үүндээ авах хариу арга хэмжээ, түүнийгээ дийлэх энэ механизм нь өөрөө хомс байдаг, тэгээд цалин нэмэгдэнэ, дагаад нийгмийн даатгалын шимтгэлүүд нэмэгддэг. Хувь хүн дээр ч тэр аливаа аж ахуйн нэгж дээр ч тэр. Тэгэхээр Сангийн яам, энэ Эдийн засгийн хөгжлийн яам иргэд аж ахуйн нэгжээ дэмжих, тэтгэх энэ өсөлтөө хангах энэ цогц бодлого, арга ажиглагаа, ажлынхаа арга барил дээр бол бас тодорхой бас нэг эргээд харахгүй бол ер нь болохоо байсан ийм л нөхцөл байдал бид нарыг ийм үнэн төрхтэй бид нар байж байна шүү. Энэ дээр дүгнэлт хийх нэн шаардлагатай байна гэж үзэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Нямаагийн Энхболд.

Н.Энхболд: Одоо яг Төрийн байгуулалтын байнгын хороогоор гуравдугаар хэлэлцүүлэг хийсэнтэй холбоотой асуудалд асуулт гарсангүй гэж би ойлгож байна. Энэ одоогийн нөхцөл байдал, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт санаачилж оруулж ирсэн Засгийн газартай холбоотой асуудал. Намын даргын өөрсдийнх нь дарга нарын өөрсдийнх нь байр суурь гэсэн асуултууд гарч байна. Нэгдүгээр хэлэлцүүлгийн үед, хоёрдугаар хэлэлцүүлэг, үзэл баримтлал ярьж байх үед голдуу яригдах ёстой. Тэр үед хариулагдчихсан асуулт л санагдаад байна Өнөрөө гишүүнээ.

Ер нь ер нь бид нар мэдээж бүгдээрээ ойлгож байгаа. Би энийг бүгдээрээ ойлгож байгаа учраас эхний хоёр хэлэлцүүлгээр энэ асуудал дэмжигдээд энэ шатад ирчихсэн гэж бодож байгаа. Юу аль талаас нь вэ гэхээр энэ зөвхөн Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр бид нар бүх зүйлийг сайхан

болгочихно гэж яриагүй, тийм боломж ч байхгүй. Тэгэхээр яг сая Өнөрболор гишүүний, Өнөрөө гишүүний хэлж байгаа шиг намуудын хариуцлага, намуудын манлайллын асуудал, бүүр детальчаад яривал тэр жагсаалтад нь ямар хүмүүс байх юм, тэрийг яаж сонгох юм, буруу сонгосон бол намууд нь мэдээж нэгдүгээрт нийгмийн өмнө хариуцлага хүлээнэ, хоёрдугаарт намуудынхаа өмнө тэр удирдлагууд нь хариуцлага хүлээнэ. Энэнтэй холбоотой намуудын тухай хууль Ерөнхийлөгчөөр өргөн барьсан байгааг бид нар бас энэ болж өгвөл энэ хаврын чуулганаараа эцэслээд батлах ийм талаар ярилцсан байгаа.

Дээр нь Сонгуулийн хууль заавал орж ирэх ёстой. Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хуулиуд заавал орж ирэх ёстой. Энэ саяын ярьсан өнөөдрийн нийгмийн хүндрэлд хүргүүлчхээд байгаа хүчин шалтгаануудыг арилгах хуулиудыг бүгдийг нь багцаар нь баталж байж, багцаар нь хэрэгжүүлж байж бид нар энэ том өөрчлөлт хийх гэж байгаагийнхаа үр дүнг л амсана. Энэ дээр мэдээж таны асуулт тавиад байгаа намын дарга нар, намын удирдах байгууллагуудын манлайлал, үүрэг, намуудын төлөвшилтэй холбоотой асуудал онцгой чухал ач холбогдолтой гэдэгтэй санал бол нэг байна.

Тийм ч байдлаар хоёр дахь, гурав дахь шатад хүртэл хэлэлцүүлэг явж ирсэн. Ийм ойлголтоор. Иргэдэд жишээ нь уулзаад, яриад, тайлбарлаад энэний үзэл баримтлал, агуулга ирээдүйд өнөөдөр хуулиудаа өөрчиллөө гэхэд маргааш бүхэн сайхан болчихгүй нь хэнд ч ойлгомжтой. Ер нь урагшаа харсан хуучин зүйлүүдээ зассан ийм өөрчлөлтүүд хийж байгаа шүү. Бүх юмнууд багцаараа явж байж л хүсэн хүлээсэн үр дүн авчирна гэдгийг ярьж, тайлбарлаж явсан гэдгийг л хэлье дээ. Байнгын хороон дээр ч тэр, урдах хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр ч гэсэн гишүүдээс ийм санал гарч байсан. Энэ хүрээнд л бид нар Байнгын хорооны зүгээс

энэ санал, дүгнэлтээ оруулж байгаа л гэж ойлгож байна.

Г.Занданшатар: Өнөрболор гишүүн маш чухал асуудал хөндлөө л дөө. Энэ ажлын хэсэгт улс төрийн намуудын төлөөллүүд бүгд орсон учраас энэ Үндсэн хуулийн өөрчлөлт маань батлагдлаа гэхэд энэ органик хууль болж, процессын хууль болж тэр Үндсэн хуульд өөрчлөлт оруулж байгаа үзэл санаа бодитой хэрэгжих, цогц Үндсэн хуулийн институтүүд төлөвшиж тогтож байж энэ механизм бодитой үйлчилнэ. Үндсэн хууль батлагдангуут л өөрчлөгдөнгүүт л амьдрал шууд сайхан болчихгүй гэж Нямаагийн Энхболд дарга хэлж байна. Үнэн.

Тийм учраас Улс төрийн намын тухай хууль хэлэлцэж байгаа. Энэ Үндсэн хуулийнхаа агуулгатай нийцүүлж Улс төрийн сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулиар тэр Үндсэн хуульд орсон өөрчлөлт, 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлт дээр дотоод ардчилалтай байна л гэж байгаа юм. Дотоод ардчилалтай байна гэдэг нь нэр дэвшүүлэх хороо, тэр улс төрийн намын төлөвшил, ард түмний төлөөллийн байгууллага, нэр дэвшүүлэх энэ институтийн төлөвшил энэ бүхэн маань Үндсэн хуулийн институтүүд болох улс төрийн намын төлөвшилөөс, сонгуулийн төлөвшилөөс ингээд цогц өөрчлөлтүүд хийгдэх шаардлага юм. Тэгээд цогцоороо өөрчлөлт хийгдэж байж тэгээд энийг ч гэсэн дараа дараагийн хуульдаа Улсын Их Хурал амилуулах, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль дагаад өөрчлөлт орно. Энэ цогц өөрчлөлт маань тэр төлөөллийн байгууллагын ажиллах журамд өөрчлөлт орно. Гишүүд нэг мэргэшсэн парламент ч болохоор асуудал асуудлаараа дагнаж ярьдаг болно гэдэг ч юм уу. Ингээд энэ цогц өөрчлөлтийг үзэл санаагүй л бас ажлын хэсэг юун дээр цаашидаа анхаарч ажиллах ёстой.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Тэгээд энэ дээр ч гэсэн Улс төрийн намын тухай хууль нэн ялангуяа улс төрийн намын шинэчлэлийн асуудлыг Өнөрболор гишүүн хөндөж ярьж байна. Тэгээд Улс төрийн намын 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ч гэсэн ерөөсөө энэ Үндсэн нэр дэвшүүлж байгаа институт, Үндсэн хуулийн институт, ардчиллын гол институт болох улс төрийн намын төлөвшил дотоод ардчилалтай байх, санхүүжилт нь ил тод, нээлттэй, шударга зарчимтай байх энэ бүх зарчимтай уялдаж л энэ цогц өөрчлөлт болж хэрэгжих ёстой гэсэн ийм саналуудыг бас ажлын хэсэг ярьж байгаагаа хэллээ. Энийг бас дараа Үндсэн хуулиа баталсны дараа Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль хэлэлцэхдээ бас энэ асуудлуудыг бас Өнөрболор гишүүн бас энэ ард иргэдийн санал бодлоо тусгаад бодитой болгох талаар нь анхаарах байх гэж бодож байна. Ажлын хэсэг ч гэсэн.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Иргэд сонгогчидтой уулзлаа, саналыг нь сонслоо. Тэгээд иргэд сонгогчдынхоо саналыг бичиж авчраад протоколдоод тэгээд намын бүлэгт, дээр нь Үндсэн хууль хуулийн өөрчлөлтийг хийх ажлын хэсгийнхэнд бас танилцуулсан.

Нэг л зүйлийг иргэд сонгогчид хэлж байгаа юм. Нэгдүгээрт та нар чинь саяхан ирээд л Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг хийчхээд ирлээ. Энэ бол ингээд дордуулсан 7 заалтыг авчихсан. Одоо бид нар 8 жил энд гар хүрэх эрхгүй болсон гээд нэг юм яриад байгаагүй билүү, чи чинь саяхан ирчхээд нэг тийм юм яриад байгаагүй билүү гэж. Дан дээл, давхар дээлийн асуудал яриад л одоо ингээд сайхан болчихлоо, одоо Үндсэн хууль маань, эцэг хууль маань ингээд аятайхан болсон. Бид нарын энэ өмнө байсан алдаа завхралууд засагдана, эвтэйхэн болно гээд яриад байгаагүй билүү. Юу яриад дахиад ингээд зуун тавин хоёр болох гээд яриад

ороод ирэв гэж хэлсэн. Тэгээд зуун тавин хоёрыг бол зөвшөөрөөгүй юм. Тэгээд нэг зүйлийг хэлэхдээ та нар цаашидаа дахиад Үндсэн хуулийг ингээд оролдоод байх уу, эцэг хуулиараа ингээд оролдоод байх уу. Ингээд энэний дараа тэгээд дахиад нэг юм орхичихсон байна, нэг юм гээчихсэн байна, энийг өөрчлөх шаардлага гарлаа гээд унах уу. Ингэхгүй байх баталгаа юу байна гэж асуусан шүү. Үндсэн хуулиараа дахин дахин оролдож байгаад энэ улс орныхоо аюулгүй байдал, тусгаар тогтнол, төрийн тогтолцоогоо та нар эвдчих вий дээ, Үндсэн хуулийн хямрал руу явчих вий дээ. Энийг анхаараарай гэж бүүр онцгой захиж хэлсэн. Энийг надад нэг хариулж өгөөрэй. Дахиад оролдох уу, оролдохгүй юу гэдгийг.

Хоёр дахь асуудал нь та нар нэг тооны бэлгэдэл жоохон яриад байгаа бол тэр далан зургаа гээд жоохон онцгүй тоо байгаад байгаа юм бол тэр улс орноо гэр орон гэж үзэж байгаа бол тэгээд 88 болгооч дээ. Униныхаа бэлгэдлээр гэж. Эсвэл тэнгэр заяатай, тэр газар шүтээнтэй мундаг ард түмэн гэж үзээд ингээд шүтлэгтэй холбоотой юм ярих гээд байгаа бол яг ерэн ес болгооч дээ гэж. Тэрнээс дээш явах гэж байгаа юм бол үндэслэлээ яриарай. Нэлээн сайн яриарай гэсэн. Тэгээд яах вэ ямар ч байсан энэ олныг төлөөлсөн мажоритараар, хувь тэнцүүлсэн пропорциональ тогтолцоог бол тогтолцооных нь хувьд дэмжье. Харин энэ дээрээ бол бас нэлээн сайн ярилцаарай гэсэн. Тэгээд олонхоороо яриад ямар ч байсан зуун хорин зургаа, тэгээд далан найман тойргоос дөчин найм нь одоо жагсаалтаар гэж ингэж явж байх шиг байна.

Тийм учраас энэ дээрээ бол нэлээн сайн анхаарах хэрэгтэй гэдэг юмыг хэлснийг хоёр дахиа би сануулъя.

Гуравдугаарт нь, ингээд жагсаалт нь холимог болон тойргоос ингээд болчихлоо. Нэрсийн жагсаалтаар сонгох юм байна. Тэгээд төлөөлөл оруулах гэж байгаа юм байна. Тийм учраас тэр

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ төлөөллийг, тэр улсын сайн малчин Намхайнямбуу шиг тийм мундаг малчин Их Хуралд орж суух гээд байгаа юм бол тэр төлөөллөө, тэр эрдэмтэн мэргэдийнхээ төлөөллийг, тэр инженер техникийнхээ мундаг хүмүүсийн төлөөллийг, тэр гадаад дахь Монгол иргэдийнхээ төлөөллийг жагсаалтынхаа эхэнд бичээрэй. Улс төрчдөө ард нь бичээрэй та нар гэж хэлсэн шүү. Энэ бол яах вэ гэхээр зэрэг энэ дагалдаж гарах гэж байгаа энэ Үндсэн хуулийг дагалдаж гарах Сонгуулийн хууль болон бусад хуульд нийцүүлэхдээ та нар бол энийг анхаараарай, нам дугуйлахгүй шүү гэж хэлсэн. Яагаад нам дугуйлахгүй вэ гэхээр зэрэг намын ард ингээд улс орноо тонон дээрэмдсэн тэр тонуулчид чинь нуугдаад ороод ирдэг. Ичих ч үгүй ороод ирдэг. Тийм учраас наадах чинь бол энэ дээр бол нам дугуйлахгүй, хүн дугуйлна шүү гэдэг асуудлыг Сонгуулийнхаа хуульд та нар нэлээн анхаараарай гэж хэлснийг би бас энд та бүхэнд хэлэх нь зүйтэй гэж ингэж бодож байна. Ийм хоёр л асуудал байгаа юм.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч хариулна.

Н.Энхболд: Үндсэн хуулиар дахиад оролдох уу, үгүй юү гэдэг асуудал нэгдүгээрт хаана ч сэдэв болж энэ өөрчлөлтийг хэлэлцэх явцад яригдаагүй. Тийм болохоор Байнгын хорооны юм уу, ажлын хэсгийн өмнөөс биеэ дангаараа хариулах боломж надад байхгүй. Зүгээр хувь хүнийхээ байр сууриас саналаа хэлэхэд энэ дахиад ойрхон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай яригдахгүй байх гэж бодож байна. Хамгийн нэгдүгээрт нийгмийн уур амьсгал ямар байгаа билээ. Энийг бид нар бодох хэрэгтэй.

Хоёрт, энэ өөрчлөлтүүдийг хийгээд авбал нэг хэсэгтээ энэний яг энэнийх энэ чинь үр дүнг нь заавал харах

ёстой шүү дээ. Тэгж байж ярина уу гэхээс ойрхон ойрхон дахиад өөрчлөөд байх боломж байхгүй гэж би бол хувьдаа харж байгаа. Энэ удаа яагаад ингээд яачхав гэхээр 22 онд дөнгөж хамгийн сүүлийн юм хийчхээд яаж байна гэхээр би түрүүчийнхээ л хариуг хэлье дээ. Энэ ганц миний ч хариу биш Засгийн газраас хууль боловсруулж орохдоо ч энийг ярьсан байх. ер нь бас гишүүд ч хэлэлцүүлгийн явцад бас тийм шүү гэж бодолцож нэг, хоёрдугаар хэлэлцүүлгээр цаашидаа үргэлжлүүлээд явахыг нь дэмжсэн гэж ойлгоод байгаа. Тогтолцооны өөрчлөлийн асуулт, тогтолцооны өөрчлөлт ярихаар тоотой заавал уялдаж таараад байгаа юм. Логик талаасаа ч гэсэн.

Тэгээд 19 онд нэмэлт, өөрчлөлт оруулахад яваад хэлэлцэгдээд зөвхөн 19 онд ч биш 8 оноос эхлээд л ажлын хэсэг гараад л хэд хэдэн удаа Улсын Их Хурал удаа дараагийн Их Хурлууд дээр ажлын хэсэг гараад хэлэлцэж байсан зүйлүүдээс үндсэндээ хамгийн том үлдсэн зүйл нь бол энэ асуудал байсан учраас энэ нөхцөл байдлын байгаа дээр үүнийгээ нэг өөрчлөөд авах нь зүйтэй гэж үзэж, Засгийн газрын зүгээс боловсруулж оруулж ирсэн гэж бодож байгаа.

Одоо ингээд энэ өөрчлөлт батлагдаад явбал дахиад жишээ нь Улсын Их Хуралд ийм том хэмжээгээр аль нэгэн ялалт байгуулах дангаараа санаачлах хэмжээний тийм бололцоотой тоогоор бүлэг бий болох гэх мэтчилэн боломжууд ховор байх болов уу. Эрсдэлтэй. Тэгэхдээ эрсдэл нэг намын нэг удаа энэ сонгуулийн үр дүн гэхээсээ илүү ирээдүйг харсан шинэ үеийнхний хүсэл эрмэлзлийг илүү тулгасан нийгэмд гараад байгаа асуудлуудад хариу өгөх гэсэн энэ том өөрчлөлтүүдийг нэг гүйцээгээд авъя гэсэн үүднээс л энийг боловсруулж оруулж ирсэн гэж би бол тэгж ойлгож байгаа. Гишүүд маань ч тэгж ойлгож эхнээсээ хоёр хэлэлцүүлэг явчхаад бид энэ шатад ирчихсэн явж байгаа гэж бодож байна. Нэгдүгээрх дахиад оролдох уу гэдгийн хувьд бол.

Үнэхээр намуудын хариуцлага л энд дараагийн шатад бол маш том асуудал. Намуудын хариуцлага, намуудын төлөвшил, улс төрийн соёл энэ өөрчлөлт батлагдвал тэрийг хэрэгжүүлэх, амьдралд үр дүнг нь харах гол баталгаа бол энэ намуудын төлөвшлийн асуудал, хариуцлагын асуудал гэж л ингэж харж байгаа шүү дээ.

Г.Занданишатар: Ер нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэгдэж байгаа бөгөөд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар 8 жилийн хугацаанд ахиж хөндөхгүй гэсэн заалт хэвээрээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Сая бас зарим заалтууд орохоор яриад шийдэгдсэн. Түрүүн бас олон удаа орууллаа, өнгөрсөн 8 сард Үндсэн хуульд дахиад өөрчлөлт оруулчихсан юм шиг асуудлууд зарим гишүүд хөндсөн. Энэ бол Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2009, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тодорхой заалтыг Үндсэн хуулийн цэц хүчингүй болгоод дээд суудлаараа. Ингээд хүчингүй болсон 19-нд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг буюу хүмүүсийн энэ нэрлэж занисанаар давхар дээлтэй холбоотой заалтыг Үндсэн хуулийн цэц хүчингүй болгосон шүү дээ. Түүнээс биш 8 жил дотор хөндөөгүй заалттай Улсын Их Хурал өөрөө хөндөөд, дахиад санаачлаад хөндсөн зүйл байхгүй гэдгийг тодруулж хэлмээр байгаа юм. Ингээд Үндсэн хуулийн цэцээс 19 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хүчингүйд тооцоод, тэгээд тэрний дагуу давхар дээлтэй холбоотой заалт хүчингүй болсон. Энэ нь ч өнөөдрийн өөрчлөлтийг хэлэлцэх нэг үндэслэл шалтгаан болж байгаа.

Яагаад гэхээр тухайн үед Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын нийт гишүүдээс 4 гишүүн л байж болно гэдэг нь гишүүдийн тоотойгоо уялдаад нийт 76 гишүүний 39-өөр олонх болно. Нийт гишүүний олонх болно, засаг барина. Олонхын олонх нь Засгийн газрын

гишүүн болчих эрсдэл үүсээд байгаа учраас, Үндсэн хуулийн хяналт тэнцлийн зарчим алдагдаад байгаа учраас энэ давхар дээл гэж нэршсэн буюу Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр давхар ажиллах асуудлыг хориглох, хязгаарлах шаардлага үүссэн.

Өмнө ч гэсэн тийм зарчим мөрдөгдөж байсан. Энэ заалтыг бол олон улсад байдаг Үндсэн хуулийн эрх мэдлийн уусал буюу Улсын Их Хурал Засгийн газрын эрх мэдэл бол харилцан уусааж болох юм байна гэсэн ийм шалтгаанаар Цэц дүгнэлт гаргаад хүчингүй болгочихсон дээд суудлаараа.

Тийм учраас үүнийг бол бас манай ард иргэд ч гэсэн, гишүүд ч гэсэн ялгаж, салгаж тодорхойлбол зүгээр байгаа юм. Дахин дахин хөндлөө гэж яриад байгаа энэ асуудал бол үндэслэлгүй гэдгийг.

Цэцийн эцсийн шийдвэрийг бол Улсын Их Хурал авч хэлэлцэх эрхгүй байдаг. Тэгээд л хүчингүй болдог ийм л заалтаар явсан. Энэ маань ч гэсэн өнөөдөр энэ давхар дээлтэй холбогдуулаад тоо нэмэгдүүлэх зайлиггүй шаардлага Улсын Их Хурал Засгийн газартаа хяналт тавихын тулд тоо нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байгаа гэдгийг бас хэлмээр байна.

Ингээд Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлаар бид нар хоёр ч удаа орон нутагт ажиллаж, санал сонссон. Иргэдийн зүгээс бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудалд бас болгоомжилж байгаа юм. Ер нь тооноос бол чанар их чухал гэдэг, сэтгэлтэй, зүтгэлтэй хүн байвал бас тоо ч нэг их чухал биш гэдэг гэсэн ийм асуудлууд маш их яригдаж байгаа юм.

Хоёр дахь асуудал нь тэр жагсаалтад орчих юм бол манай гишүүдийн ч яриад байгаа тэр итгэл

даахгүй, сэтгэлгүй гэдэг нь бас танигдсан нөхдүүд жагсаалтад ороод ирэх юм биш биз дээ гэдэг асуудлыг нэлээн их яриад байгаа юм. Энэ намуудын босгыг бас жаахан өндөрсгөх ёстой шүү. Ер нь бол 5-6 хувьтай намуудын босгыг байлгах ёстой байдаг гэсэн ийм зүйлүүд яриад байгаа юм. Энийг бол тэр Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намуудын тухай хуулиудаа бид нар ер нь бодож үзэх юм уу нэлээн бас анхаармаар юмнуудыг нь яриад байх юм.

Хоёр асуудал байгаа юм. Хөдөөгийн иргэдтэй ер нь уулзаж явахад хоёр юмыг нэлээн их ярьж байна. Тийм учраас энэ дээр Их Хурал зориуд анхаарч, тодорхой бодлого боловсруулж, Засгийн газар байх юм уу, Их Хурал нь байх юм уу. Бодлого боловсруулж тодорхой шийдвэр гаргаж онцгой анхаарах хоёр асуудал байна.

Нэг дэх асуудал нь ерөөсөө энэ хөдөөгийн хөгжлийн бодлого гэдэг асуудлыг бид нар нэг жичид нь тодорхой бодлого болгож Их Хурал дээр ярьж, Их Хурлаас нь тодорхой шийдвэр гаргах шаардлагатай байна. Хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч байгаа иргэдийн орлого чинь статистикийн мэдээ эд нар харахаар хөдөөгийн иргэдийн амьжиргааны түвшин, орлого бол 16 орчим хувиар буурчихсан гэсэн ийм судалгаа гараад байна шүү дээ. Хөдөөгийн иргэдтэй уулзахлаар энэ хөдөөгийн хөгжлийн бодлоготой холбоотой асуудал Их Хурлаас, Засгийн газраас ямар бодлого явуулж байгаа юм бэ. Ер нь хот хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах талаар юу авах юм. Хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч буй иргэд төв суурин газрын иргэдээс дутахгүй ижил түвшинд ажиллаж, амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлж өгөх асуудлууд, хөдөөгийн иргэдийн дунд ажилгүйдэл, орлогын ялгаа маш их өндөр байна. Хөдөөгийн иргэдийг ажлын байраар хангах, тогтмол орлоготой болгох асуудлууд, хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч буй төрийн албан хаагчдыг ажиллаж, амьдрах ижил

тэгш нөхцөл, бололцоогоор хангах, ядаж л хөдөө орон нутагт энэ төрийн албан хаагчдын орон сууцын хангамжийг хүртээмжийг яаж нэмэгдүүлэх вэ гэдэг нэг бодлого бас гаргамаар л байх юм. Бид чинь ипотекийн зээлтэй төрийн албан хаагчдыг хамруулна гээд байдаг. Тэгээд хамрахлаар хөдөө суманд чинь дэд бүтэц байхгүй, хөдөө орон нутаг чинь ипотекийн зээлд хамрах орон сууц баригддаггүй, хөдөө ажиллаж, амьдарч буй төрийн албан хаагчид ер нь иргэд ипотекийн зээлд хамрагдах гэхлээр эсвэл Улаанбаатар хотод орон сууц авдаг, эсвэл аймгийн төвд орон сууц авдаг тэгээд хаана орон сууцтай болсон тэр газрын иргэн чинь ажиллаж, амьдрах нөхцөл ингээд ийм эрхтэй явчихдаг. Үүнээс чинь болоод энэ төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөн чинь асар их байна.

Тийм учраас хөдөө орон нутгийн энэ хөгжлийн бодлогын асуудлыг Засгийн газар, Их Хурал анхааралдаа авч ойрын хугацаанд ер нь хөдөөгийн хөгжлийн бодлогын асуудлыг жич нэг ярьж тодорхой бодлого шийдвэр бол гаргамаар байна. Ядаж хөдөө сумдад энэ ипотекийн зээлийн орон сууц ордоггүй юм бол төрийн албан хаагчдын орон сууцтай болох асуудлыг шийдэх, эсвэл энэ түрээсийн орон сууцын асуудлыг бас шийдэх эд нар гээд ийм асуудлыг шийдмээр бол байна.

Ядаж хөдөөгийн сумуудыг бүгдийг нь инженерийн хийцтэй цэвэрлэх байгууламжтай болгох. Төв суурин газрын иргэдээс дутахгүй нөхцөлд ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нь бүрдүүлэх гээд ингээд асар их олон асуудлыг хөдөөгийн иргэд яриад байгаа юм. Байнга яриад байгаа юм.

Тийм учраас бол зориуд Их Хурал анхаарал хандуулж, энэ хөдөөгийн хөгжлийн бодлогын асуудлаа тодорхой бодлого боловсруулж гаргаж, хэрэгжүүлж цаашид шаардлагатай байгаа асуудал.

Хоёр дахь асуудал нь хөдөө нүүдлийн мал аж ахуйн малладаг манай энэ хөдөө орон нутагт сүүлийн миний мэдэх л манай Өвөрхангай аймагт 17 оноос хойш ер нь олигтой зун болсонгүй. Цаг хатуурахаар хэдэн малчид маань малаа туугаад л энэ гаднын аймаг, сумууд отор нүүдэл хийдэг. Үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг л тал тал тийшээ нүүгээд явдаг. Очсон газраа тав тухтай өвөлжиж, хаварждаггүй, хөөгдөж туугддаг асар хүнд нөхцөлд энэ мал аж ахуйн үйлдвэр бол явж байна шүү дээ. Одоо бидний ярьдгаар энэ хаяа багадвал бууж, хамар хатгавал иднэ гэдэг зарчмаар чинь энэ нүүдлийн мал аж ахуйн үйлдвэр явах ямар ч аргагүй болчихлоо.

Тийм учраас Их Хурлаас, Засгийн газраас ойрмогхон энэ мал аж ахуйн талаар баримтлах хөгжлийн бодлогын асуудлыг жичид нь авч үзэж, тодорхой бодлого шийдвэр гаргахгүй бол энэ нар, салхинд хамгийн их гандаж, элээгдэж явдаг малчдын маань амьдрал маш хүнд байна. Яаж орон нутагт энэ мал аж ахуйн бодлогыг явуулах юм, яаж энэ үүлдэр угсааг нь сайжруулах юм. Орон нутгуудад яаж энэ мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг боловсруулдаг ядаж анхан шатын боловсруулалт хийдэг үйлдвэр, цехүүдтэй болгох юм. Яаж орон нутгуудыг мал аж ахуйн шаардлагатай байгаа тэжээлийн ургамал тариалах нөхцөл, боломжийг нь бүрдүүлэх юм. Энэ малчдын орлогыг яаж тогтмол орлоготой болгох вэ гээд асар их асуудлууд хүлээгдэж байна.

Тэгэхгүй бол би саяхан манай Төгрөг сумын улсын аварга малчин Баяраа гээд хүнтэй таарсан. Олон жил ган, зудад нэрвэгдэж, отор нүүдэл хийж явлаа. Үнэхээр Чинзориг минь энэ мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж амьдарна гэдэг бол хаширмаар байна шүү. Хэдэн малаа зараад аймгийн төв барааддаг юм уу гэж ярьж явлаа. Надад хэлэх үг олдохгүй. Хэдэн малаа зараад аймгийн төв орвол та тэгээд л нэгэнт гулрахын л шинж дээ л

гэж хэлэхээс өөр хэлэх өөр үг олдохгүй шүү дээ.

Тийм учраас бол цаашидаа энэ мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаар баримтлах энэ хөгжлийн бодлогын асуудлыг Их Хурал дээр тодорхой бодлого болгож ярьж, тодорхой бодлого шийдвэр гаргаж энэ үед мал аж ахуйн эрхэлж буй малчдынхаа амьдрал ахуйг өөд татах, дээшлүүлэх асуудал яримаар байх юм. Хөдөөгийн иргэдтэй уулзаж ярихад нэг асуудал малчдын залгамж халаа, залуу малчдыг бэлтгэх ямар бодлого явуулж байгаа юм бэ? Хөдөө чинь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг залуу малчид олдохгүй байна. Хөдөө орон нутагт мал маллаж байгаа энэ хамгийн залуу малчид бараг л ч 40 настай хүнийг л бид нар хамгийн залуу малчин гэж ярьж байна шүү дээ гээд. Тэгээд энэ Боловсролын хууль бид ярьж байгаа энэ Боловсролын хуулийг ч гэсэн бид нар эргээж харах юм уу, яах юм.

Ер нь ингээд хүүхэд болгоныг 12 жилийн боловсролтой болгох юм бол 12 жилийн боловсролтой болсон хүүхэд бол хөдөө гарна, мал маллана гэдэг асуудал бол байхгүй л юм шиг л байгаа юм. Энийг хүртэл манай хөдөөгийн иргэд малчид яриад байна шүү дээ.

Тийм учраас Их Хурлын дарга энэ хөдөөгийн хөгжлийн бодлогын бодлогын асуудал, энэ мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого боловсруулж ойрын хугацаанд Их Хурал дээр ярьж, тодорхой бас шийдвэр гаргаж, хэрэглэгчийг нь хангах талаар ажиллахгүй бол энэ хөдөө орон нутгийн иргэдийн аж амьдрал, мал аж ахуй эрхэлж амьдралаа авч явж байгаа малчдын амьдрал маш хүнд байна. Энэ байгаль, цаг агаар ч гэсэн үнэхээр бас хатуурхаж байна шүү дээ. Манай Өвөрхангай аймагт л гэхэд 17 оноос хойш дараалан 6 жил олигтой зун болоогүй. Энэ малчид чинь дандаа мянгаас хоёр мянган өрх жил болгон л гаднын аймагт алсын отор нүүдэлд хөөгдөж, туугдаж

маш зутруу нөхцөл байдалд өвөлжиж, хаваржиж байна.

Тийм учраас энэ хөдөө, хөдөөгийн хөгжлийн бодлогын асуудал мал аж ахуйн үйлдвэрлэлийн бодлогын асуудлыг Их Хурлын анхааралтай хандуулж, хөдөөгийн иргэдийг ижил тэгш нөхцөлд ажиллаж амьдрах, малчдыг мал аж ахуйн үйлдвэрлэлийг нь бас хөгжүүлэх, үүлдэр угсааг нь сайжруулах, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлээр тодорхой бодлого, шийдвэр гаргаж, хөдөөгийн иргэдийн амьдралын түвшнийг сайжруулах Их Хурал зориуд бодлого гаргаж хийхгүй бол энэ үнэхээр хүнд байна. .../минут дуусав./

Г.Занданшатар: *Ажлын хэсгийн ахлагч Нямаагийн Энхболд дарга хариулна.*

Н.Энхболд: *Сая Чинзориг гишүүн бол дандаа санал хэллээ шүү дээ даргаа. Тэр тусмаа манай яг гуравдугаар хэлэлцүүлгээр оруулаад ирсэн зарчмын зөрүүтэй санал, яаж тийм санал төрөв гэх мэтчилэн асуудал асуусангүй. Саналуудаа хэллээ гэж бодож байна.*

Г.Занданшатар: *Саналууд хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн.*

Ц.Туваан: *Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол дэмжиж байгаа. Хууль тогтоомж байгаа. Тэгэхдээ бид хэд аливаа бүх зүйл сайжрах, сайн тал руугаа явах ёстой гэж ингэж бодож дэмжиж байгаа. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлаар бид хэд ноднин бас энэ ард түмний дунд давхар дээл гэж ярьдаг энэ өөрчлөлтийг хийхийн өмнө бас танилцуулаад явсан.*

Энэ жил Зөвлөлдөх санал асуулгын зөвлөмжийг танилцуулаад явсан. Дахиад хоёр удаа ард түмэнтэйгээ уулзлаа. Ингээд нийтдээ 4 очлоо. Ер нь бол эндээс нэг юм харахад ард иргэд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд бас их тийм буруу, зөрүү гээд байгаа юм бол миний

хувьд бол байхгүй гэж бодож байна. Юунд бухимдаад байна гэхлээр энэ ард түмний амьдралд ядуураад байна, үнэ өсөлттэй байна, орлого нь багасаад байна энэ бухимдлаа л яг энэ гаргаж ирж тавьчихаж байгаа асуудал өөрсдийнхөө сонгосон гишүүдийг очиход гаргаж тавиад байна.

Тэгэхээр энэ асуудал бол ийм байдалтай байна. Би бол тэгж харж байгаа юм. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид нар өмнө нь хэлэлцүүлгээрээ зуун хорин зургаа болгосон. Ер нь бол зарим хүмүүс энэ Ардчилсан нам л энийг бараг өсгөөд зуун хорин зургаа болгочихсон юм шиг ийм юм ярьж байна. Тэгэхээр бол Ардчилсан нам бол энэ 60, 40-ийн харьцаагаар өсгөнө гэдэг юун дээр бол байгаа. Үгэндээ сууна. Зуун тавин хоёр гэж ярьж байсныгаа бол бас бодох л ёстой шүү гэдгийг энэ таширамд хэлье.

Тэгээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс бол тогтолцооны өөрчлөлт хийгдэнэ, энэ маш том өөрчлөлт хийгдэнэ гэж харж байгаа. Том хүлээлттэй байгаа. Ийм өөрчлөлт гарсны ар дээр бас том дэвшилийг бид нар бол эндээс хүлээж байгаа гэдгийг бас хэлмээр байна. Ард түмэн ч гэсэн ийм бодолтой байгаа. Харин энэний ар дээр муужруулж, муутгаж асуудал нэмэгдэх юм бол нөгөө олон хулгайчаар нэрлээд байгаа хүмүүсийн чинь тоо нэмэгдэж байгаа асуудал учраас энийг намууд, Ардчилсан нам, Монгол Ардын нам гэлтгүй хаа хаанаа бүгдээрээ л сайн анхаарах ёстой шүү гэдгийг иргэд хэлж байна лээ.

Ер нь бол энэ 3, 4-хөн сая хүнтэй ийм баян орны ард иргэдийг нэг сайхан амьдруулчихвал амархан шүү дээ. Энэ бол маш амархан. Хулгай хийхээ болиод, системийн авлигаа задлаад ингээд энэ авлигын тогтолцоо гэдэг юм пирамидыг нь нураагаад хаячихад л энэ болох юм байгаа шүү дээ. Нэг том баталгаа нь бол сая энэ нүүрсний Түр хороо ажиллаад энэ төсвийн орлого 1 их наядаар давж биелж

байна шүү дээ. *Маш богино хугацаанд. Тэгээд энэ төсвийн орлого давж биелсний буянаар бид нар энэ өнөөдөр төсвийн тодотгол хийгээд энэ цалин, тэтгэвэр, хүүхдийн мөнгөө нэмэх гээд л сууж байна шүү дээ. Яг л үүн шиг ийм эерэг өөрчлөлт гарна гэж ингэж энэ дээр бол өөдрөгөөр харж байгаа.*

Энэ холимог тогтолцоог бол Ардчилсан нам анхнаасаа ер нь дэмжиж ирсэн. Ийм байх ёстой. Яагаад вэ гэхлээр энэ санал гээгдэхгүй. Тэр иргэдийн өгсөн санал тодорхой хэмжээгээр ямар нэгэн байдлаар тусаж байх ёстой гэж. Тэр хүн дээр байна уу, нам дээр байна уу гэдэг нь сонин биш. Тэгэхдээ энэ тусаж байх ёстой.

Харин үүнийг өмнөх шигээ бид нар буруугаар ашиглаж болохгүй. Ялангуяа намын удирдлага, удирдах зөвлөлүүд. Тэр яриад байгаа энэ мэргэжлийн улсуудаа оруулж ир, мэргэжлийн хуульчдаа оруулж ир, малчдын төлөөллийг бүүр санал асууж байгаад оруулж ир, тариаланч, ногоочдын төлөөллийг оруулж ир, багш эмч нарын төлөөлөл, бүүр хөгжлийн бэрхиээлтэй, тусгай хэрэгцээтэй иргэдийн төлөөллийг заавал нэг нэгийг оруулж ир. Энэ амлалтдаа харин намууд хүрэхгүй тэр хулгайч, луйварчин муу нэртэй хүмүүсээ листэд нь чихээд ороод ирвэл ард түмэн битгий тэнд нь саналаа өг.

Ерөөсөө л амархан шүү дээ. Одоо бол манай иргэд, бас сонгогчид нэлээн хэрсүүжиж байгаа. Тэгэхээр ийм байдлаар бол хандаарай гэж бас хэлмээр байна. Тэр иргэдийн бухимдлууд чинь ерөөсөө тоотой хэдхэн юм байна. Бид нар төсөв баталж байхад мөн ч олон удаа хэлсэн дээ энэ хүүхдийн мөнгөөр битгий оролд оо Үндсэн хуулийн зөрчил шүү, хүүхдээ алагчилж болохгүй л гээд байсан. Тэгээд яалаа 91, 9 гээд л ялгаварлаад л хаясан. Одоо яав? Очоод ярьж байгаа хүмүүс чинь ихэнх нь хүүхдийн мөнгийг яагаад ингэж гэж ярьж байгаа юм.

Дээрээс нь та хэд, одоо эрх баригчид энэ Засгийн газар хүүхдийн мөнгөний тэр буруу шийдвэрээс болж орхигдсон хүүхдүүдийн мөнгийг нөхөж олгох хэрэгтэй. Яг ийм орон гаран шийдвэр гаргаад байгаа дээр чинь л ард иргэд бас нэлээн бухимдаад байгаа байхгүй юу.

Тэтгэврийг нэмэгдүүлэх бол зайлшгүй шаардлага үүсчихсэн. Яагаад гэхээр тэтгэврийн манай ахмадууд маань бөөн бөөнөөрөө ядуучуудын арми руу алхаад орж байна. Одоо энэ хэддээ жсоохон нэмэгдэл өгөхгүй бол болохгүй. Тэд нарыг маш их бухимдуулдаг хоёр дахь асуудал бол энэ тэтгэврийн зөрүү арилгахгүй явчихсан асуудал шүү дээ. Тэтгэврийн индексийг 2011 оноос хойш ашиглаагүй яваад ирчихсэн. Шударга бус байдалд Монголчууд дургүй. Энэ дээр нэлээн бухимдаад байгаа. Тэгэхээр энийг бас энэ удахгүй орж ирэхдээ төсвийн тодотгол дээр энэ тэтгэврийн зөрүү арилгах талд том алхам хийгээрэй гэдгийг хэлье.

Цалинг бол нэмэгдүүлэхээс өөр дахиад арга байхгүй. Тэгэхдээ энэ дээр хэн аль нутгийн, ямар сайд, ямар яамыг толгойлж байгаагаас болоод энэ төрийн албан хаагчид чинь ялгамжтай, алагчлалтай цалинтай байгаад байна шүү дээ. Яахаараа адилхан төрийн алба хийж байгаа энэ соёл урлаг, биеийн тамирынхан бага цалин аваад тэгээд тэр дотор эмч нар дундаж, багш нар нэлээн дээгүүр гэдэг шиг ийм ялгаварласан байдлаар хандаад байгаа юм. Ялгаагүй л төрийн алба хийж, хашиж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ цалингийн ялгамжтай байдал гэдэг юмаа бас зохицуулж, тэгшитгэх энэ шударга бус байх ийм юмнуудыг нь бол зохицуулж оруулж ирэх ёстой. Тухайн мэргэжлийн биш хүмүүс өөрөөр хэлбэл, эмнэлэгт ажиллаж байгаа нярав, нягтлангууд, төрийн үйлчилгээний ажилтнууд, боловсролын байгууллагад ажиллаж байгаа тэр сургалтын менежер,

нийгмийн ажилтнууд энэ хүмүүс чинь багш биш, эмч биш гээд ингээд хаягдаад байдаг. ТУ-хэн бас хаягдаад байдаг энэ байдлуудаа бол энэ цалингийн нэмэгдэл дээрээ бол ярих ёстой шүү гэдгийг хэлмээр байна.

Хөдөө орон нутагт явсан энэ малчид дээр бол маш их асуудал яригдаж байна. Тэр нь юу вэ гэхлээр бухимдал ерөөсөө л энэ орлоготой нь л холбоотой байна. Сая энэ Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийг хамарсан байгалийн гамшиг болсон энэ дунд Сүхбаатар аймагчид Мөнххаан, Асгат, Халзан сумууд бол маш ихээр өртсөн. Энэ дээр бол Засгийн газар онцгой арга хэмжээ авах ёстой.

Тэгэхээр энэ хүмүүсийг бол бид нар муулдаг шүү дээ. Мянгат болоод мянган малтай гээд. Энэ хүмүүс өөрсдөө бүтээсэн мах, түүхий эдээ үүрээд Эрэн орох юм уу? Үүнийг чинь цааш нь дамжуулж боловсруулах, борлуулах үйл ажиллагааг нь хийх ёстой төр ажлаа хийх ёстой шүү дээ. Тэр арьс ширний үйлдвэрийг нь зохицуулж өг, тэр гадаад худалдаа хийх платформыг нь гаргаж өг, Эдийн засаг, хөгжлийн яам харин энэ дээр нэг энэ гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын агентлаг хийж байх шиг байна. Энэ бол тэр малчдын бэлдэж өгсөн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг гадагшаа борлуулах дээр бол онцгой анхаараарай. Энэ бол төрийн буруу шүү.

Сая малчдын бодлого дээр энэ Чинзориг сайд ярьчихлаа. Энэ дээр хэлэхэд энэ хөдөө орон нутагт залуу малчдын асуудал маш хүнд байна шүү. Эхнэргүй, залуу эрэгтэй малчдын арми үүссэн байна. Энэ дээр яах юм. Төр одоо бодлого л гаргахгүй бол эд нар чинь малынхаа араас явж байна. Маш олон хүн гэр бүлгүйгээр ганцаараа ингээд маллаад ингээд сууж байна. Одоо ер нь бол залуу малчид хөдөө орон нутагт тогтоож байгаа юм энэ морь уях, морины уяан дээр л ер нь тогтоож байна шүү. Өөр тэд

нарыг бол тогтоож байгаа юм үнэндээ алга байна. Тэгэхээр төрийн.../минут дуусав./

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга хариулъя. Санал хэлсэн юм уу. Асуулт байхгүй юу. Тойрогтоо яваад ирсэн болохоор тэгээд гишүүд бас.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Бид нар өнөөдөр бол маш чухал асуудлыг бол хэлэлцэж байна. Тогтохсүрэн дарга жоохон аяархан. Бид нар өнөөдөр энэ парламент бол маш чухал асуудлыг хэлэлцэж байна. Тэгээд эерэг үр дүн нь үнэхээр гарвал жишээ нь 4, 5 жилийн дараагаас бодитоор мэдрэгдэх учиртай. Ялангуяа энэ тогтолцооны өөрчлөлт нь өөрөө өнөөдөр улс оронд үүсээд байгаа энэ эдийн засгийн, нийгмийн, геополитикийн гадаад нөхцөл байдал энэ тэрд тулгарч байгаа энэ асуудлыг бид зөвөөр шийдэж, хольг харсан ийм шийдвэр болж чадвал ёстой 20-24 оны энэ парламент түүхэнд бол бичигдэх учиртай.

Тэгээд бид нар сая иргэдтэйгээ хоёр ч удаа уулзлаа. Тэгээд манай Чингэлтэй дүүргийн иргэдийн хувьд ингээд энэ уулзалтуудаас харж байхад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт үнэхээр зайлшгүй гэж үзэж байгаа бол та бүхэн ч шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тэр ажлаа өөрсдөө хийж болно.

Харин гишүүдийн тоог ингэж том зуун тавин хоёр энэ тэр гэж нэмэх нь бол буруу гэсэн байр суурь дийлэнх нь байсан. Тийм ч учраас бид нар бас сая хэлэлцээд ингээд нам намууд хоорондоо ярьж байж зуун хорин зургаа дээр тогтоож байна л даа. Тэгэхээр хамгийн гол нь тоондоо биш, чанартаа, сонгосон хүндээ байгаа гэдгийг бол иргэд бүгд ярьж байна.

Тийм ч учраас өнөөдрийн энэ парламентын ардчиллын сүүлийн 30 жилийн энэ улс төрийн бохирдсон энэ байдлыг л засах нь бид нарт чухал байгаад

байна шүү дээ. Дэндүү авлигал, хээл хахуульд автсан эсвэл сайдын суудлыг энэ парламентын танхимыг бизнесээ өргөжүүлэх гэдэг юм уу эсвэл хувийн эрх ашгаа илүү харж, энд сонирхож орж ирдэг явдлууд өнөөдөр энэ тогтолцоог өөрчилснөөр гишүүдийг илүү хариуцлагатай болгосноор өөрчлөгдөх байх гэж би харж байгаа.

Тийм учраас энд харин яах вэ гэхээр одоо хэлэлцэх Улс төрийн намын тухай хууль дээр намууд энэ гишүүд маань маш хариуцлагатай хандах ёстой. Одоо жагсаалтаар орж ирж байгаа энэ нэрс нь ямар байна вэ гэхээс тухайн намын яг энэ нам өөрөө ямар нам бэ гэдгийг л шууд харчих ийм бодит байдал үүснэ гэж би бодож байна л даа.

Өнөөдөр иргэд тэгж байна шүү дээ. Яах вэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөс илүүтэй өнөөдөр миний амьдралд тулгарч байгаа энэ санхүүгийн асуудал, өрхийн орлогын асуудал, ажлын байрны асуудал, эрүүл мэндийн асуудлыг та нар маань шийдээч. Үндсэн хууль өөрчлөгдчихөөр энэ бүх юм өөрчлөгдчих юм уу, үгүй юү гэж асууж байна л даа.

Тийм ч учраас гишүүд сая тойрогтоо ажиллаж ирээд өчигдөр Монгол Ардын намын бүлгийн хурал дээр бид өөрчлөлт хийнэ. Гэхдээ иргэдийнхээ амьдралыг, ялангуяа цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжээ нэмэх, энэ хүүхдийн мөнгийг ялгаатай олгодог явдал бол байж болохгүй. Энийгээ засах ажлыг эхлээд бид хийх ёстой гэсэн байр сууриа гишүүд, би өөрөө жишээ нь хувь гишүүний хувьд хатуу илэрхийлсэн.

Тийм ч учраас бүлэг олонхынхоо шийдвэрээр төсвийн тодотгол хийж 7 сарын 1-нээс энэ цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөний зөрүүг олгох, нөхөж олгох тухай асуудлуудыг ингээд шийдэж байна л даа. Тэгэхдээ энэ бол хангалттай биш байгаа юм. Өнөөдөр энэ үнэ ханшийн өсөлт 60-70 хувьтай болчихоод байна шүү дээ. 60-70 хувь.

Тэгсэн хэр нь цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, өрхийн орлого бодитоор ямар ч нэмэгдсэн зүйл байхгүй болох нь иргэд, ер нь хэн хэнгүй бухимдаж байна л даа. Тэгэхээс ч аргагүй шүү дээ.

Тэгэхээр бид нар үнэхээр энэ ард иргэдээ бодохгүй байж ийм асуудлуудыг шийдэх гээд явахаар иргэд бухимдалтай байх нь зүйн хэрэг. Худалдан авах чадваргүй байна, яаж ажлын байр хомс байна, хөдөлмөрийн зах зээл нь унтаа байдалтай байгаад байна шүү дээ. Тэгээд энэ нь юу юм гэхээр нөгөө сэтгэлгүй дарга, сайд нарын л асуудал гэж би бол харж байгаа. Уг нь шийдвэрлэх ёстой. Парламентыг нэг талаасаа энэ далан зургааг зуун хорин зургаа болгоод тогтолцоог холимог тогтолцоо болгоод орж ирснээрээ парламентын төлөөлөх чадварыг илүү сайжруулна гэж ярьж байгаа. Энэ нэг талаасаа маш зөв гэж би бодож байна.

Нөгөө талаасаа парламент гэдэг чинь ард түмний төлөөлөл, хаана эрх мэдэл төвлөрсөн тэр засгийн газраа хянаж чаддаг энэ чадвар ард түмнийхээ төлөөлөх үүргээ ухамсарлаж чаддаг тийм хүмүүс нь өөрөө парламентад байж байж харин засгийн газраа хүчтэй ажиллуулж чадна шүү дээ. Одоо сөрөг хүчний зүгээс Засгийн газар нь Их Хурлынхаа дээр гарчхаад байгаад байна шүү дээ. Парламент үүргээ гүйцэтгэж чадахгүй байна гэж шүүмжлээд байна. Энэ бас бодитой шүү дээ.

Тийм учраас энэ эрх мэдлийн хуваарилалт хүртэл тэр хяналтын чадвар энэ тэр өнөөдөр энэ Үндсэн хуульд өөрчлөлт оруулснаар засагдах уу, үгүй юү гэдэг дээр бид үнэхээр 100 хувь итгэж чадах уу, үгүй юү гэдэг дээр иргэд ч гэсэн, бид ч өөрөө болгоомжтой хандаж байна шүү дээ. Тиймээс Улсын Их Хурлын гишүүд маань энд маш сайн анхаарах ёстой гэж би бодож байгаа. Энэ холимог тогтолцоо, жагсаалтын ард үнэхээр тэр төлөөлөх чадвараа хадгалж чаддаг хүмүүс орж ирээд энэ нь өөрөө өөрчлөлт

хийж чадвал үнэхээр 24, 28, 32 оноос эхлээд бодит байдал өөрчлөгдөх байх. Өнгөрсөн 30 жил шиг улс орон маань явахгүй байх гэж би бол бас харж байгаа. Тийм учраас үүнийг дэмжиж байгаа.

Харин бид ард түмнийхээ энэ хэлсэн, ярьсныг биелүүлэх ёстой. Яагаад гэвэл энэ парламент чинь өөрөө төлөөллийн байгууллага. Иргэд биднийг та нар маань биднийг төлөөлөөд тэнд очихоор энэ улс орны хөгжлийн асуудлыг, үүнийг шийдээд ирээч, энэ ажлын байрны асуудлыг, энэ гадаад, дотоод нөхцөл байдлын асуудлуудаа та нар шийд гэж явуулж байгаа шүү дээ. Гишүүд мэдээж өөр өөрийнхөө зүйлийг ярьж байна. Жишээ нь би Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүн. Өнөөдөр энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудлыг, гэр хорооллыг зохион байгуулалтад оруулах дэд бүтэцжүүлэх асуудлыг хэдэн жил ярьж байна. 30 жил ярьж байна шүү дээ. Яг бараг хэвээрээ байна шүү дээ. Уг нь энэ бололцоотой гэдгийг би Чингэлтэй дүүргийн тэр Хөтөлд 7, 20 дугаар хороонд сервис центр буюу дэд төв гэсэн төсөл хэрэгжүүлэхэд л 300 айл яндан, нүхэн жорлонгоос салаад хашиандаа хаустай. Одоо яг халуун хүйтэн усаа аваад амьдрах бололцоо бүрдэж байгааг харуулж байгаа байхгүй юу.

Гэтэл энэ мөнгө юунд урсаж байна гэхээр буруу замаар урсаад байна шүү дээ. Одоо энэ сангуудын байдлыг харъя л даа. Эрүүл мэндийн даатгалын санг хар, Нийгмийн даатгалын санг хар, Хөдөө аж ахуйн эрхлэлтийг дэмжих, Тариалан эрхлэлтийг дэмжих санг хар, Боловсролын зээлийн сан гээд л энэ олон сангуудын зарцуулж байгаа хөрөнгө, мөнгөнүүдийг бид нар бас харж байна шүү дээ. Тэн дотор зөв хуулийн дагуу ч байна, бүүр эсрэгээрээ хууль бус зүйлүүд ч байгаад байна л даа. Тэгээд бид энэ парламентыг л сайжруулчихаар энэ бүхэн нь үнэхээр сайжирчих уу гэдэг дээр сайн бодолцох ёстой л доо.

Тийм учраас энэ үүнийг дагаж орж ирэх Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль өөрөө өнөөдрийн энэ тогтолцоо үнэхээр үр дүнгээ өгөх үү, үгүй юү гэдгийн гол хариулт чагт нь болох ёстой. Үүнийг л иргэд, олон түмэн маань хүсэж байна. Ямар ч байсан бид нар 7 сарын 1-нд төсвийн тодотгол хийж, уулзалт дээр иргэдийнхээ тавьж байсан энэ тодорхой хэмжээгээр өрхийн орлогыг нэмэгдүүлэх асуудал дээр анхаарч байна.

Гэхдээ энэ бол маш бага хэмжээний асуудлыг л шийдэж байна. Ер нь яваандаа бид нар энэ эдийн засгийн асуудал дээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, хувийн хэвшилээ сайн дэмжиж, энэ хулгай, авлигын асуудлуудаа үнэхээр цэг тавьж, цэгцэлж байж, энэ дотор сэтгэлтэй, шударга хүмүүс л оруулж ирэх нь өөрөө маш чухал байгаа. Үүнийг хэн хийх юм гэхээр улс төрийн намууд өөрсдөө хийнэ. Одоо энэ тогтолцоог өөрчилснөөр улс төрийн намын даргын эрх мэдэл бол маш сайн, нэлээд их эрх мэдэлтэй болно.

Тэгэхээр өмнөх шиг тойрон хүрээлдэг ч гэдэг юм уу, эсвэл үгээр нь байдаг юм уу, эсвэл муу нэртэй хүмүүсийг жагсаалтын ард .../минут дуусав./

Г.Занданшатар: Үг хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Үг хэлэх боломж өгсөнд баярлалаа. Хуулиа л дагадаг байх даа хэдүүлээ. Бид бүр хуулийг бол уландаа гишгэчихлээ шүү дээ. Хуулиа л дагадаг байх даа. Бид Үндсэн хуулийн хорин гурав дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж заасан байгаа. Улсын Их Хурлын гишүүний ажил үүргийн тодорхойлолт. Энэ дээр бол Улсын Их Хурлын гишүүн бол намын удирдлагын элч мөн гэж бичээгүй байна. Энэ дээр нийт иргэн улсын ашиг сонирхлыг л эрхэмлэнэ

гэсэн болохоос биш ямар нэгэн нам дагаж далдгана гэж бичээгүй байна. Өнөөдөр нийт ард иргэд бараг 100 хувь энэ ярьж байгаа юмны эсрэг байхад энэ зааланд орж ирээд чанх эсрэг бид юм ярьж, чанх эсрэг ингэж кнопоо дарна гэдэг бол Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийг бид зөрчиж байна.

Миний хувьд бол хуулиа л дагадаг байх даа. Хэрэв хойшид Улсын Их Хурал энэ удаагийнх шигээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж иймэрхүү жишиг дэг тогтчихвол Үндсэн хууль нийгмийн гэрээ гэсэн сонгомол утгаа алдана. Үндсэн хууль зүгээр л нам нэртэй хэдэн хүмүүсийн зөвшилцөл бий болдог болно. Энэ улс оронд Үндсэн хуулийн аюул учрахгүй гэсэн магадлал тун бага боллоо. Мааш аюултай.

Үндсэн хуульд намуудын зөвшилцөл гэдэг ийм башир аргаар гар дүрдэг явдал бол хэрээс хэтэрчихлээ. Хуулиа л дагадаг байх даа. Та бүхнээс би асуулт асууя.

Миний 1 дүгээр асуулт. Одоо энд надад 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 28-ны өдрөөс 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны бүх тэмдэглэлүүд байна. Энэ дээр энэ 19 оны яг энэ хуралдаан дээр Бат-Эрдэнэ аварга, Тэмүүлэн гишүүн энэ ард нь нэлээн олон хүн байна. Ард нийтээс асуугаач ээ, энэ ард түмний асуулга асуух ёстой эрх мэдэл шүү дээ гэж асуусан байна. Бямбацогт Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хариулсан байна. Тэгнэ ээ гэж. Тэгэхээр миний 1 дүгээр асуулт. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 2 дугаар хэлэлцүүлгийн дараа ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэх тухай санал хурааж, Улсын Их Хурлын тогтоол гаргаж байжээ. Одоо яагаад ийм саналыг би эхний хэлэлцүүлэг дээр ярилаа. 2 дахь дээр ярьж байна. Одоо 3 дахь дээр нь ярьж байна. Яагаад ийм саналыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах 2 дугаар хэлэлцүүлгийн дараа хураахгүй байгаагийн хууль зүйн

тайлбарыг хийж өгөөч ээ. Хууль зүйн тайлбарыг хийж өгөөч.

2 дугаар асуулт. Энхболд даргын илтгэл дээр ч гарсан, хэд хэдэн хүний илтгэл дээр гарч байх шиг байсан. Зарчмын зөрөөтэй санал гараагүй гээд байна. Би өөрийнхөө харьяалагдаж байгаа 2 Байнгын хороо дээр зарчмын зөрөөтэй санал буюу байр сууриудаа илэрхийлсэн. Миний өөдөөс Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14.3-ыг барьж байгаад ингэж хэлсэн. Байнгын хороод Улсын Их Хурлын гишүүдээс төсөлд оруулахаар гаргасан зарчмын зөрөөтэй саналыг тусад нь хэлэлцүүлэхгүй. Харин 2 дахь хэлэлцүүлэгт оруулсан төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр нь дэс дараалан санал хураалт явуулахдаа хамтад нь хэлэлцэнэ гэж байгаа юм. Одоо би хамтад нь хэлэлцэхийг нь хүлээгээд л найдлага тасрахгүй л гуйгаад, яриад, учирлаад байгаа ухаантай шүү дээ. Би хуулиа л ярьж байгаа. Хуулиа л дагаж байгаа.

39.5-д тухайн асуудал хуваарилагдаагүй. Байнгын хороо цаашид бусад Байнгын хороо гэх нам, эвслийн бүлэг хуулийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан бол санал, дүгнэлтээ зарчмын зөрөөтэй саналын томъёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж байгаа юм. Төрийн байгуулалтын байнгын хороонд би байдаггүй. Би харьяалагддаг 2 Байнгын хороо дээр энэ асуудлыг тавиад уламжилсан. Юмыг яаж мэдэх вэ, замдаа гацаж магадгүй гээд 76 гишүүнд би бүгдэд нь би хаяглаж, тамгаа дараад явуулсан. Орхон аймгаас сонгогдсон төлөөлөгчийн хувьд би төлөөллийн ажлаа л хийж байгаа. Надад хариу байхгүй. Би бол Төрийн байгуулалтын байнгын хороонд санал ирээгүй гэсэн. Би очсон байх ёстой гэж бодож байна.

3 дугаарт, миний хүсээд байгаа юм энэ л дээ. Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заачихсан байгаа. Төрийн

байгуулалтын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэж, Улсын Их Хурлын нийт гишүүний 3-ны 2-оос доошгүй саналаар батална гэж байгаа юм. Үүнийгээ бариад та нар батлаад өгөөч ээ. Ард түмнээс асуугаад өгөөч ээ гэдэг саналыг минь унагаад юм уу эсвэл босгоод өгөөч ээ л гэж байгаа юм. Огт хэлэлцэхгүй байна гэдэг бол энэ хүчирхийлэл.

53.3-д Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах гишүүн цөөнх 2 дахь хэлэлцүүлгээр батлагдсан саналаас зөрөөтэй болон өөр зүйл, хэсэг, заалт нэмэх саналыг гаргахыг тус тус хориглоно гээд. Би яг үүнийг бариад зарчмын зөрөөтэй санал гаргана гэсэн. Хориглоно л гэж байгаа юм. Тэгэхээр ард түмнээс асуугаад өгөөч ээ гэсэн саналыг. Би дахиад унигъя. Та нар мартсан байж магадгүй. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.4.6-д төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо иргэдийн санаа бодлыг судалж, харгалзан үзэх гэж байгаа юм. Миний энэ асуулт дээр та нар яг ард иргэдийн санаа бодлыг харгалзаж байгаа юу, эсвэл эсрэгээр нь харгалзаж байгаа юу. Миний асуулт энэ бол.

Дараагийн миний асуулт бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуулийн 17.1 та нар бичээд аваарай, 17.1-д Улсын Их Хурал төслийг хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний 3-ны 2-оос доошгүйн саналаар тогтвол гэж байгаа. Би өнөөдөр 126, 150, 60, 300, 76 гэж тоо ярьсангүй шүү дээ, тэртээ тэргүй би эсрэг байгаа. Би үүнийг шийдэж байгаа

арга механизм нь буруу байна л гэж яриад байгаа юм. Энэ арга механизм дээр та нар миний асуултад хариулж өгөөч. Тэгэхээр тогтвол гэсэн үг анхаарал татаж байна. Энэ тогтвол Улсын Их Хурлын тогтоол гарч шийдвэр гарч цаашаа явна л гэж байгаа юм. Бид тогтсон уу, тогтоогүй юу, шууд хүчиндчихсэн үү? Миний 4 дүгээр асуулт.

Дараагийн асуулт. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15.2-т, 15.2-т Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24-ийн итрих 6. 2-т заасан үндэслэлээр гаргасан саналын томъёоллыг уншиж томъёолол тус бүрээр санал хураана гэж заасан байгаа. Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан гээд. Би та бүхэнд бичиг илгээхдээ үүнийг бүгдийг нь хавсаргасан байгаа. Легал инфо дээр ч байхгүй, тэр бүх 24 итрих 6. 2 гэдэг юм байхгүй. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 24-ийн итрих 6. 2 гэсэн зүйл заалт байхгүй болохоор бид мухардалд орчихоод байгаа юм биш үү. Энэ дээр надад хариулт өгөөч, эрх зүйн тайлбар өгөөч. Би эсвэл буруу юм хараад та нарыг гүтгээд байна уу?

Эцэст нь хэлэхэд ... /минут дуусав/

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга, ажлын хэсгийн ахлагч асуултад хариулъя.

Н.Энхболд: Үндсэн хуулийг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал өөрөө тусгай дэгээр тусгай хуулиудаар явдаг. Энд хамгийн гол өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэхдээ баримтлах хамгийн гол заалт бол хууль санаачлагчаас оруулж ирснээс өөр зүйл, заалт, бүлгийн тухай асуудал ярихгүй ээ гэдгийг маш тодорхой заачихсан байдаг, 1 дүгээрт.

2 дугаарт, ард нийтийн санал асуулга өөрөө бас зохицуулдаг тусгай хуультай. Хэн санаачлах вэ, яаж

санаачлах вэ, яаж хэлэлцэх вэ, шийдвэр нь яаж гарах вэ гээд. Тэгээд энэ 2 хуулийг ингээд хоёуланг нь аваад үзэхээр жишээ нь Засгийн газраас оруулж ирсэн ганцхан заалттай, дотроо нэг 2 агуулгатай, энэ хуулийг хэлэлцэх явцад хажуугаар нь өөр тусгай хуулиар зохицуулагддаг санал асуулгын тухай асуудлыг жишээ нь оруулж ирэх боломж хуулиар зөвшөөрөгдөөгүй байсан учраас Ганбаатар гишүүний яриад байгаа зүйлүүд хөндөгдөөгүй. Ажлын хэсэг дээр ч хөндөгдөөгүй, Байнгын хороо дээр ч хөндөгдөөгүй, 2 удаагийн хэлэлцүүлгээр ч Их Хурлаас тийм тодорхой шийдвэр, тийм шийдвэрүүд гараагүй, гарах ч үндэсгүй гэж үзсэн. Нэмэлт тайлбар байвал манай ажлын хэсэг Их Хурлын Тамгын газраас бас нэмээд хариулчхаарай.

Харгалзаж байгаа юу та нар 2 удаа хэлэлцүүлэг явуулаа. Ард иргэдээс гарч байгаа саналыг харгалзаж байгаа юу гэж, харгалзсан уу гэж асууж байна. Харгалзаж үзсэн гэж бодож байгаа. Анх орж ирсэн гишүүдийн тооны харьцаа байна, тооны асуудал байна. Холимог системээрээ явбал тойрог, жагсаалт 2-ын харьцаа ямар байх вэ гэсэн ийм үндсэн 2 асуудлыг л товч бид нар ярьсан. Одоо 152 байсан 126 болчхоод явж байгаа нь бол үнэхээр бас хэлэлцүүлгүүдийн явцад хүмүүстэй уулзах явцад гишүүдийн тоо ийм олон байж болохгүй гэдгийг харгалзаж үзээд бууруулсан гэж хэлж болох нэг том шалтгаан нь бол тэр ард иргэдээс гарч байсан саналтай холбоотой харгалзаж үлдсэн байдал.

Нөгөөх нь тойрог, жагсаалт 2-ын хоорондын харьцаа. Хэдэн хувь нь хэрэв холимог тогтолцоогоо авч байгаа бол хэдэн хувь нь тойргоос байх ёстой, хэдэн хувь нь жагсаалтаар байх ёстой гэдэг дээр бас гарч байсан саналын дийлэнх нь нутаг дэвсгэрийн, хүн амын суурьшлын гэх мэтчилэн асуудлуудыг харгалзаж үзээд тойргоос сонгогдох гишүүдийн тоо нь аль ч тохиолдолд хуучнаараа үлдэнэ үү, тоо нь нэмэгдээд гарна уу илүү байх

ёстой гэсэн санал дийлэнх олонх нь давамгайлж гарч байсан учраас мөн үүнийг харгалзаж үзээд нөгөө өргөн барьсан хуулийн төсөл дээрээ оруулсан өөрчлөлтүүд маань энэ хэлэлцүүлгийн явцад иргэдийн зүгээс гарсан саналыг тусгасан гэж хэлж болох юм. Ер нь тусгасан гэж үзнэ, үзэж бид нар ийм өөрчлөлтүүдийг оруулж ирсэн.

Тамгын газраас нэмж хариулах юм байвал хариулж болно.

Г.Занданшатар: Тамгын газар хариулахгүй л дээ. Ажлын хэсэг.

Н.Энхболд: Дэг бол ер нь бид нар тогтоосон журмынхаа дагуу л мөрдөөд л явж байна гэж явж байгаа. Хэрэв Их Хурал буруу гэж үзсэн бол 2 удаа 3 дахь хэлэлцүүлэгт хүрэхгүй л байх л даа. Тэгээд энэ хооронд чинь бид нар маш олон хуульчдаас, гишүүдээс гарч байгаа саналууд, иргэдээс гарч байгаа саналууд, таны бичиг бол над дээр ирсэн, ажлын хэсэг дээр бид нар би танилцуулсан албан ёсоор. Ингээд энэ шат дамжлагуудаар дамжаад өдий хүрчихсэн байгаа болохоор энэ бүх шатанд дэг зөрчигдөөгүй л гэж ойлгож яваад ирж байгаа. Тийм.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууна.

С.Ганбаатар: Би хариултаа хангалттай аваагүй. Ямар ч байсан үүнийг протоколдоо тусгуулъя. Миний ярьсан, асуусан зүйлүүдийг. Тэгээд ер нь бол Үндсэн хууль өөрөө анх үүсэхдээ бол хаад, ноёдын дур зоргыг л хязгаарлах гэж, хазаарлах гэж л бий болсон ойлголт. Одоо манайхаар бол Улсын Их Хурлын гишүүд болон Улсын Их Хурал, Ерөнхий сайд болон тэдний сайд нар, Ерөнхийлөгч, Ерөнхий шүүгч гэсэн шийдвэр гаргаж байгаа энэ хүмүүсийн буруутай үйлдэл, шийдвэрүүдийг л дур зоргыг нь хазаарлах гэж энэ бий болсон зүйл. Өнөөдөр бид дур зоргоороо сандал, ширээ, тоогоо нэмж байгаа. Нэмж болно. Би үүнийг ерөөсөө

яриагүй. Ганцхан эздээс нь асууя л гэдгийг би асуудлыг ярьж байгаа.

Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд бид нэг ард иргэдээс ор төдий жүжигчилсэн асуулга асуусан болоод ирээд хаалгаа хааж байгаад энэ дээр дөрөвний гурваараа гар өргөнө өө гэдэг бол бид хуулиа дагах ёстой л гэж би бодож байна. Тэгэхээр нийгмийн гэрээ зарим хүмүүс яриад байдаг, нийгэм төртэй байгуулсан гэрээ гэж буруу ойлгоод байдаг. Үгүй, Жон Локин яг анхны сонгодог ойлголт нь бол нийгэм өөрөө өөрсдөө гэрээгээ байгуулдаг. Түүнийг нь төр засаг хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Хэн нэгэн хаан, хэн нэгэн ухаантай улс төрч биднийг дээрээс захирахгүй. Бид дотроо зөвшилцөж, нийгмээ яаж авч явах вэ гэдгээ тогтоно л гэж байгаа. 76 бид 850-аад хууль баталсан юм гэнэ лээ. Ард иргэдийн ганцхан бидэнд баталсан хууль руу бид гар дүрж болохгүй гэдэг ийм зарчмын байр суурьтай байгаа.

Г.Занданиатар: Ганбаатар гишүүн Сайнхүүгийн Ганбаатар гишүүн яг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, Үндсэн хуулийн 23.1 нэг эшлээд бас чухал асуудал хөндөж байна л даа, зүйтэй. Үндсэн хуулийн 23.1-д зааснаар Улсын Их Хурлын гишүүн бол нийт ард түмний илч төлөөлөгч мөн бөгөөд улсын ашиг сонирхлыг эрхэмлэнэ гэсэн ийм агуулгатай. Тийм учраас энэ зарчмаараа л Үндсэн хууль тогтоогчид Үндсэн хуулиа хэлэлцэх ёстой. 24-ийн штрих 6.2 бол одоо 3 дахь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу Байнгын хорооны санал, дүгнэлтийг эхлээд сонсоно. Үүний дагуу гишүүд асуулт асууж болно. Асуулт асуусны дараа 24-ийн штрих 6.2-т заасны дагуу саналын томъёолол тус бүрээр санал хураалт явуулна. Тэр саналын талаар бол дэмжсэн, дэмжээгүй асуулт асууж, үг хэлж болно гэсэн энэ дэгийн дагуу явж байгаа.

Таны тэр ард нийтийн санал асуулга явуулах асуудал бол Ард нийтийн санал асуулга явуулах журмын тухай хууль болон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль зохицуулснаар Улсын Их Хурлын нийт гишүүний 3-ны 2 буюу 38 энэ Улсын Их Хурлын нийт гишүүний 3-ны 2-ын саналаар ард нийтийн санал асуулга явуулах журмыг. Тусгай дэгтэй буюу 3-ны 2-оор буюу нэг гишүүний саналаар бол энэ Төрийн байгуулалтын байнгын хорооноос энэ асуудал орж ирээгүй, санал болоогүй, хэлэлцээгүй учраас ард нийтийн санал асуулгаар явуулах асуудал хэлэлцээгүй.

3 дахь хэлэлцүүлэг явуулсны дараа хэрвээ тухайн саналын томъёоллоор Улсын Их Хурлын гишүүний 3-ны 2 ард нийтийн санал асуулгаар явуулах санал гаргаад энэ нь дэмжигдэх юм бол энэ дэг журмаар явна. Тийм учраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15.1, 15.2-т заасны дагуу энэ яг журмынхаа тухай хууль хэлэлцэж байна. Тэгээд гишүүн бол үүнийхээ дагуу асуудал тавьж болно.

Харин тэр Үндсэн хуулийн 23.1 байх, тэр Улсын Их Хурлын гишүүд бол ард түмнийхээ элчийн хувьд Үндсэн хууль тогтоогчоор оролцоно. Намын төлөөлөгчөөр биш гэдгийг ард түмний төлөөлөгчийн хувьд гэдгийг бол энэ зарчим санал бол дэмжиж байгаа. Хэлэлцүүлгийн үед анхаарах ёстой зөв асуудал мөн гэдгийг хэлчихье.

Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр сая бас Хороо, хороон дээрээ очиж Үндсэн хуулийн асуудлаар зөвлөлдөж ярилцлаа, иргэдтэйгээ. 152-оос буулгасан нь сайн байна гэж байгаа юм. Гэхдээ бас энэ дээр өөрсдийнхөө санаа бодлыг хэлж байна. Хэлэхдээ үгүй ээ энэ ер нь 76-аараа байгаад байж болдоггүй юм уу? Яагаад заавал ингэж нэмэх шаардлага гараад байна. Тэгээд тэр галт тэрэг нь хөдлөөд

нэгэнт ингээд нэмэх гэж байгаа бол 126 чинь ч гэсэн ер нь их байна шүү гэдэг асуудлыг бол иргэд үнэхээр бас ярьж байна. Тэгээд үүнийгээ арай багасгаж болдоггүй юм уу гэдэг асуудлыг бол бас хороо, хороон дээр бол хүмүүс яриад хөндөөд байна. Ингээд энэ дээр бас нэг зарчмын асуудал юу яригдаж байгаа гэхээр энэ 76-гаа одоо ингээд 126 дээрээ явлаа гэж бодоход хэрэв үүнийгээ ингээд буулгах юм бол, буулгавал 76 гишүүн дээрээ буулгахгүй шүү. Энэ мажоритар тойргоороо явдаг энэ тогтолцоогоор гардаг гишүүдийнхээ тоог буулгахгүй, харин пропорциональ тогтолцоогоор орж ирж байгаа энэ тавиасаа буулгана шүү гэдэг бас асуудлыг бол тууштай захиж, ярьж байна лээ.

Төсвийн асуудал дээр бас тал талаас нь иргэд яах аргагүй хөндөж ярьж байгаа. Төсөв дээр бол нэг ийм юм яриад байгаа юм. Хэрэв ингээд гишүүдийн тоо нэмэгдлээ гэхэд тэгвэл энэ чинь нэг тодорхой тоогоор нэмэгдэхэд өнөөдөр байгаа тооцоогоороо нэг гишүүнд гарч байгаа тэр зардал тэгвэл тэр нэмэгдэж байгаа гишүүдэд яг тэр хэмжээгээрээ бол нэмэгдэж болохгүй шүү. Тэр нөгөө хэмнэх зарчмаа бол бариарай. Тэгэхээр нэмэгдэх ёстойгоосоо буулгаж тооцож нэмээрэй. Аль болох сайн буулгана шүү. Энэ дээр ямар нэгэн бодол санаа оноо байна уу гэж асууж байна лээ. Тэгэхээр би энэ асуултыг бас тавимаар байна. Яг тэр төсөв дээр тэгвэл энэ нэмэгдэхэд тооцоо хийсэн үү? Энэ байгаа гишүүд нэг гишүүн дээр гарч байгаа зардлаа энэ нэмэгдэж байгаа гишүүдээрээ яг түүгээр нь нэмэх гэж байна уу эс үгүй бол түүнээсээ буулгаж нэмье гэсэн юу тооцоо, санал байгаа юу? Үүнийгээ бас хэлж өгмөөр байна. Энэ дээр нэг юм би бол дүүргийнхээ бас сонгогчдоор бахархаж байгаа. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг өчнөөн ярьж байхад бүгдээрээ тогтолцооны өөрчлөлт гэж яриад л байгаа. Тэгтэл энэ дээр бол манай дүүргийн гишүүн ялангуяа юу дүүргийн сонгогчид 18 дугаар хорооны Болд гуай асууж байгаа юм. Үгүй ээ, энэ та нар Үндсэн хууль ярихдаа

тогтолцооны өөрчлөлт гэж ер нь юу яриад байна аа? Би үнэхээр энэ асуултыг асуухад яг л асуудлыг нь оноож харж асууж байна даа гэж бодож байсан. Үнэхээр энэ Үндсэн хуулийнхаа тайлбарыг хийхдээ бас үндэслэлтэй ийм тайлбар бас хийж ярьж баймаар байна. Энэ Үндсэн хуулийн энэ өөрчлөлт бол тогтолцооны өөрчлөлт биш шүү. Монгол Улсын Үндсэн хуулийн эрэмбэд яригдах тогтолцоо гэдэг бол улс төрийн тогтолцоо л ярина. Үндсэн хуулийн эрэмбэд яригдах тэр улс төрийн тогтолцоо бол Монгол Улс 92 онд хийчихсэн. Өөрөөр хэлбэл парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улс. Энэ тогтолцоонд ямар ч өөрчлөлт бол орохгүй байгаа. Гишүүдийн тоо нэмэгдэнэ гэдэг бол энэ парламентынхаа орон тоог л нэмж байгаа. Өөрөөр хэлбэл Засгийн газар 16 гишүүнтэй байж байгаад 20-той боллоо гээд тогтолцооны өөрчлөлт бол хийгдээгүй шүү дээ. Энэ чинь Засаг нь л томорч байгаа, өөрөөр хэлбэл, ардчилсан, бүгд найрамдах энэ парламентын засаглалтай улсад байгаа Засгийн газрынх нь хэмжээ л томорсон болохоос биш бүтэц нь өөрөө бүхэлдээ улс төрийн тогтолцоо нь өөрчлөгдөөгүй. Тэгэхээр үүнийг ингэж андуурч яриад байж болохгүй ээ гэсэн үүднээс тэр юу манай сонгогч асууж байна лээ. Тэгэхээр үүнийгээ бас яг тал талдаа зөв ойлгож ярих хэрэгтэй. Тэгэхгүй бол ямар бид нар чинь Ерөнхийлөгчийн засаглал руу юм уу эс үгүй бол хэмжээт эрхт хаант засаглал руу юм уу эс үгүй бол бүр бүрэн эрхт хаант засаглал руу шилжиж байгаа биш. Тэгэхээр манай тогтолцоонд бол ямар нэгэн өөрчлөлт гараагүй.

Пропорциональ тогтолцоо ч гэсэн сонгуулийн тогтолцоонд л өөрчлөлт орж байгаа болохоос биш улс төрийн тогтолцоонд бол өөрчлөлт ороогүй. Тэгэхээр үүнийг бол энэ Үндсэн хуулийн хүрээндээ энэ тогтолцооны өөрчлөлт гэж яриад байх нь бол үнэхээр байгаа онохгүй байгаа зүйл шүү.

Тэгээд надад нэг асуулт байна. Энэ иргэд бол ийм юм ярьж байгаа юм.

Амьдрал үнэхээр хэцүү байна. Та нар тэтгэвэр тэтгэмжийг ёстой нэмэх, цалин нэмэх тал дээр үнэхээр сайн анхаараарай. Тэгээд энэ эдийн засаг чинь цаашаа тогтвортой өсөх ийм хууль, тэгээд Үндсэн хуулийн өөрчлөлт чинь ийм шинж чанартай юм байгаа юм биз дээ гэдэг дээр бол үнэхээр сэтгэл нь зовж асууж байна лээ. Тэгэхээр энэ дээр нөгөө эрсдэл талаасаа та нар бас тооцож үзсэн үү? Өөрөөр хэлбэл эрсдэл талаасаа нэгэнт энэ чинь ингээд хэрэгжээд эхлээд асуудал үнэхээр хүндэрдэг юм бол үүнийгээ яаж буцаах вэ гэдэг тал дээрээ та нар ямар гаргалгаа гарц бодсон бэ гэдэг асуултуудыг асууж байгаа юм. Тэгэхээр манай зарим ахмад дөнгөж сая наашаа явж байхад хүртэл ахмад Монгол Улсад бол үнэхээр нэр хүндтэй Хөдөлмөрийн баатар, Улсын баатар хүмүүс нийлээд бас захидал бичиж байгаа юм байна лээ. Тэрийгээ надад албан ёсоор мэдэгдэж байна лээ. Тэгээд юу энэ дээр бол миний нэг асуух юм тэгэхээр энэ чинь 8 жилийн дараа, 8 жил гар хүрэхгүй гэж байгаа шүү дээ, энэ заалт нь орж ирж байгаа. Тэгэхээр 8 жилийн дараа, 8 жил хүрэхгүй гээд зогсохгүй, бас 8 жилийн дараа энэ чинь ажиллаж байна уу, болж байна уу, үгүй юү гэдгийг дүгнэх энэ процедурыг оруулж өгч болох уу? Би бол заавал өөрчилнө гэж ярьж байгаа биш. 8 жилийн дараа болохгүй бол үүнийгээ дүгнээд дараагийн алхмаа хийх энэ үүд хаалгаа нээж өгөх эрх зүйн боломж байгаа юу гэж юунаас ажлын хэсгээс асуумаар байна аа. Ингээд 2 асуулт байна. Тэр 2 асуултад хариулт өгнө үү?

Л.Мөнхбаатар: Дамдины Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Нямаагийн Энхболд хариулъя. Ажлын хэсэг нэмж болно.

Н.Энхболд: Цогтбаатар гишүүнээр дамжуулаад иргэдийн тавьсан тогтолцоотой холбоотой асуудал дээр бол санал нэг байгаа. Бид нар төрийн тогтолцооны өөрчлөлтийн тухай яриагүй байгаа. Сонгуулийн

тогтолцоогоо яаж шинэчлэх вэ гэдэг асуудал ярьсан. Ер нь сонгуулийн тогтолцоо дотроо юуг ойлгох вэ гэхээр бас үүнийг бас л энэ талаар мэргэшсэн судлаачид, улс төрчид, олон хүмүүстэй ярьж байгаад сонгуулийн тогтолцоо гэдэг бол өөрөө ерөөсөө яаж нэр дэвшүүлэхээс эхлээд яаж тоолох вэ, яаж дүнгээ гаргах вэ? Тийм ээ, энэ бүх зүйлүүдээ оруулсан энэ цогцыг үүнийг бүхэлд нь сонгуулийн тогтолцоо гэж үзнэ. Одоо бол манайх жишээ нь 76 тойргоос тойрог тойрог дээр нь дэвшүүлээд, тэгээд ингээд тоолоод, ингээд дүнг нь гаргаад яваад бүрэн эрхийг нь эдлүүлж эхэлнэ гэдэг хүртэлх энэ зүйл бол бүхэлдээ нэг байгаа. Гэтэл дундуур нь өөр юм ороод нэг хэсгийг нь тойргоос, нөгөө хэсгийг нь жагсаалтаар гээд явна гэвэл энэ сонгуулийн тогтолцооны л асуудал болохоос төрийн тогтолцооны асуудал биш ээ гэдэг дээр санал нэгдсэн. Энэ нь тэр иргэдээс гарч байгаа саналтай нийцэж байна гэдгийг хэлье.

2 дугаарт, 1 гишүүнд ноогдох зардлын тухай асуудал байна. Яг энэ удаа манай ажлын хэсэг дээр Байнгын хороо дээр энэ талаар тооцоо хийж үзсэн зүйл байхгүй. Яах аргагүй энэ асуудлыг хэлэлцэхэд дагаж гарч ирж байсан нэг асуудал бол энэ мөн. Хүний тоо нэмэгдлээ гээд зардал чирэгдэл хэр болох вэ. Энэ нь өөрөө эдийн засагт, нийгэмд хэр зэрэг дарамттай байх вэ гэдэг асуудал бол олон удаа яригдсан. Тэгээд хэрэв энэ Үндсэн хуулийн өөрчлөлт батлагдчихвал үүнийг дагаад мэдээж хэдэн гишүүнтэй байх вэ? Хамгийн наад зах нь байр сав, ширээ сандлаас эхлээд асуудал гарч таарна. Тэгэхдээ хэлэлцэх явцад ерөөсөө нийтлэг гарч байсан саналууд гэвэл дор хаяж нэг гишүүнд ноогдож байгаа зардал бол одоогийнхоос бага байх ёстой шүү гэдэг зүйлүүд дээр ер нь үг хэлсэн хувилбар дэвшүүлж байсан хүн болгон ярьж байсан гэдгийг хэлье.

Яг одоогийн байдлаар Үндсэн хуулийн заалт зүйл, заалтууд яаж хэрэгжиж байна вэ гэдгийг яг ингэж

дүгнэнэ гэсэн тийм зохицуулалт, түүнд нийцсэн процедур гэж юм байхгүй. Энэ өөрөө хөгжлийн явцад нийгмийн хөгжлийн шаардлага, улс төр, нийгмийн амьдрал, бүх л талыг хамарсан энэ амьдралын явцад гарч ирэх шалтгаануудаас үүдээд ер нь болж байна уу, болохгүй байна уу, цаашидаа яах вэ гэдэг асуудлууд бол байнга л ярьж хөндөгдөж байдаг асуудал. Түүнээс тодорхой хугацаа дагаад тийм хугацаанд ингэж дүгнээд болж байна, болохгүйг нь дүгнээд, тэгээд түүнийхээ дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах уу, үгүй юү гэдэг асуудлыг ярьдаг ийм зохицуулалт манайд байхгүй. Бусад улс орон ч гэсэн ер нь бас тийм тэдэн жилээр заагаад тэдний дараа нь ингэж дүгнэж үзээд ингээд шаардлагатай бол өөрчлөлт хийх асуудлыг хөндөж байна гэсэн зохицуулалт бараг байхгүй болов уу л гэж би бодож байна. Лав би мэдэхгүй, би мэдэхгүй байна. Манайд бол 8 жилийн дотор өөрчлөлт урьд нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хөндсөн асуудлыг 8 жилийн дотор дахиж ярихгүй гэсэн ийм л зохицуулалт байгаа болохоос 8 жил болоод ингэж дүгнээд цаашидаа ингээд явна гэсэн ийм зүйлүүд бол бас байхгүй байгаа гэдгийг л хэлье дээ.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Дамдины Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Д.Цогтбаатар: Энхболд гишүүн ээ, энэ дээр миний асууж байгаа ерөөсөө 8 жилд оролдохгүй байна гэдэг чинь уг нь миний асуултад эерэг хариулт өөрөө агуулчихсан байгаа зүйл. Би зөвхөн тодотгож өгч байгаа юм. Би тэгэхээр энэ саналаа бас ер нь протоколд оруулъя гэдэг үүднээс хэлж байгаа юм. Юу гэвэл 8 жил оролдохгүй гэдэг чинь 8 жилийн дараа хэрэгцээ гарвал энэ заалтуудыг өөрчилж болно гэж үүд хаалгыг нь угаасаа нээж өгсөн заалт байхгүй юу. Тэгэхээр энэ дээр өнөөдрийн бид нар энэ хэлэлцэж байгаа энэ Ганбаатар гишүүн эд нарын хэлээд байгаа чинь яах аргагүй бас сонсох ёстой. Энэ гишүүн ч хэлэх

ёстой санаагаа хэлээд байна шүү дээ. Тэгэхээр ийм нөхцөл байдалд бид нар энэ хууль чинь орж ирээд хэлэлцэгдээд явж байхад тэр 8 жилийн дараа аливаа хуульд ер нь өөрчлөлт орж болно. Тэгвэл бид нар үүнийгээ эргээд зүгээр нээлттэй үлдээх биш, эргээд дүгнэнэ шүү гэдэг энэ санааг би бол заавал энэ протоколд бол оруулж өгөх гэж байгаа. Яагаад гэвэл угаасаа нээлттэй болж байгаа байхгүй юу. Тэр чинь дүгнэхийг ч уг нь зөвшөөрчихсөн, тодотгож өгөөгүй байгаа юм. Үүнийг би тодотгож өгч байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Байр сууриа бүртгэн авч тэмдэглүүлж байгаа гэж ойлголоо. Одоо Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Үндсэн хуулийн өөрчлөлт нийгмийн бүхий л хүрээнд 1 сарын ингээд хэлэлцүүлэг болоод Их Хурлын 3 дугаар хэлэлцүүлэг буюу төгсгөлийн хэлэлцүүлэг рүү орж байна л даа. Би бас анхнаасаа оролцоод явсан хүний хувьд ажлын хэсгийн гишүүний хувьд асуулт бол алга.

Ер нь өнгөрсөн хугацаанд тойргийн сумдаар болоод тойргийн бус аймаг, сумдаар бас багагүй хугацаанд бас явж ажиллалаа. 1 дүгээр хэлэлцүүлэг, 2 дугаар хэлэлцүүлгийн хүрээнд. Ер нь ард иргэдийн хувьд тоо нэмэхийг нийтээрээ бас таашаахгүй байгаа. Тоо нэмэхгүй болоод гэвэл хуучнаараа 76 байхыг бас бүр их таашаахгүй байгаа. 76 хулгайч, 76 бүхий л тийм таагүй хэллэгээр хэлдэг ийм л нөхцөл байдалтай болчихож. Тэгэхээр энэ Монголын төр чадваржих, Монголын парламент чадваржихын тулд бид нар яах ёстой вэ. Одоо байгаадаа тааламжгүй. Өөрчлөлтийн саналд бас тааламжгүй. Тэгэхээр үүн дээр бид нар бас тодорхой хэмжээний энэ яагаад ийм болчихов оо гэдэг дээр тал талдаа бас дүгнэлтүүд хийх ёстой байх гэж л бодож байгаа. 126 биш 110, 108, 99 боллоо гээд ч дахиад энэ тааламжгүй. Тэгэхээр яг энэ үндсэндээ одоо байгаадаа ч тааламжгүй.

Тэгэхээр энэ үндсэндээ асуудлын шалтгаан нь энэ магадгүй парламентын Их Хурлын тоондоо биш байж таарах гээд байгаа юм. Эдийн засгийн ядуурал их байна, нийгмийн шударга бус байдал их байна, энэ бүхэнд бухимдсан иргэдийн бухимдал энэ гарч байгаа Үндсэн хуулийн өөрчлөлт дээр бүр илүү тийм тэсэрч, илэрч харагдаж байна л гэж би хувьдаа дүгнэлттэй байгаа. Түүнээс биш тоо их, багын асуудал энд асуудлын гол цөм бас биш байх гээд.

Ардчилсан намын хувьд ер нь энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал дээр пропорциональ тогтолцоо оръё. Холимог тогтолцоо гэдэг зүйл оръё. Нийгмийн төлөөлөл оръё. Улсын Их Хурал байгуулагдахад санал гээгддэггүй байя гэдэг энэ зарчмыг баримталж ирсний түүхэн байр суурийг л энэ удаагийн өөрчлөлтөд шингээх юм сан гэдэг л ийм байр суурьтай байсан. Явсаар явсаар байгаад энэ орохын тулд заавал тоо өөрчлөгдөх нь ээ гэдэг ийм нөхцөл байдал эндээс зайлшгүй үүсэж байгаа. Ийм учраас тэгээд заавал ийм учраас энэ хэлэлцүүлэгт Ардчилсан намын удирдлага, Ардчилсан намын төлөөллийн байгууллага болоод Ардчилсан намын бүлгийн гишүүд ийм учраас энэ хэлэлцүүлэгт хамтран оролцоод анхнаасаа улс төрийн зөвшилцөл хийгээд тал талаасаа ажиллаж байгаа юм.

Яг бас тодорхой нөхцөл байдал дээр энэ буугаад ирж байгаа 152-ыг ард иргэд таашаахгүй байгаа учраас 126 гэдэг тоо дээр бас тодорхой хэмжээнд Ардчилсан нам бас үүн дээр нэлээн тийм энэ тоо дээр нэлээн тийм үүрэг оролцоотой бас оролцож байгааг бодоод бас нуух зүйлгүй бас хэлэх нь зүйтэй. Аливаа асуудлын цаана ер нь Монголчууд бас нэг тийм арга билгийн сэтгэхүйгээр асуудалд ханддаг. Арга билгийн сэтгэхүйгээр. Ер нь арга талаасаа олон зүйлийг л тайлбарлаж болно. Төлөөллийн зарчим олон зүйлүүдийг. 126 гэдэг тоо дээр ер нь бас ингээд тал талаасаа байж болох юм гэдэг санал очиж байгаагийн нэг

нь агуулга талаасаа 126-г хуваах нь 78 гээд гарвал 1.61 гэдэг тоо гарч байгаа юм. Математикт алтан харьцаа гээд байдаг. Пибоницийн дараалал энэ тэрээс гаралтай алтан харьцаа агуулгын хүрээнд, гоо зүйн хүрээнд энэ алтан харьцаа аливаа тоо алтан харьцаатай байвал илүү тийм дэвшилттэй бас үздэг. Тэгэхээр яг өнөөдөр энэ санал болгогдоод эцсийн хэлэлцүүлэгт орж ирж байгаа тэр 126, 76 гэдэг 2 тооны харьцаа бол яг математикийн алтан харьцаанд 1.61 гэдгээрээ ингээд бүрэн дүүрэн нийцэж байгаад би энэ тийм таатай тоо дээр бас эцсийн хэлэлцүүлэгт орж ирж байна уу гэсэн ийм байр суурьтай байгаа.

2 дугаарт нь, билиг талаасаа бид нар бас тийм билиг ёсны ард түмэн. 126,12, 06 гээд хэрвээ үзэх юм бол энэ өөрөө бас Монгол Улсын сэргэн мандсан Их Монгол Улс байгуулагдсан бас ийм билгийн тоо. Ардчилсан намын хүрээнд ч тэр, энэ билэг талаасаа асуудалд ханддаг бас их олон хүмүүс байдаг, бас тэр хүмүүсийн байр сууриуд энд бас тодорхой хэмжээний нөлөө үзүүлснийг энд бас хэлчих нь зүйтэй. Жишээ нь Фортуна гэж хэлдэг Батбаяр гуай бас л олон тал дээр асуудлуудыг ярьдаг. Манай Говь-Алтайн Амгаланбаатар гээд бас ингээд асуудалд ингээд билэг ёс талаасаа, агуулга талаасаа ханддаг олон хүмүүсийн нөлөө энд бас тодорхой хэмжээгээр бас ингэж тусаад явж байгаа гэдгийг ингээд хэлчих нь зүйтэй.

Ер нь бол нэгэнт эцсийн шатанд ороод ингээд Улсын Их Хурал дээр ингээд эцсийн хэлэлцүүлэгт орж байна. Ер нь бид нар чинь бас аливаа амны билгээр ард түмэн. Тэгээд ямар ч байсан энэ тал талаасаа судлаачдын хамгийн гол нь энэ 120-оос бас дээш байх нь өөрөө өөрчлөлт хийсний утга учир бас тодорхой хэмжээгээр оршино гэж судлаачид бас ийм байр суурийг маш хүчтэй илэрхийлж байгаа болохоор эцсийн дүндээ Улсын Их Хурал болоод шийдвэр гаргагчид олон талаасаа судлаачдын байр суурийг авч бодлого шийдвэрт хэрэгжүүлэх нь зүйтэй

гэдэг дээр ер нь энэ нийгмийн зөвшилцлийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль ер нь Үндсэн хууль гэдэг зүйл өөрөө зөвхөн хууль төдий биш юу нь өөрөө нийгмийн ойлголцлын хүрээнд гардаг томоохон баримт бичиг болохоор үүн дээр ингээд тал талаасаа бас харилцан хүндэтгэлтэйгээр хандаж асуудал ингээж ойлголцол зөвшилцлийн хүрээнд бас явж ирснийг энд бас би заавал ингээд тэмдэглээд хэлчихье гэж ингээж бодож байна. Асуулт байхгүй.

Л.Мөнхбаатар: Үг хэллээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтийг өнгөрсөн 30 жилийн алдаа оноог засаж сайжруулахад, залруулахад чиглэгдэж байгаа гэж ойлгож байгаа. Тэр дундаа Доржханд гишүүний хэлснээр бол хулгайгүй төр засагтай болох юм байна. Шилэн тунгалаг төр засагтай болох юм байна. Төр шиг төртэй болох юм байна. Нэр хүндтэй хариуцлагатай төр засагтай болох юм байна гэж хамгийн их итгэж энэ өөрчлөлтийг хийх ёстой юм байна гэж би хувьдаа ойлгож байгаа. Тийм учраас бас 30 жил энэ тогтолцоо энэ төр засгийн бодлого явж ирсэн. Өнөөдөр бас яг энэ чигээрээ явж болохгүй юм байна гэж хувь хүнийхээ хувьд залуу хүний хувьд бас нэг томоохон өөрчлөлт, шинэчлэлт хийх ёстой юм байна гэж үзэж энэ удаагийн өөрчлөлтийг дэмжиж байгаа юм. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг.

Гэхдээ зүгээр ард иргэд тоон дээр их акцент өгөөд байгаа юм. 152-ыг дэмжихгүй, 126-г дэмжихгүй гээд ингээд. Яах вэ, уулзахаар бол ер нь аль алийг нь дэмжихгүй байгаа асуудал бий. Гэхдээ ард түмнээс асуугаад нийгэмд өөрчлөлт, шинэчлэлт хэрэгтэй юу гэхээр бүгд 100 хувь дэмжиж байна, хийхийг хүсэж байна гэж ингээж хэлж байгаа юм. Энэ бол сайн тал. Ам уралдаад өнөөдөр нийгэм бүр уначихлаа, доройтчихлоо гээд ярьж

байгаа юм. Тэгвэл ер нь энэ өнгөрсөн 33 жилийн хугацаанд 90 оноос хойш, ер нь хэзээ, ямар үед бид чинь ер нь ард иргэдээ сайн сайхан амьдруулсан юм. Уруудна, дордоно гэдэг чинь боломжийн тэр түвшинд байж байгаа түүнээс доошоо уруудахыг л хэлж байгаа шүү дээ. Унахыг хэлж байгаа юм. Гэтэл ер нь яг үнэнээ хэлэхэд энэ 33 жилийн хугацаанд тэгж сайн байсан зүйл байгаа юм уу, дээшлүүлсэн байсныг нь унагаад уруудуулаад байгаа юм байгаа юм уу.

Сүүлийн үед бол яг л энэ нэг 4 жилийн хугацаанд бүхэл хулгай, луйвар хийчихсэн юм шиг, энэ улс төрчид нь энэ 4 жилийн хугацаанд л байгаа юм шиг юм ярьж байгаа шүү дээ. Угаасаа энэ ерөөсөө энэ төрийн хулгай, луйвар чинь бол аль зах зээлийн нийгэмд шилжих харилцаанд шилжихээс л эхэлсэн юм байна шүү дээ. 90 оны, 91 оны тэр өмч хувьчлалаас л эхэлсэн юм байна гэж би ойлгож байгаа шүү дээ. Тэр төр засаг, Сангийн яам, тэр нэгдэл, сангийн аж ахуйнуудыг хувьчлахаас л энэ асуудал өмчийг завиш, үнэгүйдүүлэх, хулгай луйвар эндээс л эхэлсэн гэж харж байгаа шүү дээ. Төр лүү гар дүрэх, төрийн өмч рүү гар дүрэх, төрийн өмчийг эзэнгүйдүүлэх, хийж чаддаг байсан ажлаа хийж чадахаа больсон Монголчууд өнөөдөр, арьс ширээ боловсруулдаг байсан чадахаа байсан. Оёдол, сүлжмэлийн үйлдвэрүүд бүгд ажилладаг байсан чадахаа байсан, ард иргэдээ хоол хүнсээр хангадаг байсан, Атрын 3 дугаар аян яагаад үүссэн гэхээр ерөөсөө газар тариалан, төмс хүнсний ногоогоороо ард иргэдээ хангаж чаддаг байсан юмаа чадахгүй болсон учраас л хийж чаддаг болъё гэж л ийм аян өрнүүлсэн юм байна лээ шүү дээ. Тийм учраас ерөөсөө энэ 33 жилийн хугацааны энэ хулгай луйвраас салъя. Энэ улс төрд хулгай луйврыг байхгүй болгоё. Улс төрчдөд хулгай хийх тэр нөхцөл бололцоог олгохгүй байя. Тэр цоорхойг бүх талаар нь хаая, ийм л байдлаар цаашидаа явъя гэдэг үүднээс өнөөдрийн энэ ажлууд хийгдэж байгаа гэж ойлгож байгаа.

Ганц 2 асуулт байна. Саалиа бэлдэхээр саваа бэлд гэж. Ингээд ямар ч байсан 126 болоод батлах юм шиг байна. 126 болохоор ер нь энэ чуулганы чинь танхим юм ер нь ямар болох юм, хаанаа хуралддаг байх юм, багтаж шингэх нь юу байгаа юм. Энэ талаар бодож төлөвлөсөн энэ зүйлүүд байгаа юм уу? Ингээд харахаар энэ дотор 76 чинь л чүүчээ багтах юм. Ахиад 50 гишүүнээр нэмэгдэхээр яаж энэ өрөө тасалгаа чуулганы энэ гишүүдийн байр савыг хэрхэн яаж төлөвлөсөн юм бэ? Бас л сандал ширээ хэрэгтэй болох байх даа.

Нөгөө талаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө баталчихвал энэ б сардаа багтаад Улс төрийн намуудын хууль, Сонгуулийн хуулиуд орж ирж батлагдах ёстой. Үүнтэй холбоотойгоор бас иргэдээс сая уулзалт хийж байхад маш чухал асуудлуудыг ярьж байна. Уламжилж дамжуулж өгөөрэй гэж хэлсэн. Тухайлбал Багануур дүүргийн иргэн Цэдэнсодном гуай гэхэд энэ намын жагсаалтаар сонгогдсон хүмүүсийг цаашидаа ер нь Засгийн газрын гишүүнээр сонгохгүй байх асуудал дээр анхаарч өгөөрэй л гэж байна лээ. Намын жагсаалтаар сонгогдсон улсууд гээд. Ашиг нь уг нь бол гишүүд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээж баймаар байна. Өнөөдөр бол хэлсэн үгэндээ хариуцлага хүлээдэггүй байгаа. Юу таарснаа, юу дуртайгаа хэлдэг, ярьдаг болсон. Хариуцлагагүй байдал газар авсан. Тийм учраас энэ хэлсэн ярьсандаа хариуцлага хүлээдэг баймаар байна. Төрийн өндөр албан тушаалтан болох тусмаа гарч байгаа үг хэл нь хариуцлагатай баймаар байна гэдэг асуудлыг иргэд чинь ярьж байна.

Нөгөө талаар Батмөнх гуай бол давхар дээлийн асуудал үр дүнгүй байна л гэж байна.

Нөгөө талаар энэ гишүүдийн халдашгүй бүрэн эрхийн асуудал гэж энэ халдашгүй байдлыг энэ хуулиар хамгаалагдсан байдлыгаа та нар болиоч

ээ гэдэг асуудлуудыг зөвхөн Батмөнх гуай биш маш олон иргэд хэлж байгаа юм. Маш олон иргэд хэлж байгаа юм. Энэ халдашгүй байдал нэрийн доор хулгай хийж болно, луйвар хийж болно, хууль хулгайлж болно, зээлийн сангаас мөнгө авч болно, үр хүүхдээ сургаж болно. Жирийн иргэд өнөөдөр банкны зээлийн хүүгээ нэг хоногоор хоцроовол банкнаас ямар их дарамттай, яаж данс юмыг нь хааж байгаа билээ. Гэтэл өнөөдөр эрх мэдэлтнүүд хэдэн мянган доллароор нь үр хүүхдүүдээ сургачхаад өнөөдөр түүнийг нь тэглэнэ гэдэг бол өнөөдөр үнэхээр шударга ёсонд нийцэхгүй байна л гэж жигшин зэвүүцэж байна шүү дээ. Тэглүүлж байгаа асуудал нь.

Тийм учраас цаашидаа энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ улс төрд нэр цэвэр, элдэв янзын хэл аманд орооцолдоогүй улсуудыг тэр намын жагсаалтад жагсаадаг байх, нийгмийн төлөөлөл, бүлгүүдийг оруулдаг байх ийм асуудлуудыг бүрдэнэ гэж, ийм асуудлууд бүрдэх юм гэж ингэж ард иргэдэд тайлбарлаж ярьж байгаа шүү дээ, бид бүхэн.

Тэгээд жилийн дараа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны үр дүн харагдах л байх. Цаг хугацааны хувьд. Тэгээд юу гэж ярьж байлаа, үр дүн гарсан уу үгүй юү гэдэг асуудлыг цаг хугацааны шалгуураар харагдана. Бахь байдгаараа байж байгаа бол байх бол тэгээд нэмсний хэрэг байхгүй шүү дээ, ер нь бол. Үүнийг асуухаар нэг их тоймтой хариулт ерөөсөө сонсохгүй өнөөдрийг хүрсэн, 3 удаагийн хэлэлцүүлгээр. Чанарын ямар ахиц өөрчлөлт гарах юм, ёс зүйн ямар өөрчлөлт гарах юм. Одоо ингээд сая Улсын Их Хурал дээр төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг баталсан. Бөөн юм болж баталсан. Гэтэл өнөөдөр энэ Боловсролын зээлийн сангийн асуудалтай холбоотойгоор энэ улс төрчид нар чинь энэ төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар ёс зүйн хариуцлага хүлээж байна уу. Баттөмөр дарга аа, та бид нарын ажлын хэсэгт орж ажилласан хууль.

Өнөөдөр хэн нэгэн улс төрч ёс зүйн хариуцлагаа хүлээгээд ухамсартайгаар уучлал хүлээж байгаа улс төрчийг би лав зурагт, телевизээр харахгүй. Тэгээд нөгөө хуулийн хэрэгжилт чинь ийм л байна шүү дээ.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Нямаагийн Энхболд хариулъя.

Н.Энхболд: Яг гишүүдийн тоо нэмэгдчихвэл танхим нь тэнд байна, ширээ сандлаа ингэж зохицуулна, ажлын байраа ингэж зохицуулна гэж яг энэ хөдөлмөр эрхлэх орчинтой нь холбоотой асуудлуудыг Байнгын хороо дээр, ажлын хэсэг дээр яриагүй, ер нь хэрэв энэ өөрчлөлт батлагдвал тэр асуудал гарцаа байхгүй хөндөгдөж таарна. Нэгэнт Үндсэн хуулиар асуудал ингээд шийдэгдчихвэл түүндээ зохицуулаад Засгийн газар, Монголын төр арга хэмжээ авч ажиллах нөхцөлийг нь бүрдүүлэх нь ойлгомжтой. Тэгэхээр яг нарийн тооцоо хийгээд тэгчихсэн юм бол байхгүй байгаа гэдгийг би хэлье.

Л.Мөнхбаатар: Сайнбуянгийн Амарсайхан, Сандагийн Бямбацогт, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя. Чимэдийн Хүрэлбаатар. Одоо Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьшаа: Өнөөдөр Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 3 дахь хэлэлцүүлэг хийж байна. Иргэд олон түмнээс Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудалд ямар үнэлэлт дүгнэлт өгч байгаа нь тодорхой байна. Гишүүдийн тоо нэмэхийг улс төрийн намуудын жагсаалтад эргэлзэх ийм асуудал иргэд сонгогчдын дунд түгээмэл байгаа нь тодорхой. Үүнтэй санал нэг байгаа.

Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийх ёстой. Улс төрийн нөхцөл байдал, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлууд

үүсээд байгаа гэдэг ийм дүгнэлтийн үүднээс энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэгт бол оролцож, сонгогчдын төлөөллийн хувьд байр сууриа илэрхийлж байгаа.

Бид 30 жилийнхээ улс төрийн төлөвшилийн асуудал, улс орны эдийн засгийн асуудал, нийгмийн хүрээнд болж байгаа үйл явдлууд 8 удаагийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан парламентын засаглалын асуудлуудыг бид өнөөдөр дүгнэж, хэлэлцэж, энэ Үндсэн хуулийн нэмэлтийг оруулж байгаа гэж ойлгож байгаа. 30 жилийн энэ хугацаанд 8 удаагийн сонгууль явуулж, парламентын засаглалын түүхэн 30 жилийн үйл явцыг өнөөдрийн өндөрлөгөөс бид харж дүгнэж, хэлэлцэж байна. Улс төрийн төлөвшилийн хувьд ч гацаанд орсон, төрийн үйл ажиллагааны ч хувьд гацаанд орсон. Эдийн засгийн хувьд ч цөхөрсөн ийм цаг үед бид үүнийг хэлэлцэж байгаа юм. Энэ өөрчлөлтийг бид өнөөдөр хийгээд 24 онд, 28 онд ч гэсэн үр дүн гарна гэдэгт тийм зорилгыг, тийм шинэ одоо өргөс авсантай адилхан асуудал гарахгүй. 20 жилийн дараа, 10 жилийн дараа Монголын улс төрийн төлөвшил, Монголын улс төрийн намуудын төлөвшил, Монголын Улс төрийн тогтолцооны төлөвшил сайн үр дүн авч ирж парламентын засаглалын хөгжил ирж, шинэ зүйл, аливаа асуудалд олонхын шийдлийг, шударгын шийдлийг шийддэг ийм төр засгийг бид байгуулаасай, ийм төлөвшил бий болоосой, ийм улс төрийн тогтолцоо бий болоосой гэдэг ийм шийдлийн үүднээс өнөөдөр бид энэ Үндсэн хуулийг хэлэлцэх үйл ажиллагаанд оролцож, улс төрийн хариуцлагатай намын хувьд улс төрийн намын шийдвэрээ гаргуулж, бүлгийн шийдвэрээ гаргуулж бид өнөөдөр оролцож байгаа юм. Монгол орон гацаанд орсон. Монголын төр гацаанд орсон. Авлига, хээл хахууль, улс төрийн ашиг сонирхол ард түмнийг өнөөдөр төрд итгэх итгэлийг, ард түмнийг өнөөдөр энэ улс төрийн намуудад итгэх итгэлийг ямар байдалд хүргэснийг бид өнөөдөр дүгнэж хийх ёстой. Бид энэ байдлаараа энэ хуучин 76-аараа энэ холимог

тогтолцоог оруулахгүйгээр бид цаашаа хэдэн жил явах вэ. Бид ямар үр дүнд хүрэх вэ гэдэгт бид өнөөдөр асуудлыг тавихыг хичээж энэ нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэгт оролцож, Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд ард иргэдтэйгээ улс төрийн намуудын тодорхой түвшинд ярилцаж тохиролцсон. Ялангуяа энэ нийгмийн төлөөллүүдийг энэ парламентын засаглалын үйл ажиллагаанд оролцуулах, улс төрийн намуудыг олон ургалч үзлийг Монголын улс төрийн үйл ажиллагааны төлөвшилд оруулах энэ шийдлийн хүрээнд өнөөдөр энэ Үндсэн хуулийн өөрчлөлт явагдаж байгаа. Бид өнөөдрийг энэ асуудлыг хэлэлцэж, энэ төлөвшлийг, энэ парламентын тогтолцооны гажуудлыг энэ төрийн үйл ажиллагаа гацсан, улс төрөөр авлигажсан намын эрх ашгаар дамжуулж нам дагасан бүлэглэлийн энэ асуудлыг энэ улс төрийн тогтолцооны шинэчлэл хэлбэрээр хийхгүй бол 2024 онд дараагийн 76 гарч ирээд л дахиад л энэ асуудал ноцолдсон, зууралдсан, эрх ашгаа хамгаалсан, авлига, хээл хахууль төрийн өмч хөрөнгийг луйварддаг, хулгайлдаг, аливаа төрийн хөрөнгө, мөнгөөр бий болсон сан хөмрөгүүдийг хоосолдог энэ тогтолцоо чинь үргэлжилсээр байх болно гэсэн ийм бодлогын үүднээс энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг хийж байгаа энэ үйл явцад идэвхтэй оролцож байгаа. Энэ асуудлыг өнөөдөр бид хийхгүйгээр, парламентын төлөвшлийн асуудлыг хийхгүйгээр бид энэ байдалтайгаа бахь байдалтайгаа эвлэрээд дараагийн сонгуультайгаа, дараагийн 30 жил жилтэйгээ бид золговол Монголын ирээдүй, бидний үр хүүхдийн ирээдүйн асуудалд бас ямар үр дагавар хийх вэ гэдэг дээр бид дүгнэлт хийх ёстой гэж ойлгож байгаа.

Нөгөө талаасаа дэлхий нийт тийн хүрээнд өнөөдөр геополитикийн том хуваагдал бий болж, дэлхий ертөнц 2 туйлд хуваагдаад байна. Монгол орны тухайд бид 2 их том гүрний дунд оршин тогтнодог. 2 их гүрний бодлого Америкийн Нэгдсэн Улс тэргүүтэй

гаднын бодлогын зөрчилдөөн, сөргөлдөөн, үндэсний аюулгүй байдлын асуудалд харшлах хэмжээнд ирэх ийм үйл явц бий болох цаг хугацаа байхыг ч үгүйсгэхгүй байгаа. Энэ үед олон ургалч үзлийг олон парламентын гишүүнтэй байж байж аливаа асуудал дээр зарчимтай, бодлоготой байх бас нэгэн ийм шинэ кэйс гарч ирсэн гэж ойлгож байгаа. Ийм учраас энэ асуудлыг бид 30 жилийн дараах улс төрийн төлөвшил, 30 жилийн дараах үйл явдалд тохируулж энийг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Адьшаа гишүүний хувьд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан байр сууриа илэрхийлж үг хэллээ. Асуулт байхгүй гэж ойлголоо. Чимэдийн Хүрэлбаатар. Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Үндсэн хууль бол зөвшилцлийн баримт бичиг гэдэг. Намуудтай зөвшилцсөн. Манай дарга нар бол намуудтай зөвшилцсөн 152 гэсэн, дараа нь 126 болоод ингээд явж байна л даа. Тэгэхдээ намын дарга нар суугаад зөвшилцөх нэг өөр. Бодит байдал дээр тухайн намын гишүүд ямархуу бодол саналтай байна гэдэг зөвшилцөл бол хангалтгүй хийчихсэн юм болов уу гэсэн ийм дүгнэлт хийж байгаа. Тухайлбал Дархан-Уул аймагт байж байгаа тэр намуудын төлөөлөл бол манай төв намаас бидэнтэй энэ талаар ямар ч уулзалт хийгээгүй, зөвшилцөл хийгээгүй ээ гэж. Бид 3 гишүүн очиж гурвуулаа уулзалт хийсэн. Гурвууланд нь хэлсэн. Манай зарим гишүүд өчигдөр яг энэ талаар бол мэдээлэл хийж байх шиг байна лээ. Ийм байдалтай байгаа юм аа. Тэгээд Үндсэн хуулийн энэ өөрчлөлт бол ард түмний хүсэн хүлээсэн тэр зүйлийг л бид хийх ёстой юм л даа. Тэгээд ард түмэн юу гэж байна гэхээр зэрэг та нарын 152 байна уу, 126 байна уу, 76 байна уу бид нарын амьдрал яагаад дээшлэхгүй байна. Энэ үнийн өсөлт чинь идүүлж дууслаа шүү дээ энэ чинь. Энэ өвчлөл чинь бол замаа алдлаа шүү дээ. Энэ байгаль орчны сүйрэл чинь харанга дэлдэж байна шүү

дээ. Та нар улс эх орноо авч явж чадах юм уу, үгүй юу гэдэг ийм л асуултыг бидэнд тавьж байгаа юм. Тэгэхээр бид одоо энд хэдэн хүний тоо нэмнэ, 126 болно гээд л явж л байгаа байх. Ер нь аливаа шинэчлэл бол өөрчлөлт бол шинэчлэлийг л агуулдаг. Энэ утгаар бол 126 болоод сайн сайхан болохыг бол үгүйсгэхгүй. Ер нь бол манай Дархан-Уул аймгийн иргэдийн хувьд бол олонх нь бол энэ гишүүдийн тоог нэмэхийг бол дэмжихгүй л байсан. Үүнийг би өнөөдөр бас төлөөлж байгаа хүний хувьд бас хэлэх нь зүйтэй гэж ингэж бодож байгаа юм. Ингээд Үндсэн хууль 76 гишүүнтэй, нэг танхимтай Үндсэн хууль мөрдөгдөөд 32 жил болжээ. Ямар алдаа байв, ямар оноо байв гэдгийг бид яг гаргаж тодорхой хэлэхгүй л байгаа юм л даа. 76 Ерөнхий сайдтай болчихсон, 126 болохоор авлигал багасна. Тэгээд л нэг ийм жишжүүрийн л юм яриад байгаа байхгүй юу. Эндээ биш юм л даа. Ямар өөрчлөлт хийх вэ, ард түмний амьдралд яаж өөрчлөлт гарах вэ. Ер нь энэ хөгжил гэдэг чинь өөрөөр хэлбэл ардчилал гэдэг чинь сайн сайхан, ардчилсан нийгэмд амьдарна гэдэг чинь сайн сайхан амьдрахыг л хэлж байгаа шүү дээ. Бид нар маш олон үзүүлэлтээр 1990 оны түвшинээс доошоо орчихсон байж байгаа шүү дээ. Тэгээд энэ 30 жилийн хугацаанд чинь юу болоод өнгөрчхөв. Ямар дүгнэлт хийж байгаа юм бэ. Хүн амын 42,5 хувь нь ядуурчихсан байна. Гадаад өр 33,4 тэрбум доллар. Улсын өрийг ингээд тооцох юм бол тэр ДНБ 80 90 хувь хүрчихсэн. Азийн хөгжлийн банкны зарлаж байгаагаар бол ядуу орон гээд зарлачихсан. Хорт хавдар, ядуурлаараа дэлхийд тэргүүлж байгаа. Баян хоосныхоо ялгаагаар дэлхийн чихийг дэлдийлгэж байгаа шүү дээ өнөөдөр. Монголд бол олигархийн олигархижсан загвар яригдаж байна шүү дээ. Явж байна шүү дээ. Нийт баялгийн бараг 80-аас илүү хувь нь хүн амын 3, 4 хувьд оногдож байна шүү. Баян хоосны ялгаа бол дэлхийн чихийг дэлдийлгэж байгаа шүү. Тархины гоожилт чадвартай улсууд нь гадагшаа явчихдаг. Эдийн засгийн дүрвэлт ийш тийш нь очиж амьдрах, амьдралаа залгуулах гээд хөдөлмөр хийх

гээд гадагшаа явчихдаг. Баялгаараа эхний 10-д ордог мөртөө ядуу улс. Баялгийн хараалд орчихсон, чөтгөрийн тойрогт орчихсон. Энэ тойргоос гарахад бол 10 жил хэрэгтэй шүү. Дор хаяхад. Тэгээд ийм л үр дүнтэй л байна л даа. Тэгээд энэ 76 хүн цөөдөөд ийм болчхов уу. Хөгжил яагаад ингээд гагцхав гээд ингээд бодохоор ерөөсөө энэ 76 хүндээ биш, парламентын засаглалдаа биш, хүндээ л байгаа байхгүй юу. 2 Хөрш бол Монгол Улстай бол маш сайхан харилцаатай. Хойд хөршөөс бол эрчим хүчний чиглэлийн бүх импортоо авч байгаа. Урд хөршид бол бүх баялгаа гаргаж байгаа. 3 дахь ертөнц Монголд тусалж байгаа. Яагаад ийм болчхов гэхээр зэрэг Монголчууд бидний хөгжлийн бодлого, төлөвлөлт буруу байна. Хөгжлийн загвар буруу байна. Яваад байгаа зам маань буруу байна. Тэгээд дээрээс нь энэ хүний бодлого. Хүн хөгжүүлэхгүй. Монгол хүн, Монгол улсаа л хөгжүүлсэнгүй шүү дээ. Засгийн газар байгуулдаг. Унагаадаг. 1,6 жилийн настай засагтай. Төрөөрөө айл гэр болж тоглосон ийм л одоо байдалтай байгаа байхгүй юу. Ерөөсөө энэ хоцрогдлын гол шалтгааныг хайя гэвэл ерөөсөө улс төрийн энэ тогтолцоотой холбоотой, хүнтэй холбоотой юмаа л сайн хийх ёстой. Өнөөдөр хулгай гээд л бид нар яриад байна шүү дээ. Хүн л хулгай хийгээд байгаа шүү дээ. Төр хамгийн муу менежер гээд байдаг. Төрд сайн хүн тавих юм бол төр сайн менежер байж чадна. Төр бодлогоо зөв гаргах юм бол сайн менежер байж чадна. Хулгай хийдэг хүн гаргаж тавьчхаад тэгээд муу менежер гээд ийм л байгаа байхгүй юу. Одоо манай намын хувьд бол социал демократ үзэл баримттай гэж байгаа юм. Тэгтэл манай энэ хөгжлийг хариуцсан улсууд нелиберал загвар яриад л. Тэр нөгөө үл үзэгдэгч гар мар гэдэг чинь 2000 онд хаалгаа хаачихсан юм шүү дээ. Тэр үед энэ сүүлийн үед энэ геополитикийн, ковид гээд Дэлхий нийтийн ийм юмтай холбогдуулаад төр бодлогоо зөв тодорхойлоод, зохицуулалтаа зөв хийж чадах юм бол улс, эх орон хөгжиж байна шүү дээ. Одоо манай урд хөршийн загвар. Хурдтай

хөгжлийн загвар, хуримтлалтай хөгжлийн загвар. Бид хурд ч алга, хуримтлал ч алга. Тийм учраас бол энэ улс төрийн шинэчлэл хийх гэж би оролдож байна гэж ойлгож байгаа. Улс төрийн шинэчлэлийг эдийн засгийн шинэчлэлтэйгээ хамтарч хийх ёстой. Энэ 126 гэдгийн цаад талд бол эдийн засгийн ямар шинэчлэлүүд явагдах вэ. Төрийн бодлого маань энэ 30 жилийн хугацаанд яагаад ийм хоцрогдол чөтгөрийн тойрогт орчхов оо. Эндээ дүгнэлт хийх ёстой. Хамгийн гол асуудал бол энд л байгаа юм. Түүнээс биш 126 болоод их сайн сайхан болчихно гэж бол утгагүй л байна л даа. Тийм учраас бол алдаа дээрээсээ зөв сургамж авах ёстой. Яаж засах вэ. Одоо энэ чинь 21 дүгээр зуунд гуравхан сая хүнтэй. 1,5 сая хавтгай дөрвөлжин километр газар нутагтай. Геополитикийн хувьд их сайн байришилтай. Асар их хөгжлийн боломж байна шүү дээ. Гэтэл одоо ийм ядуу байгаад байж болохгүй шүү дээ. Эндээ ер нь дүгнэлт хийх асуудлыг мэдэхгүй, энэ яригдахгүй л байгаа юм. Би энэ сүүлийн 2000 оноос хойш ингээд хараад байхад ерөөсөө энэ дээрээ тогтоож ажиллахгүй, ярихгүй байгаа юм. Тийм учраас гол асуудал руугаа орох нь зүйтэй. Миний бодож байгаагаар бол ер нь бол 76 байгаад ийм хөгжлийн хоцрогдолд ороогүй шүү. Төрийн бодлого буруу, дээрээсээ хүнтэй ажиллах ажиллагаа байсангүй. Энэнээс болж Монгол улс хоцрогдсон гэдгийг би хэлэх гэж байгаа юм. Асуулт алга санал хэллээ.

Л.Мөнхбаатар: Нанзадын Наранбаатар. Батсуурь гишүүн байхгүй байна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя. Дараа нь Идэрбат гишүүн. Ингээд 2 гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа цуглаарай. Дараа нь бол зөвхөн саналын томьёолол дээр үг хэлж болно. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Бид бол ингээд 2 удаа орон нутагт иргэд, сонгогчидтой уулзлаа. Олон хүмүүс санал онол хэлж байна. Ялангуяа энэ ойрын хугацаанд амьжиргаатай холбоотой, цалин тэтгэврийн зөрүү гаргах, цалин тэтгэвэр нэмэгдүүлэх, үнийн өсөлттэй холбоотой энэ асуудлууд дээр тодорхой шийдэл гаргаач гэсэн ийм санал хэлсэн. Улсын Их Хурал, Засгийн газар дэс дараалалтай арга хэмжээ авч байна. Нөгөө нэг юм бол би энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийтлэгээрээ гарч байгаа асуудлууд ч бий. Дээрээс нь би өөрийнхөө санал онолыг хэлье. Ер нь Их Хуралд 5 удаа сууж ажилласан энэ он жилүүддээ би нэг тодорхой юм л хэлээд байгаа юм. Энэ юу вэ гэхээр зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, Улсын Их Хурлын гишүүд аливаа нэг асуудалд холбогдох юм бол, яригдах юм бол энийгээ олон нийтэд баримттай, нотолгоотой тайлбар өгч бай. Цаашилах юм бол нэр дэвшүүлсэн нам нь энэ улсуудаа үнэн мөнийг нь ол гэдгийг нь араас нь шаарддаг, шахдаг байх хэрэгтэй. Түүнчлэн хуулийн байгууллага энэ холбогдох газруудаар үг дуу байхгүй очоод шалгуулдаг, үүнийгээ тогтоодог ийм байх хэрэгтэй гэж 4, 5 бүрэн эрхийн хугацаанд асуудал тавьж ирлээ. Үүний цаад талд ямар ач холбогдол байна гэхээр зэрэг наанадаж энэ дэвшүүлсэн нам хамт олны нэр хүнд, хамгийн гол цаад талд нь энэ Монгол төрийн нэр хүнд байгаа юм аа. Энэ чинь энд сууж байгаа нэг хүн гэдэг бол тэр хувийн нэр хүндийн тухай асуудал байхгүй шүү дээ. Төрийн нэр хүндийн асуудал. Тийм учраас ийм нэг зарчмыг тогтоо гэж олон жил шаардсан. Тэгээд харамсалтай нь энэ хэрэгжихгүй юм. Ингээд нийтээр нь бүгдийг нь 76 хулгайч мэтээр ингээд нийгэмд ойлгогдоод байдаг. Арга байхгүй. Үүнээс өөр арга байхгүй. Яагаад гэвэл тэр хүмүүс нь үнэн мөнийг нь араас нь хөөцөлдөж, олж тогтоож, тайлбар хийж, хэрвээ нотолгоогүй ташаа мэдээлэл гаргасан байвал тэр гаргасан хүмүүс нь уучлал хүсдэг. Хэрвээ үнэхээр тэр мэдээлэл нь үнэн баттай байх юм бол хариуцлагаа

хүлээдэг ийм нэг жишигтэй байх юм бол өнөөдрийн ийм байдалд хүрэхгүй гэсэн ийм тодорхой байр суурийг хэлж явж ирсэн.

Манай Даваасүрэн байна. Бид нар бол энэ гарсан мэдээллийн дагуу цагдаа, хуулийн байгууллагад өгдөг. Тэгээд хуулийн, цагдаагийн байгууллага ямар ч нотлох, тогтоогдох юм алга гээд ингээд хариу өгчихдөг. Нөгөө мэдээллээ гаргасан хүн албан ёсоор уучлал гуйна. Ингээд одоо тараачихлаа гээд ингээд хүрээд ирдэг ийм нэг байдалтай. Тэгэхээр ийм байдлаараа явж болохгүй л гэж би ийм зүйлийг л хэлэх гээд байгаа юм. Өнөөдөр энд сууж байгаа олон Их Хурлын гишүүд, үе үеийн парламентад сууж байгаа хүмүүс бүгдээрээ үл бүтэх этгээдүүд байгаагүй шүү дээ. Энд нэг цөөхөн хэдэн хүмүүсийн асуудлаас болоод л ингээд л нийтээрээ. Нэг үхрийн эвэр доргивол, мянган үхрийн эвэр доргидог энэ жишигээр яваад байдаг. Энд орж ирсэн хувийн ашиг завшаан хайсан цөөхөн хүмүүсийн энэ муу халдвар цаашаа төрийн дунд шатад, бүүр цаашилах юм бол энэ анхан шат руугаа биеллээ олоод биежээд байдаг ийм л асуудлууд байна шүү дээ. Тэгээд энэ асуудлуудаа нэг талд нь гаргах хэрэгтэй. Би яагаад ийм асуудал яриад байна вэ гэхээр зэрэг түрүүн Баттөмөр гишүүн ч хэллээ. Энэ хүний асуудал байгаа юм. Хүний хүчин зүйлээс шалтгаална. Бид тогтолцоо өөрчилж болно, тоо өөрчилж болно. Хэчнээн сайн хууль баталж гаргаж болно. Хамгийн гол нь энэ хүний асуудлаас шалтгаалаад байгаа юм. Энэ Улсын Их Хурлын хэмжээнд гэхэд олон сонгогдсон нас ахмад эсвэл эрэгтэй, эмэгтэй, эсвэл анх удаа сонгогдсон залуу гэдгээс шалтгаалахгүй байна шүү дээ. Асуудалд орооцолдож байгаа, хэл ам таталж байгаа хүмүүс аль аль нь л байна шүү дээ. 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр 40 гаран залуу гишүүн сонгогдлоо. Үгүй ээ, анх удаа залуу хүмүүс сонгогдож байна. Хачин жигтэйхэн сайхан юм болох нь ээ л гээд бид шагшиж магтаад л сайхан л байцгаасан. Гэтэл өнөөдөр бодит байдал

дээр ямар байна вэ. Иймэрхүү л байдалтай байж байгаа. Тийм учраас энэ хүний үзэл ухамсар, хүний төлөвшил, сахилга, хариуцлагатай, ёс зүйтэй холбоотой асуудал гол жин дарна аа. Ийм байр суурьтай байдаг хүн байгаа юм. Энэ талаас нь гол юмыг нь зохицуулах, ялангуяа энэ боловсон хүчин, хүний нөөцийнхөө асуудлыг шийдэж байдаг энэ улс төрийн намуудын хуулийн тухай асуудал, цаашилах юм бол улс төрийн намын санхүүжилтийн асуудлыг бие даасан энэ хуулийнх нь зохицуулалт юмнуудыг нэг талд нь боловсронгуй болгож ингэж гаргах хэрэгтэй байгаа юм. Ийм тодорхой зүйлүүдийг хэлье. Өнөөдөр бол яах вэ, энэ 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд бол энэ улс төрийн намууд энэ Улсын Их Хуралд энэ улс төр лүү оръё гэсэн хүмүүс бол ер нь тодорхой сонголт хийж байж орохоос өөр аргагүй ийм байдал руу орчихсон. Яагаад гэвэл эхний ээлжид бол бид энэ шатны гишүүрийг дээрээс нь шүүрдэх ёстой гэдэг энэ зарчмыг хатуу тавьж, шаардаж байж Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээр нэлээн нарийвчлаад тусгаад өгчихсөн. Тэгээд Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хууль байна. Төрийн хэмнэлтийн хууль байна. Энэ цагаан захтнуудын үйлдсэн гэмт хэрэг, авлига, хээл хахууль, хулгайн худалтай холбоотой асуудлыг цэгцэлсэн, ялын бодлогыг нь чангаруулчихсан Эрүүгийн хууль байна. Төрийн хэмнэлтийн хууль хэлсэн. Ингээд Засгийн газраас санаачилж оруулж ирж байгаа Нийтийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх энэ хуульд оруулж байгаа улсын Ерөнхийлөгчөөс эхлээд Ерөнхий сайд, Их Хурал, Засгийн газрын гишүүд, Агентлагийн дарга, дэд дарга нар төрийн худалдан авалт тендерт оролцдоггүй. Төр ард түмний нэр барьж авсан зээл, бонд элдвийн хөнгөлөлттэй сангийн юманд халхай зуузай байх энэ хууль Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэх нь шийдэгдээд явж байна. Ингээд нэг ийм хуулийн зохицуулалтад, тэгээд дээрээс нь энэ Улс төрийн намын хуулиараа тэр улс төр рүү орж байгаа, энэ төр рүү орж байгаа

хүмүүсийн ёс зүй, төлөвшил, хариуцлага, сахилга баттай холбоотой юмнуудыг нь хүнээ олоод тавих юм бол ер нь харьцангуй юм тодорхой болох байх. 2024 оны сонгуулиар дээр дурдаж байгаа энэ хуулийн хайрцагт бол ажиллах уу эсвэл хувийнхаа бизнес хувийнхаа салбарт ажиллах уу гэдгээ ийм сонголт дээр ирнэ. Нэлээн юмнууд бол тодорхой болно гэсэн ийм ойлголттой байгаа. Ийм зүйлүүдийг хэлье. Би бол асуух юм алга. Санал, байр сууриа тодорхой илэрхийлж байгаа хэрэг ээ. Баярлалаа та бүхэнд.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний хувьд бол бас бусад гишүүдийн л адил тойрогтоо 2 удаа явж Бат-Эрдэнэ гишүүн бид 2-ын хувьд бол Хэнтий аймгийнхаа бүх сум, сууринуудаар явж энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлын 1, 2 дугаар хэлэлцүүлгүүдийг хийж, тэндээс гарсан ард иргэдээс хэлсэн санал, хүсэлт, бүх л зүйлүүдийг нэмж хачирлалгүйгээр бас холбогдох газрууд нь уламжилж ингээж л ажилласан. Тогтолцооны хувьд бол иргэд олон нийтээр сонгогчдын санал гээгдэхгүй байх, тэр тойрог шүтдэггүй байх, тойргийг ямар нэгэн байдлаар өөрт давуу байдал олгодог, ашигладаг, мөнгө төгрөг, бэлэг сэлт тараадаг барьдаг энэ бүх зүйлээс бол иргэд бол бас ойлгож, энэ тогтолцооны өөрчлөлт гэдэг зүйлийг бол бас дэмжиж байна. Тоог бол мэдээж 152-ыг дэмжихгүй. Сая 126 гээд ингээд танилцуулаад явахад ч бас олон л байна гэдэг ийм л зүйлийг бас ярьж байгаа юм. Тэгэхдээ бид олон байна гэдэг, яагаад одоо олон байна гэдэг энэ тооноос татгалзаад байна вэ гэхээр цаад шалтгаан нь бол энэ урд өмнөх 30 жилийг дүгнэдэг, цэгнэдэг нь бас би ч биш байх. Гэхдээ ард иргэд бол энэ замбараагүй явсан 30 жил дахиад ингээд цаашаа үргэлжилбэл яах юм бэ. Ингээд дахиад л замбараагүй хүмүүсийнхээ тоог нэмбэл яах юм бэ гэсэн ийм үндсэн гол татгалзах шалтгаан л байгаа юм билээ. Тийм учраас

ер нь бол харин ч ард иргэд бол өөрчлөгдөөсэй. Энэ байдлаараа бол бас хэцүү болж байна гэсэн ийм зүйлүүдийг ч бас ярьж байгаа юм ярьж байгаа юм. Тэгэхээр бид нар тоо тэдийг дэмжихгүй байна гэж ингээж зөвхөн тоог яриад байгаа болохоос биш дэмжихгүй байгаа учир шалтгаан нь бас юу юм бэ гэдгийг бас би энд ярих нь зүйтэй болов уу гэж бас бодож хэлж байгаа юм.

Тэгээд өнөөдрийн энэ чуулган дээр хэлж байгаа үг ч гэсэн миний хувьд бол яг л иргэд олон нийттэй Үндсэн хуулийн энэ өөрчлөлттэй холбоотой асуудлаар ярьж, хэлж байсан зүйлүүдээ л энэ чуулганы танхим бас хэлэх гэж байгаа юм. Энэ явж ирсэн гэдэг үү, энэ замбараагүй гэдэг үү энэ байдал бас тодорхой хэмжээнд цэгцлэгдээд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ энэ бүх зүйлүүд үр дүнгээ өгөөд 30 жилд анх удаа бид нар төсвийн орлого нь хугацаанаасаа өмнө давж орж ирээд өнөөдөр цалин цагаа, тэтгэвэр, зургаахан сарын өмнө хүүхдийнхээ мөнгийг 100 хувь өгч чадахгүй байсан эдийн засаг өнөөдөр бүр нөхөж олгох хэмжээнд хүртэл ирээд өөрчлөлтүүд гарч эхэлж байна. Тэгэхээр тодорхой хэмжээнд эдийн засаг дээр энэ өөрчлөлт орж байгаа бүх зүйлүүдийн үед одоо Үндсэн хуулийг хэрвээ Улсын Их Хурал батлах юм бол ганц ингээд тогтолцоогоо өөрчлөөд, тоогоо нэмээд зогсохгүйгээр дараагийн Үндсэн хуулийн өөрчлөлт оруулсан энэ агуулга бүтэн утгаараа ард иргэдийн хөрсөн дээр буух улс орны амьдралд нөлөөлөх өөрчлөлтүүдийг энд байгаа Улсын Их Хурлын гишүүд бас улс төрийн зориг гаргаж, улс орны цаашдын хувь заяаг бодож бас дараагийн хуулиудаа ч гэсэн би бол цаг алдалгүй батлах ёстой гэж ингээж бодож байгаа юм.

1 дүгээрт энэ Сонгуулийн хуулийн өөрчлөлт энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг хүлээгээд байж байгаа байх. Сонгуулийн хуулийн өөрчлөлтийг бид бас зоригтой хийх ёстой байх. Энэ мөнгөнөөс хараат бус байх. Яагаад энгийн багш хүн орж

ирдэггүй, эмч хүн орж ирдэггүй. Яагаад 32 жилийн парламентын түүхэнд Намхайнямбуу гэдэг малчин ганцхан удаа энэ 600 гаран гишүүдээс орж ирэв. Энэ болгон бол бас мөнгөнөөс хараат бус явсны хараат явсны илэрхийлэл байх гэж ингэж үзэж байна. Тийм ч учраас Улсын Их Хурлын энэ дараа дараагийн сонгуулиуд мөнгөнөөс хараат бус байж, энэ танхимд бас ард иргэдийн төлөөлөл, сэхээтэн, мэргэжилтэн, судлаачид, магадгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гадаадад байгаа иргэдийн төлөөлөл энэ танхимд ороод ирээсэй гэсэн утгаар энэ Үндсэн хуулийн өөрчлөлт бас явагдаж байгаа гэж харж байгаа. Тэгэхээр бид Үндсэн хуулиа өөрчлөөд зогсохгүйгээр дараагийн энэ хуулиудаа бас өөрчлөх хэрэгтэй.

Дараа нь тэр ашиг сонирхлын хууль гэж яриад байгаа юм. Үнэхээр Улсын Их Хурлын гишүүн болох эсэх нь өнөөдөр таны явуулж байгаа бизнес, таны гэр бүлийн гишүүдийн цаашидын карьер гэдэг юм уу энэ бүхэнтэй шууд хамааралтай болж байгаа учраас энэ Ашиг сонирхлын хуулийг зүгээр хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явчихсан энэ хуулиа үргэлжлүүлээд Монгол Улсын парламент бас дэмжээд Улсын Их Хурлын гишүүн болохоороо л бизнес нь төрийн дэмжлэг аваад явчихдаг, хамаарал бүхий этгээдүүд нь төрийн өндөр албан тушаалд оччихдог, янз янзын хөнгөлөлттэй зээл хаана юу байна тэрийг бүгдийг нь авчихдаг ийм байдлыг бүр хааж өгөх нь зүйтэй. Тэгэхээр энэ хуулийг ч гэсэн бас яаралтай батлах хэрэгтэй.

Дараа нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн барьчихсан энэ Улс төрийн намын тухай хуулийг ч гэсэн энэ парламент маш өргөн цар хүрээнд ярьж, энэ улс төрийн намын хуулиа ч гэсэн бид нар бас нэлээн сайн өөрчилж өгөхгүй бол дээгүүрээ Манан болтлоо гэтлээ нэгдчихээд, яг ард иргэдээ болохоор хэдэн намаар хуваагаад ингээд талицуулаад байдаг ийм нөхцөл байдал бас дахиад битгий цаашаа яваасай билээ. Тийм

учраас Улсын Их Хурал өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрвээ баталбал энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн үр ашиг шууд нөлөөлөх утгаараа энэ Ашиг сонирхлын хууль, Улс төрийн намын хууль, Сонгуулийн хууль энэ бүх зүйлүүдээ бас давхар яаралтай өөрчлөөд ингээд явах юм бол өнөөдөр бид нар 126 энэ тогтолцооны өөрчлөлт гэж олон хоног ярьсан, хэлсэн. Ард түмнээ бас бухимдуулсан, учирласан энэ бүх зүйлүүд үндсэн утгаараа бол би хэрэгжинэ л гэж ингэж харах гэж байгаа юм. Тийм учраас энэ хуулийг бас энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үр дүнтэй болгоё гэвэл хийх хэрэгтэй байх. Хэрвээ бид нар Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийж, тогтолцоо тоогоо нэмж ингэж өөрчилчхөөд, дагаад энэ Улс төрийн намын хууль, Сонгуулийн хууль, Ашиг сонирхлын хуулиа батлахгүй байх юм бол Үндсэн хуулийн өөрчлөлт бас би бүрэн утгаараа хэрэгжиж чадахгүй байх болов уу. Тийм учраас парламентын гишүүд энэ дээр бас маш эр зоригтой манлайлалтай ингэхгүй бол магадгүй ард иргэд маань энэ Ардчилсан парламентын засаглалд эргэлзэх, Ардчилсан Монгол Улс цаашидаа байх эсэх дээр ч гэсэн нөлөөлөх ийм том эрсдэл бас гарч байгаа гэдгийг хэлье гэж ингэж бодож, энэ 20 гаруй гишүүдийн хамгийн сүүлд нь нэрээ өгч, энэ парламентад 57-оос илүү Их Хурлын гишүүд орж ирсэн хойно нь үгээ хэлье гэж бодож бас энэ үгийг хэлж байгаа юм гэдгийг бас би зориуд хэлэхийг хүсэж байгаа юм. Надад бол асуулт байхгүй. Энэ зүйлүүдийг л бид дараа дараагийн үйл ажиллагаандаа анхаарлаа хандуулах ёстой шүү л гэж ингэж хэлье гэж бодсон. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч бас үг хэлж дууслаа. Байнгын хорооны гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулна. Саналын томъёоллыг 10 минутад багтааж Байнгын хороо тайлбарлаж болно. Дэмжсэн, дэмжээгүй

цөөнх үг хэлж болно. Тэгээд заалт дээрээ л ярина. Ганицхан санал хураалт байгаа.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Төслийн 1 дүгээр зүйл буюу 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан зургаан гишүүнийг олныг төлөөлөх, тавин гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно.” гэснийг “Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Үг хэлэх гишүүдийг Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Дашидондогийн Ганбат гишүүнээр тасаллаа.

Б.Пүрэвдорж: Ер нь бол хууль бол бичдэг техникүүд байдаг. Тэгэхээр ер нь бол Үндсэн хууль бас өөрөө ийм бичилтийн техниктэй. Тэгэхээр та бүхэнд би ингээд сануулъя. Энэ 30 дугаар зүйл дээр Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн Монголын ард түмний эв нэгдлийн ерөнхий илэрхийлэгч мөн гэж биччихээд, дараачийн 31, 32 дээр яадаг вэ гэх дээр шууд ерөнхийлөгч гээд ерөнхийлөгчийн, ерөнхийлөгч нь гээд ингээд явчихдаг байхгүй юу даа. 38 дугаар зүйл дээр Монгол Улсын Засгийн газар бол Төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн гэж бичиж байгаа. Монгол Улсын Засгийн

газар. Тэгчхээд 40 дүгээр зүйл энэ тэр дээр болохоор Засгийн газар гээд ингээд шууд явчхаж байгаа юм. Тэрэнтэй адилхан 20 дугаар зүйл дээр Монгол Улсын Их Хурал бол Төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Монгол Улсын Их Хурал хадгална гээд Монгол Улсын Их Хурал гэж тодорхойлж орж байгаа. Тэгчхээд 21 дүгээр зүйл дээрээ одоо байгаа бичилтийн техникээр бол Улсын Их Хурал нэг танхимтай гэж байгаа. Монгол Улсын Их Хурал гэж байхгүй байхгүй юу даа. Тийм учраас энэ анхнаасаа энэ бичигдсэн энэ техникийнх нь дагуу тэр Монгол гэдэг үг үгийг нь авч хаяад энэ Үндсэн хуульд бичигдсэн, анхнаасаа бичигдсэн тэр техникийн дагуу оруулж өгөөч л гэсэн ийм санал байгаа юм. Өөрөөр хэлбэл 21 дүгээр зүйл дээр одоо Монгол Улсын Их Хурал гээд нэг танхимтай гэж байна шүү дээ. Тийм ээ, тэгэхээр Улсын Их Хурал нэг танхимтай гээд л бичээд явчихвал нөгөө техникийн хувьд бол зөв болох гээд байна гэж хэлэх гээд байна. Энийг найруулга дээрээ яаж явдаг юм, дэгээрээ яаж шийдэх ёстой юм

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүний хэлсэн саналыг би бас түрүүн сүүлд уншиж үзээд нөгөө 7 хэмжигж, нэг огтол гэвэл тэр Монгол гэдэг үгийг Үндсэн хуулийн бичиглэлийн хувьд засаж найруулах ёстой юм байна гэж бодож байсан. Пүрэвдорж гишүүнд ч хэлчихлээ. Бусад бүх заалт дээр дандаа Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар гээд цаашидаа дандаа Улсын Их Хурал, Засгийн газар гээд явчхаж байгаа юм. Тийм учраас энэ дээр Монгол гэдэг үг бол Үндсэн хуулийн бичиглэлийн хувьд илүүдэж байгаа нь бол үнэн байна лээ. Тэгэхээр энэ дэгийн хууль дээр бас нэг ийм зөрчил гараад байна. Тамгын газар, ажлын хэсгийг анхаарахгүй бол. Энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 15.2 дээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24^б.2-т заасан үндэслэлээр гаргасан саналын томъёоллыг уншиж, томъёолол тус бүрээр санал хураана гэж

байгаа юм. Одоо үүгээр санал хураалт явах гэсэн чинь Дэгийн тухай хууль дээр 24⁶.2 гэж байхгүй байгаад байгаа юм. Дэгийн хуулийн 24⁶.2-ийг дэгийн хуульд өөрчлөлт оруулахдаа хасчихсан юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ нэг ийм хийдэл үүсээд байгааг анхаарна биз. Ер нь агуулгын хувьдаа бол Төрийн байгуулалтын байнгын хорооноос энэ хуулийн 51.2-т заасан саналын томъёолол тус бүрээр санал хураалт явуулна гэсэн. Тэгээд үг хэлж болно гэсэн ийм санал хураалтын дэгээр явна. Энэ гишүүд гаргаж байгаа саналын томъёолол гэж үзнэ. Тийм учраас найруулгын саналыг протоколд тэмдэглээд Монгол гэдгийг хасаад явчхаж болж байна уу гэдгийг редакцын засвараар хянан тохиолдуулъя гэж үзээд ингээд ийм агуулгаар санал хураалт явуулчихыг зөвшөөрч байна уу. Ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд.

Н.Энхболд: Найруулгын байдалтай засвар хийгээд ингээд санал хураахыг зөвшөөрч байна. Та уншихдаа тэр үгийг нь хасаад л унших. Тэгээд таны уншсанаар тэмдэглэгдээд явчихна.

Г.Занданшатар: Редакцын засвараар буюу найруулгын засвараар энэ үгийг авахаар боллоо. Ингээд санал хураалт явуулна. Санал хураалтыг. Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлэх юм байна. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ өөрчлөлт бол мэдээжийн хэрэг нэлээн тийм улс орны цаашдын хөгжил, энэ бүх зүйлд нөлөөтэй өөрчлөлт байх. Энэ Үндсэн хуульд орж байгаа өөрчлөлтийг тэгж бодож байна. Гэхдээ бусад улс орнууд 300 жил туулдаг ийм зүйлсийг бид нар 30-аад жил туулж байгаа. Мэдээж хэрэг алдаа оноо, авах гээх гээд зөндөө л юм байдаг байх. Төрийн байгуулалтын байнгын хороо дээр хэд хэдэн удаа тоо солигдоод байна. Засгийн газраас оруулж ирэхдээ 152, 50/50 тойргоос 50, жагсаалтаар 50 хувь нь

байна гэж оруулж ирж байсан. Дараа нь энэ тоо 126 болсон. Тэгээд 50/76 гэдэг тоо байсан. Одоо өнөөдөр яг энэ 3 дахь хэлэлцүүлэг дээрээ 48/78 гэдэг тоо орж ирж байна. Энэ маань яг зөв зүйтэй ийм тоо байж чадах уу. Нөгөө анх хууль санаачлагчаас орж ирсэн тоо энэ 2-ын хооронд зөрүүтэй байна. Би Засгийн газраас орж ирсэн тэр тоо тооцоолол энэ тэр бол мэдээжийн хэрэг судалгаа дээр үндэслэсэн ийм тоо байсан байх. Энэ Төрийн байгуулалтын байнгын хороо дээр өөрчлөгдсөн энэ тоо чинь 3 намын дарга яриад өөрчилсөн гэдэг асуудал ярьж байгаа. Тийм ээ. Эсвэл Төрийн байгуулалтын байнгын хороо дээр яриад ийм болсон юм уу, яасан юм. Тэрийг бас нэг тодруулж өг өө. Тэгээд энэ чинь сүүлд нь эрэмдэг зэрэмдэг юм болох вий. Энэ Үндсэн хуульд орсон өөрчлөлт чинь. Бид нарын хийх гээд байгаа энэ өөрчлөлт чинь энэ хулгай, авлига, олон түмний дургүйцэл, эдийн засгийн хөгжлийн сүүлийн 10 жилд гацсан энэ байдал, 2 хөрш гэхэд л бид нараас 2 дахин илүү байна шүү дээ. Тэрбум 400 сая хүнтэй улс, 140 сая хүнтэй улсууд. Тэр байтугай бид нараас 1 адил гараанаас эхэлсэн энэ Казахстан хүртэл бид нараас илүү ийм амьдралтай байна шүү дээ. Орлого нь ихэссэн, амьдрал ахуй нь сайжирчихсан ийм байдаг. Бид нар болохоор нэг л байран дээрээ ингээд яваад байдаг ийм юм байна. Хэрвээ энэ өөрчлөлтийг бид нар зөв зүйтэй хийж чадах юм бол тэр сонгуулийнхаа хуулийг, тэр намынхаа хуулийг ингэж хийж чадах юм бол маш зөв зүйтэй өөрчлөлт болж чадна. Хэрвээ бид нар буруу тийшээ явах юм бол энэ бол өмнөх 76-аас долоон дор болно. Сая сар болоход бол сарын хугацаанд бол ард түмэндээ энийг тайлбарлаж ухуулж гэгээрүүлэх ийм ажил бол хангалттай сайн хийгдэж чадсангүй гэсэн ийм зүйлийг бас анхааруулж хэлмээр байгаа юм би. Тэгээд харах л үлдэж байх шив дээ.

Г.Занданшатар: Гишүүд саналын томъёололтой холбогдуулж үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан зургаан гишүүнийг олныг төлөөлөх, тавин гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно.” гэснийг “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Санал хураалт явуулъя. Санал хураалт. 63 гишүүн дэмжиж 92,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж, саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Эрхэм гишүүд ээ,

Одоо Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг бүхэлд нь уншиж танилцуулъя.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу төслийг нэр зүйл, хэсэг, заалт, цэг таслал бүрээр нь уншиж танилцуулна гэж заасан байгаа. Тэгээд санал хураалт явуулах ёстой.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт.

Нэг дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэг дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай гэж байгаа юм.

Нэг.Улсын Их Хурал нэг танхимтай таслал нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна цэг Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна цэг Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх таслал дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно цэг

Одоо Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг бүхэлд нь баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Чинзориг гишүүн суудалдаа сууя. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

62 гишүүн дэмжиж, Үндсэн хуульд оруулах өөрчлөлт батлагдаж байна. Цогтбаатар гишүүн дэмжсэнд тооцох бол протоколд тэмдэглүүлж үг хэлж болно. Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Миний санал гарсангүй ээ. Тэгэхээр та протоколд тэмдэглээд оруулна уу. Дэмжиж оруулсан.

Г.Занданшатар: Ингээд Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас дээш гишүүд батлах санал өгсөн тул Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт батлагдлаа.

Ингээд Үндсэн хуулийн өөрчлөлт албан ёсоор батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, Ажлын хэсэгт баярлалаа.

Хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүд маань тойрогтоо ажиллаж, ард иргэдийнхээ санал бодлыг сонссон. Сая 3 дугаар хэлэлцүүлгийн үед гарсан саналуудыг томъёолон дурдвал Улсын Их Хурал ойр ойрхон Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад байна гэсэн агуулга дурдагдаж байна. 2019 онд Үндсэн хуульд

оруулсан өөрчлөлт бол үр дүнгээ өгч эхэлж байгаа. Өнөөдрийн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль ч гэсэн энэ агуулгаар батлагдсан. Олон сангууд ил болж, олон жил бугшсан юмнууд ил тод болж, цаашидаа Үндэсний баялгийн сангийн хууль батлагдах хүртэл олон өөрчлөлтүүд цаашидаа хэрэгжинэ. Энэ бол үр дүнгээ өгнө гэдэгт итгээж байгаа. Энэ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дутууг гүйцээж байна. Нөгөө талаасаа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр энэ давхар дээлийн асуудал буюу Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр ажиллах асуудлыг хүчингүй болсонд тооцсон. Энэ бол Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан асуудал биш. 2019 онд оруулсан өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэцээс хүчингүйд тооцсон учраас тэр заалт 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийн заалт хүчингүйд тооцогдсон. Энэ заалт маань ч гэсэн өнөөдрийн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нэг шалтгаан, шалтаг нь болж байгаа юм. Яагаад гэхээр Улсын Их Хурлын 76 гишүүнтэй үед нийт гишүүний олонх нь буюу 39-өөс дээш суудал авсан нам олонх болно. Олонхын доторх олонхын хяналтыг Засгийн газрын гишүүд бий болж Үндсэн хуулийн хяналт тэнцэл, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын харилцан хяналт тэнцэл алдагдах учраас гишүүдийн тоотой асуудлыг зайлигүй харгалзан үзэхийг Үндсэн хуулийн цэц дүгнэлтдээ дурдсан байсан. Ийм учраас Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлт, нөгөө талаас өнөөдрийн энэ 30 жил нийгэмд бугшсан авлига, хээл хахуулийн асуудал, өмч хувьчлалаас эхлээд олон алдаа завхралууд энийг засаж, янзлах гэсэн иргэд, нийтийн хүсэмжлэл бол энд тусгалаа олчихсон гэж бодож байгаа.

Ийм учраас энэ Үндсэн хуулийн өөрчлөлт бол олон үр дүнгээ өгнө гэж итгэж байна. Түүхэн үүргээ маргаашаас эхлээд гүйцэтгэж эхэлнэ гэж итгэж байна. Харин зөв зүйлийг бид алгуурлалгүй тайван алсын хараатай хийж чадах нь үр дүнгийн суурь болно. Үүний дагуу Улсын

Их Хурлын тухай хууль өөрчлөгдөнө. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль өөрчлөгдөнө. Улс төрийн намын тухай хууль өөрчлөгдөнө. Сонгуулийн хууль өөрчлөгдөнө. Ингэж байж энэ цогц өөрчлөлт болж шударга иргэдийн төлөөлөл болж өргөжнө. Сая бас манай олон гишүүд ярьж байна. Тэр ашиг сонирхлын тухай хуульд хуулиа эцэслэн батлах шаардлагатай. Ингэж байж Улсын Их Хурлын гишүүн бол зөвхөн төр түмнийхээ төлөө зүтгэх, аливаа тендерт оролцдоггүй, хамаарал бүхий этгээдээ албан тушаалд томилоход нөлөөлдөггүй байх бүх хориг саадыг тавьж, ингэснээрээ тоондоо биш, чанартаа энэ асуудал байна гэсэн асуудлыг ч гэсэн нэр мөсөн цэгцэлнэ.

Ийм учраас энэ цогц өөрчлөлтийг хийхэд бид маргаашаас эхлээд улам шаргуу ажиллах хэрэгтэй. Ерөөсөө энэ Үндсэн хуулийн өөрчлөлт батлагдангуутаа маргааш бүх юм сайхан болчихно гэсэн үг биш. Харин түүнийг дагаж гарах органик хууль, үндсэн хуульчилсан хууль, процессын хуулиудаа бид даацтай нийт ард түмний эрх ашигт нийцүүлж байж шийднэ. Ийм учраас Монголын нийгэмд бол энэ том шилжилт хийгдэж байна гэж үзэх ёстой. Алдаанаасаа суралцсан, илүү хэрсүүжсэн, илүү олон зөв өөрчлөлтийг нийгэм хүсэмжилж байна. Шударга ёсыг иргэд хүсэмжилж байна. Иргэд үнэн зөвийг хүсэмжилж байна. Хэрсүү иргэд бол бас тэнцвэртэй үнэн бодит мэдээллийг хүсэмжилж байна. Ийм учраас нэг буруугаа илчилдэг, нийгмийн асуудлуудаа зоригтой хэлэлцэж шүүдэг, шударга бустай үл эвлэрдэг, буруу зөрүүг шууд хэлдэг, хэрсүүжсэн мэдээлэлжсэн гэсэн иргэд нийгмийн олонхыг бүрдүүлдэг болсныг бид сая Үндсэн хуулийн өөрчлөлтийн хэлэлцүүлгийн үеэр харлаа. Хэрсүү иргэд бол тэнцвэртэй бодитой мэдээллийг хүсэж байна. Үнийн өсөлт, хүний эрх, шударга ёс гээд олон асуудлыг иргэд шүүмжлэн хэлэлцэж байна. Ийм ч учраас төрд үл итгэх итгэлээ ч гэсэн илэрхийлж байна. Шууд шийдэгдэх

боломжууд ч гэсэн төрд байгаа. Түрүүчээсээ төсвийн тодотгол боломжоороо асуудлуудаа шийдэж байна.

Одоо нийгмийн хүсэл эрмэлзэл, хүсэл зоригоо сонсож, түүний төлөө зүтгэх нь орчин үеийн төрийн хамгийн чухал үзэлт үзүүлэлт юм. Бас энэ дотор онцлон тэмдэглэх ёстой зүйл бол төр иргэний итгэлцлийг холдуулж, парламентын нэр хүндэд зориуд зохион байгуулалттай халдаж, энэ парламентын ардчиллын нэр хүндийг унагаах ийм санаатай, санамсаргүй үйлдэл хэсэг бүлэг гадаад, дотоодоос гарч байна гэж хэлэхэд болоход болохгүй байх аргагүй юм. Яагаад гэвэл энэ төрд итгэх итгэл бол Монголын энэ ардчиллын суурь юм. Ийм учраас энэ эдийн засаг өсөж, иргэдийн амьжиргаа дээрдэж, буруу булхайнууд илчлэгдэж, бохир арга барилууд үйлчлэхээ больж байгаа нь энэ гадаад, дотоодын бүлэглэл, хэсэг бүлгүүд, шунахай бүлэглэлд уул уурхайн бүлэглэл таалагдахгүй байж болно.

Үүнийхээ хариуг Монголын төр харин шударга энэ шийдвэртэй өөрчлөлтүүдээрээ тод томруун харуулах ёстой. Ийм учраас Үндсэн хуулийн өөрчлөлтийг бол бид эхлүүлж байна гэдгээ бол бодох хэрэгтэй. Энийг яг органик хуулиуддаа, процессын хуулиуддаа суулгаж, бүх процесс шударга байх энэ зарчмуудыг суулгая. Ийм учраас энэ төр иргэний итгэлцлийг холдуулах, Монгол төрийг сульдуулах холын бодлого хүчтэй хэрэгжиж байгааг гишүүд иргэд ч гэсэн сайтар анхаарч хэрсүү оюун ухаандаа тунгаан бодож, Монгол төрөө эрүүл, нийгмээ шударга болгох их үйлсийн төлөө энэ өөрчлөлтийг хийлээ гэж бид итгэж байна. Энэ үр дүнгээ бодитой гаргахын төлөө Улсын Их Хурлын гишүүд бид илүү их хичээж, хөдөлмөрлөж ажиллахыг уриалж байна. Анхаарал тавьсанд баярлалаа. Үндсэн хуулийн өөрчлөлт батлагдлаа.

Одоо дараагийн асуудал орно.

Хүсэлт ирж байна. Энэ Жамбын Батсуурь, Ням-Осорын Учрал, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын гишүүд бас дэмжсэн боловч эсрэг санал гарсан учраас протоколд тэмдэглүүлэх хүсэлтээ илэрхийлж байна. Ингээд Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: Энэ Дэлгэрсайхан гишүүн бид 2-ын саналыг бас та бүхэн дэмжсэнээр протоколд үлдээж өгнө үү гэж хүсэж байна. Тэгээд анхнаасаа бас Үндсэн хуулийн өөрчлөлтийг дэмжиж байсан. Тэгээд бид 2 бас нэг эрүүл мэндийн шалтгаанаар санал хураалтын үеэр оролцож чадсангүй.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүнийг протоколд дэмжсэнээр тэмдэглэе. Тэгэхдээ Ням-Осорын Учрал гишүүн бол Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүнийг төлөөлөх бололцоогүй. Зөвхөн өөрийгөө төлөөлнө. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн өөрөө л хэлэх ёстой.

Б.Дэлгэрсайхан: Юуны өмнө хүлцэл өчье. Тэгээд Үндсэн хуулийн өөрчлөлтийг анхнаасаа дэмжиж байсан. Тэгээд сая санал хураалт дээр бас энэ үүдэнд нэг дөнгөж эмнэлгийн тасаг руу орж нэг тариа хийлгээд ороод ирэх хооронд ингээд хоцорчихлоо. Хүлцэл өчье. Тэгээд намайг дэмжсэнд тооцож протоколд оруулж өгнө үү.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Сая нөгөө үг хэлэх хүмүүсийг тооцоод үзсэн чинь нэг цаг орчмын зай болонгуут нэг хажуу тийшээ эмчилгээнд орчхоод ирсэн чинь жаахан хожигдчихлоо. Тариа хийлгэсэн байсан юм. Тэгээд дэмжсэнээр тооцож өгнө үү.

Г.Занданшатар: Гишүүд чимээгүй.

Ж.Батсуурь: Тэгэхдээ юу шүү, дарга аа. Нөгөө бид нарын санал оронгуут нөгөө хувь чинь өөрчлөгдөнө шүү дээ.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Г.Занданишатар: Дэмжсэнээр тооцно уу гэж та.

Ж.Батсуурь: Тийм, тэгээд л нөгөө хувь чинь өөрчлөгдөнө шүү дээ. Нөгөө урьд нь гарах хувь нь өөрчлөгдөх ёстой байхгүй юу.

Г.Занданишатар: Дэмжсэнээр тооцож өгнө үү гэж протоколд тодорхой тэмдэглэхгүй бол.

Ж.Батсуурь: Тийм, тийм.

Г.Занданишатар: Дэмжсээр тооцож байна. Ингээд санал хураалтад 68 гишүүн оролцож 62 гишүүн дэмжсэн дүн гарсан. Энэ дээр Дамдины Цогтбаатар, Ням-Осорын Учрал, Борхүүгийн Дэлгэрсайхан, Жамбын Батсуурь нарын 4 гишүүн дэмжсэн саналаа протоколд тэмдэглэж илэрхийллээ. Санал хураалтын дүн 62-оор гарсан ч гэсэн нийтдээ 66 гишүүн дэмжсэнээр тооцож протоколд тусгая. Ингэвэл 97 хувьтай гарч байгаа юм. 66 гишүүн дэмжихэд 76-гаар тооцоход нийт гишүүний 86,8, оролцсон гишүүдийнхээ 97 хувь болох юм байна. Ингээд 66 гишүүн дэмжиж Үндсэн хуулийн өөрчлөлт батлагдлаа.

15.15 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэг, 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 1 санал хураасан бол хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 2 санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дарга Г.Занданишатар Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл дэх мажоритар гэдгийг олныг төлөөлөх гэж, пропорциональ гэдгийг хувь тэнцүүлэн хуваарилах гэж нэг мөр ойлгож хэрэглэх талаар хуралдааны тэмдэглэлд тусгуулсан болно. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарыг саналын томъёоллын хамт бэлтгэн та бүхэндээ тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга, саналын томъёоллыг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд өмнөх асуудалтай нэр овог, ажил, албан тушаал нэг мөн адил бүгд оролцож байгаа үргэлжлүүлээд. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Дамдины Цогтбаатар, Шатарбалын Раднаасэд гишүүнээр тасаллаа. Дамдины Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Д.Цогтбаатар: Би түрүүн ажлын хэсгээс бас асуусан. Одоо яг энэ дээр Оюунчимэг гишүүнээс бас нэг зүйлийг асуумаар байгаа юм, тодруулмаар байгаа юм. Ер нь бол ингээж ойлгох хэрэгтэй байна. 8 жил энийг одоо яг энэ журмын юу хэлэлцүүлэг орж ирж байгаа учраас энэ дээр би бас хэлж энийг протоколд үлдээмээр байгаа юм. 8 жил энийг бол эргээд хөндөхгүй гэж байгаа. Тэгэхээр энэ чинь юу гэсэн үг вэ гэхээр эрх зүйн ойлголтоороо 8 жилийн дараа эргэж харах үүд хаалга нээгдчихэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр кристаллизаци буюу илүү тодорхой нэг зүйлийг бид нар ойлголцмоор байгаа юм. 8 жил бид нар хараад энэ чинь болохгүй том эрсдэл үүсгэж байх юм бол энийгээ дүгнээд эргэж харна гэдэг ийм ойлголттойгоор цаашаа явмаар байгаа юм.

Тэгэх юм бол энэ Үндсэн хууль дээр ямар нэгэн хүндрэл гараад амьдрал дээр болохгүй болоод ирэх юм бол энийгээ зүгээр нээлттэй хандах биш эргээд дүгнэнэ шүү гэж Их Хурлын гишүүд энэ үедээ ярьж байсан шүү гэдгийг протоколдоо оруулж энэ санаачилга тэр үедээ явахад тэр улс төрийн суурь нь эрх зүйн болон улс төрийнх нь суурь нь болж өгөх ёстой гэж үзэж байгаа юм. Тэгээд ийм боломж байгаа юу Оюунчимэг гишүүнээ?

Г.Занданшатар: Энэ Байнгын хорооны дарга, Ажлын хэсгийн ахлагч Нямаагийн Энхболд гишүүн хариулна.

Н.Энхболд: Яг Цогтбаатар гишүүний хэлснээр ойлгож ингэж явж болно. Тийм.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ хуучин өргөн барьсан төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож байгаа юм байна л даа. Энэ 1, 2 хоёр чинь хоорондын яг уг нь агуулгын хувьд ямар ялгаа байгаа юм бэ? Одоо энэ шинээр нэг болгоод, сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй гэдэг нь ямар зориулалттай юм бол?

2 дугаарт бас нэг зүйл байна. Энэ зүгээр энэ дээр хийх ёстой байсан уу? Би зүгээр хүмүүстэй санал солилцож үзэхээр тийм юм байхгүй тэгж ойлгогдохгүй гээд байгаа юм. Ингээд бид нар чинь холимог тогтолцоо руу орчихлоо. Нэг жилд холимог тогтолцоо руу орчихсон юм чинь нэг жилд 2 сонгууль явах ийм нөхцөлийг тавьчихсан уу, үгүй юу? Хүмүүс бол яах вэ энэ Үндсэн хууль судлаач, Үндсэн хууль зохиохон судалсан хүмүүс бол тийм ойлголт байхгүй тэгж харагдахгүй байна гээд байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол 6 сарын 20-ны өдөр мажоритар тойргоос нэр дэвших сонгууль нь болоод, 6 сарын 30-ны өдөр

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

пропорциональ буюу тэр нөгөө юу билээ хувь тэнцүүлэн гэдэг сонгууль чинь болоод ингээд нэг ийм нэг хүн 2 удаа нэр дэвших боломжуудыг нээх эсхүл сонгуулийг улс төр гэдэг чинь нөгөө шумуулын юунаас нарийхан гэж ярьдаг биз дээ. Түүн шиг чинь тийм байдал руу оччих вий, тэрийг зүгээр энэ дээр бид нар хаах байсан уу? Тийм ойлголт байсан уу, үгүй юү бас?

Г.Занданшатар: Дагаж мөрдөнө гээд хүчин төгөлдөр болох байсныг дагаж мөрдөнө гэгчээд. Үгүй, чи байж бай. Нямаагийн Энхболд дарга асуултад хариулна.

Н.Энхболд: Эхний асуултын хувьд бол үндсэндээ агуулгын хувьд онцын ялгаа байхгүй. Бас яах вэ энэ түрүүчийн бид нарын түүхээс үзэхэд бид нарын ярьж дассанаар давхар дээл буюу Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын гишүүнийг хамтран гүйцэтгэж болох тухай өөрчлөлт орсны дараа бас нэг ямар маргаан үүсэж байсан гэхээр ингээд Үндсэн хуульд өөрчлөлт орсон юм чинь одоогийн байгаа Засгийн газар үйл ажиллагаа явуулах эрхтэй юү, үгүй юү, хууль ёсных уу, үгүй юү энэ тэр гэдэг асуудал гарч байсан юм. Тэрнээс тиймэрхүү үл ойлголцол гарах вий гэдэг үүднээс зориуд 24 он, 20 оны сонгуулиар байгуулагдсан Их Хурал бол наана нь ямар нэгэн асуудалгүйгээр бүрэн эрхээ хуульд заасны дагуу дараагийн Их Хуралд сонгогдож, бүрэн эрх нь хэрэгжиж эхлэх хүртэл эрхээ хэвээрээ хадгална гэсэн заалтыг нэг томъёоллыг нь жоохон өөрчлөөд ингэж оруулсан байгаа.

2 дахь асуултын хувьд бол тийм давхардах зүйл гарахгүй. 1 дүгээрт Сонгуулийн хуулиар энийг зохицуулагдана. Яаж сонгууль, хэдэн өдөр яаж явагдах гээд. 2 дугаарт ерөөсөө Үндсэн хуульд жишээ нь Улсын Их Хурал дор хаяж одоогийн хуулиар бол 76 байхад 57 нь бүрдчихсэн байхад бүрэн эрхээ хэрэгжүүлнэ гэсэн ийм зохицуулалт бас байдаг шүү дээ. Тэрэнтэй ижилхэн зохицуулалт энэ Үндсэн хуулийн

өөрчлөлтийг дагаад Улсын Их Хурлын тухай Эрх зүйн байдлынх нь тухай хуульд өөрчлөлт орно гэж ойлгож байгаа. Тэр тохиолдолд 2 удаа тусад нь сонгууль явуулах ямар ч боломж байхгүй. Нэг удаа явуулаад л нэг сонгуулиараа Их Хурлаа бүрдүүлнэ. Нэг хэсэг нь жагсаалтаар, нөгөө хэсэг нь тойргоороо сонгогдоод явна. Ингэж байж Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл байдал нь үүсэх учраас саяынх шиг тийм хоёрдсон ойлгомжгүй байдал үүсэхгүй байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Би энэ ажлын хэсгийн гишүүн. Тэгэхдээ бас нэг зүйлийг тодруулах шаардлагатай болчихоод байна. Энэ хуулийг хэрэгжиж эхлэх хугацаа дээр 1 дүгээр зүйл дээр болохоор өмнө нь Их Хурлын даргаас өгсөн нөгөө чиглэлийн дагуу ч бас ажлын хэсэг дээр ярилцаад 24 оны 1 дүгээр сарын 1-нээс улс орон даяар даган мөрдөнө гээд ингээд тодорхой заачихсан. Энхболд дарга та энэ 5 дугаар зүйлийг хар даа. 5 дугаар зүйл дээр болохоор батлагдсан өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэгчихсэн. Энэ 2 заалт хоорондоо энэ агуулгын хувьд зөрчилдөөд байгаа юм биш үү? Нэг нь 24 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр болно, дагаж мөрдөнө нэг нь батлагдсан өдрөөс.

Тэгэхээр яах вэ хуульд хүчин төгөлдөр болох өдөр, дагаж мөрдөх өдөр гээд 2 өөр байдаг ч гэсэн хоёулан дээр нь дагаж мөрдөнө гэсэн төгсгөлтэй байгаад байна л даа. Хоёулаа дагаж мөрдөхийг заачихсан. Тэгэхээр энэ дээр та нэг тайлбар хэлээч. Энэ дараа нь хууль зүйн хувьд зөрчил авчрахгүй юу?

Г.Занданшатар: 5 дугаар зүйлийг хэлээд байна уу?

О.Цогтгэрэл: 1, 5 хоёрыг.

Г.Занданшатар: Тэр чинь дагаж мөрдөх журмын тухай хуулиа дагаж мөрдөх хугацааг хэлж байгаа шүү дээ тийм ээ.

О.Цогтгэрэл: Тийм, харин.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, одоо хариулт хариулна. Нямаагийн Энхболд дарга хариулъя. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч хариулна.

Н.Энхболд: 1 дүгээр зүйл нь Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх тухай асуудал. 5 дугаар зүйл бол энэ дагаж мөрдөх, Мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг дагаж мөрдөх тухай асуудал 2 өөрөөр. Юуны тухай? Тэгээд дээр нь, Нямбаатар. 2 өөр хуулийн дагаж мөрдөх журмын тухай асуудал шүү.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүн Хишгээгийн Нямбаатар гишүүн хариулна.

Х.Нямбаатар: Би Цогтгэрэл гишүүний асуултад товчхон хариулъя. Энэ журмын тухай хуулийн 1 дүгээр заалт бол Монгол Улсын Үндсэн хууль энэ нэмэлт хэдийд хүчин төгөлдөр болох вэ гэдэг зохицуулалтыг зааж байгаа юм. Энэ хүчин төгөлдөр үйлчлэлийг өөртөө тээж дагаж орж ирж байгаа хууль нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ Үндсэн хуулийн нэмэлтийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйл нь болохоор энэ дагаж мөрдөх журмын тухай хуулийг өөрөө хэзээ хүчин төгөлдөр болох вэ гэдэг энэ агуулгыг оруулж ирж байгаа юм. Өмнөх Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд, өмнөх өөрчлөлтүүдийн, өмнөх өөрчлөлтүүд нь ихэвчлэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл дээрээ тухайн өөрчлөлтийг хэдийд хүчин төгөлдөр болох хугацаагаа зааж орж ирдэг байсан бол энэ удаагийн өөрчлөлт нь зөвхөн 20 дугаар зүйлийг өөрчлөх зохицуулалтыг төсөл хэлбэрээр

нэмэлтийн төсөл хэлбэрээр өргөн барьж орж ирсэн.

Хууль хүчин төгөлдөр болох 2 үндсэн аргын алийг нь хэрэглэх вэ гэдгийг ажлын хэсэг дээр ярьж байгаад Дагаж мөрдөх журмын хууль дээрээ Үндсэн хуульд оруулсан нэмэлтийг ийм хугацаанд хүчин төгөлдөр үйлчлүүлэхийгээ заая гээд 1 дүгээр зүйлээр зохицуулж байгаа юм. Тэр Үндсэн хуулийг амилуулж байгаа, дагаж мөрдөж байгаа шилжилтийг зохицуулж байгаа Дагаж мөрдөх журмын хууль чинь хэзээ үйлчилж эхлэх вэ гэдгээ 5 дугаар зүйлээр ингээд зохицуулаад явж байгаа гэдгийг нэмж хэлэх гэсэн юм. Энэ 2 өөр хуулийн 2 өөр өөрчлөлт үйлчлэлийг зохицуулж байгаа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна гэсэн 2 минут.

О.Цогтгэрэл: Би яг Нямбаатар сайд таны хэлснийг л яг асуугаад байна л даа. Энэ дагаж мөрдөх хугацаа чинь өөрөө Үндсэн хууль дээрээ бичигдээгүй шүү дээ. Угаасаа энэ дагах хууль дээрээ бичигдсэн шүү дээ. Тэгэхээр энэ хууль дээр чинь 24 оны 1 сарын 1, нэг нь өнөөдөр гэдэг 2 өдөр л ингээд Үндсэн хууль дээр бичигдчихсэн бол тусдаа асуудал шүү дээ. Таны хэлж байгаагаар. Гэтэл энэ чинь угаасаа дагаж мөрдөх хугацааг Үндсэн хууль дээр нэг ч өгүүлбэр байхгүй байгаад байгаа шүү дээ. Нэг хууль дээр л 2 заалт хоорондоо зөрчилдөөд байгаа юм биш үү. Зүгээр яах вэ хууль зүйн техникийн хувьд болоод хууль зүйн хувьд энийгээ бас тэгээд тал талдаа анхаараад л явах ёстой байх даа.

Г.Занданшатар: Санал дээр үг тавина. Дараа нь Чимэдийн Хүрэлбаатар сайд асуулт асууна. Тэгэхдээ энэний өмнө Цогтгэрэл гишүүний асуултад хариулаадахъя. Энд 3 хугацаа байгаа юм. Батлах өнөөдөр ингээд батлагдана шүү дээ тийм ээ. Батлагдлаа гэж бодъё. Батлагдсан хугацаа. Батлагдсаны дараагаар хоригийн хугацаа өнгөрөөд,

нотлон баталгаажуулаад албан ёсоор эх нь хэвлэгдээд хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болох хугацаа. Хүчин төгөлдөр болсон Үндсэн хуулийн өөрчлөлтдөө нийцүүлж Сонгуулийн хууль, Улс төрийн намын тухай хууль бусад хууль, эрх зүйн орчин, органик хуулиудаа батална. Дагаж мөрдөх хугацаа нь 24 оны 1 сарын 1-нээс. Ингээд 3 хугацаа байгаа гэж ойлгуулж өгнө. Тийм учраас энэ Хишигээгийн Нямбаатар гишүүн тэр санал гаргаад, гишүүн маань санал гаргаад бас энэ 3 дугаар санал хураалт дээр тэр батлах хугацаа гэдэг маань бас цаана нь батлаад мөрдөх хугацааны зөрүү гарчхаад байгаа учраас баталж мөрдөх гэж өөрчлөлт оруулъя гэсэн санал гаргаж санал хураалгая гэсэн ийм санал ирсэн байгаа.

Түрүүн Оюунчимэг гишүүний танилцуулгад тэр протоколд нэг тэмдэглүүлэх асуудал байна. Тэр миний хэлсэн үг дээр протоколд тэмдэглүүлэх асуудал бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл дээр мажоритар гэдгийг олныг төлөөлөх, пропорциональ гэдгийг хувь тэнцүүлэн төлөөлөх гэсэн төлөөлөх гэж нэг мөр ойлгоно шүү гэж. Энэ дээр хуваарилах гээд биччихсэн байгаа юм. Хувь тэнцүүлэн төлөөлөх гэж.

2 дугаарт нь холимог тогтолцоо гэдэг үг нь хаягдсан байна. Энэ 2 тогтолцооныхоо хослуулан явуулж байгааг холимог тогтолцоо гэж нэрлэнэ гэж ингэж протоколд тэмдэглээд явахыг ажлын хэсгийг нэг мөр шийдсэн болохыг энд зориуд дурдан цохон тэмдэглэе. Протоколд тусгуулж байна. Энэ ажлын хэсгийн санал. Чимэдийн Хүрэлбаатар гишүүн асуулт асууна.

Ч.Хүрэлбаатар: Үндсэн хуульд оруулах өөрчлөлт ингээд батлагдаж байна. Нэг л зүйл дээр би бүүр баталгаатай хариу авмаар байгаа юм. Юу вэ гэхээр энэ намар сонгуульд явна, сонгууль болно, сонгууль хийгдэнэ гэдэг яриа нэлээд явагдсан. Олон улс төрчийг ч

идэвхтэй болгосон. Энэ хэвлэл мэдээллийн хэрэгслээр явж байгаа сошиалаар явж байгаа байдлыг харахад бол заримдаа сонгууль эхэлчихсэн юм шиг санагдаж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр би тодорхой хариулт авмаар байгаа юм. Үндсэн хууль батлагдчихлаа. Улсын Их Хурал 126 гишүүнтэй байх ёстой. Одоо энэ 76 юу хийж байгаа юм бэ? 126 болгоё гээд намар тийшээ сонгууль руу явуулна гээд хэсэг хүн гараад ирэх вий.

Тэгэхээр дотор нь 80 юу гэдэг юм 2020 оноор оноор Улсын Их Хурлын сонгуулиар бүрдсэн Их Хурал бүрэн эрхтэй эрхээ 24 оны сонгууль хүртэл хэрэгжүүлнэ гэдэг заалт байгаа гээд яриад байгаа юм. Гэхдээ энэ батлагдсан Үндсэн хууль батлагдчихсан учраас хэрэгжээд эхэлчихсэн. Гэтэл энэ дотроо заалт чинь өөр байна гээд Цэц дээр очоод дахиад өөрөөр асуудал шийдэгдээд энэ намар луу сонгууль болохгүй гэдэг заалтыг яаж та нар баталгааг нь энэ дотроо оруулж ирж өгч байгаа юм бэ? Тэгэхгүй бол энэ Монголын улс төр хэлбэлзэж л байдаг. Янз бүрийн юм болж л байдаг. Гэхдээ Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллагын хувьд хэзээ ч цаг хугацаанаас өмнө тарж байгаагүй. Үүнээс өмнө нь сонгууль ч болж байгаагүй. Тэгэхээр энэ удаагийн парламентын гишүүд бид нар санал өгөхдөө энэ батлагдаж байгаа дээрээ Дагаж мөрдөх хууль дээрээ энэ төрийг самарсан юм уу, энэ сонгуулийг наашлуулсан ямар нэгэн зүйлийг бид нар хийх учиргүй.

Тэгэхээр ажлын хэсгээс энэ дээр бүүр баталгаа авмаар байна. Нэг өгүүлбэр оруулчихлаа, одоо тэгэхээр гайгүй гээд бодоод явж байтал Цэц дээр нэг нь гомдол гаргаад тэгээд энэ намар сонгууль хийнэ, энэ алдаатай болчихжээ, болчихжээ гээд явчих ийм эрсдэл бол байгаа шүү. Тийм учраас яг энийг нэг мөр энэ дээр ойлголт аваад, энэ дээрээ гишүүд саналаа үүнтэйгээ холбогдуулаад өгчихмөөр байна. Тэгэхээр энэ дээр би

ажлын хэсгээс яг баталгаатай хариу энэ дээр сонсмоор байна.

Г.Занданишатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Нямаагийн Энхболд баталгаатай хариуг өгнө. Улс төрийн намуудын төлөөлөл бүрэн оролцуулж байна.

Н.Энхболд: Миний өгсөн хариу баталгаа болоод байдаг бол амархан л байна. Би хариулъя. Энэ 1 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 24 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө гэдэг бол энэ намар тийм юм болохгүй гэдгийг баталгаажуулж байгаа юм. Нэг заалт байгаа юм.

Би түрүүн хэлсэн. Түрүүн нөгөө гишүүд Засгийн газрын гишүүнийг хамтруулж хийж болох хууль гарсны дараа яг Хүрэлбаатар сайдын ярьж байгаа шиг тийм асуудал нэг хэсэг манайд гарсан. Бас хөөрхөн бужигнаан болж байсан. Тэгээд тэрнээс сэргийлэх зорилгоор бид нар Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь өөрөө 1 сарын 1-нээс өмнө, 1 сарын 1-нээс хойш дараа оны хүчин төгөлдөр болно гэж заагаад, бусад наана нь хийх юмнуудаа Дагаж мөрдөхөд шилжих журмынхаа дагуу зохицуулсан гэж л хэлье дээ.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, асуулт дууссан. Одоо хариулт үргэлжилж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ үг хэлнэ. Асуулттай холбогдуулж.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэндээ бас Засгийн газраа төлөөлөөд энэхүү хуулийг санаачлагчийн хувьд талархал илэрхийлж байна. Хэдийгээр Үндсэн хуульд орж байгаа энэхүү сонгуулийн тогтолцооны энэ асуудал нэг өгүүлбэр боловч өнөөдөр

сонгуулийн тогтолцооны суурь реформ хийгдэж байна гэж ойлгож байна. Энэ бол шинэ 30 жилийг цоо шинээр эхлүүлэх ийм шинэ тоглоомын дүрэм гэж ойлгож болно. Цаашилаад улс төрийн намууд, эрх баригчид сонгууль дөхөөд өөрсдөдөө зориулсан ийм тоглоомын дүрэм хийх энэ бүх өнгөрсөн алдаа энд хүрээд цэг тавигдлаа. Одоо энэ л тоглоомын дүрмээр цаашдаа дараа дараагийн сонгуульд бид нар оролцдог байх ийм том агуулга явж байна.

Нэг гишүүнд ноогдсон эрх мэдлийн хэт төвлөрөл өнөөдрийн энэхүү санал хураалтаар ингээд цэг тавигдаж байна. Тэгэхээр үүнээс болоод хууль тогтооход 1 гишүүн 2, 3 Байнгын хороонд давхар ордог, хууль хэт хяналтгүй гардаг энэ бүх асуудал ингээд түүх болж үлдэж байна гэж ойлгож болно. Цаашилаад Байнгын хороо илүү мэргэшсэн, 1 парламентын гишүүн 1 л Байнгын хороонд ордог байх энэ том агуулгын том реформ бас хийгдэж байна гэж ойлгож болно.

Мөн эрх мэдлийн төвлөрөл одоо ингээд задарчхаж байгаа учраас ямар нэгэн байдлаар Их Хурлын гишүүн байх нь өөртөө давуу байдал олгох энэхүү асуудал ингээд эцэслэгдэн шийдэгдлээ гэж ойлгож болно. Бид нар хамтдаа л бүгдээрээ Их Хурал, Засгийн газар өнгөрсөн 30 жилийнхээ л алдааг дүгнэж, шинэ 30 жилийг эхлүүлэхийн төлөө л явж байгаа юм. Олон алдаа завхрал, ололт амжилтууд байгаа. Бүгдийг нь бид нар сайныг нь сайн, мууг нь муугаар нь ил тод нээлттэй болгоод л явж байгаа юм. Цаашилаад энэ суурь реформ өөрөө салбарлаад сая Их Хурлын даргын хэлснээр ингээд органик хууль болоод баяжаад ирэхээр өмнө нь гарсан энэ бүх алдаа завхралууд цэг тавигдаад ийм шинэ тоглолтын дүрэм рүү орж байна гэж ойлгож болно. Тэгээд энэ бол мэдээж Их Хурлын гишүүдээс маш их хэмжээний ийм эр зориг шаардсан нөгөө талаараа ирээдүйг харсан ийм алсын хараа шаардсан хүнд хэцүү ийм өдрүүд байлаа.

Энэ асуудал урьд нь олон удаа яригдсан. Тэгээд яг шийдэгдэхийн өмнө тэгээд л асуудал шийдэгдэж чадахгүй бол сүүлийн бараг хориод жил ингээд яриад явсан, 19 онд ч бас чадаагүй. Тэгээд өнөөдөр магадгүй энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд цар тахалтай, дайн тулаантай нөхцөл байдлын дундуур энэ парламент бүрэн эрхийнхээ хугацаанд хийсэн хамгийн том түүхэн реформ бол энэ болж түүхэнд үлдэнэ. Энэ дээр Их Хурлын гишүүд та бүхэн маань итгэлтэй байж болно гэж бодож байна. Засгийн газраас өргөн барьсан хувилбараар бол 152 буюу эрх мэдлийн энэ төвлөрлийг 2 дахин задлах, төлөөлөх эрхийг 2 дахин нэмэгдүүлэх байсан. Ингээд бид нар Ардчилсан намдаа бас хүндэтгэлтэй хандаж Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны шийдвэрийн дагуу өнөөдөр 126 болох энэхүү зөвшилцөл хийгдсэн гэж ойлгож болно. Тэгээд Ардчилсан нам энэ асуудлуудыг санаачилж дэвшүүлсээр ирсэнд талархал илэрхийлье. Энэ бол та бүхний л манлайлал. Та бүхний олон жилийн хугацаанд ярьж ирсэн энэхүү дэвшилттэй үзэл баримтлалын үр дүн өнөөдөр парламент дээр хэлбэршиж байна гэж бас ойлгож болно.

Мөн ХҮН намд бас талархал илэрхийлье. Бидний хувьд бол аль болохоор нийгмийнхээ захиалгыг ирээдүйг мэдэрч аливаа нэг асуудалд илүү хүлээцтэй цөөнхдөө хүндэтгэлтэй хандах энэ агуулгаар л зөвшилцлийн хүрээнд өнөөдөр энэхүү Үндсэн хуулийн реформ хийгдэж байна. Энэ ингээд их олон өөрчлөлтүүд гарна, жендерт маш том хэмжээний дэвшил авчирна. Жинхэнэ утгаараа олон намын тогтолцоо руу Монгол Улс өнөөдрөөс эхлээд орж байна гэж ойлгож болно. Зөвхөн нутаг дэвсгэр тойрог руу хандсан биш, нийгмийн сегментүүд рүү хандсан ийм том өөрчлөлтүүд гарна. Гадаадад байгаа манай хилийн чанадад байгаа Монголчуудын төлөөлөл парламентад орж ирэх саналаа өгөх боломж бас үүгээр нээгдэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд олноороо

парламентад орж ирэх үүд хаалга нээгдэж байна. Энэ бол гагцхүү намуудын бодлогоос хамаарна. Намууд үзэл санаагаараа мэтгэлцдэг байх ийм үүд хаалга нээгдэж байна. Манайх социал демократ үзэл баримтлалтай намын хувьд бид нар багш, эмч нар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, соёлын салбарыг шинжлэх ухааныг илүү чухалчилна. Ардчилсан нам либерал үзэл санаатай намын хувьд хувийн хэвшил бусад олон байгууллагуудыг илүү хүний суурь эрхтэй холбоотой олон төлөөллийг оруулж ирэх үүд хаалга нээгдэж байна. ХҮН нам ч гэсэн бас сэхээтний ийм том давхрыг төлөөлж байгаа шинэ улс төрийн хүчний хувьд маш том хэмжээний үүд хаалганууд нээгдэж байгаа. Парламентад суудалгүй байгаа олон намуудад өнөөдөр бид нар хамтдаа бодитой шударга өрсөлдөөний үүд хаалгыг нээж өгч байгаагаараа энэ бол маш их тийм онцлогтой юм гэж бас бодож байна. Парламентад малчдын төлөөлөл орж ирэх, парламентад гэр хороололд амьдарч байгаа иргэдийн төлөөлөл орж ирэх.../минут дуусав/

Г.Занданшатар: Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулья.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. Асуулт байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Тийм, 24 оны 01 сарын 01-нээс дагаж

мөрдөнө гэдэг нь саяын таны асуусан Нямаагийн Энхболд даргын хариулсан, Цогтгэрэл даргын дэвшүүлсэн санаа. Санал хураалт.

65 гишүүн дэмжиж, 97 хувийн саналаар санал дэмжинэ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжих хүртэл 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал бүрэн эрхээ хэвээр хадгална. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. 66 гишүүн дэмжиж, 98,5 хувийн саналаар санал дэмжигдсэн. Манай Чимэдийн Хүрэлбаатар гишүүн нөгөө төр самрах гэж айхтар үг хэлсэн. Тэгээд түүнийгээ баталгаажуулж асууж тодруулах гээд байгааг ойлгож байна. Яг л тэр агуулгаар л Цогтгэрэл нарын гишүүд санал гаргаад л энэ саналууд орсон гэж ойлгож байгаа.

Дараагийнх нь 3.Төслийн 3 дугаар зүйлийн “2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг үндэслэн олныг төлөөлөх /мажоритар/, хувь тэнцүүлэн хуваарилах /пропорциональ/ тогтолцоог хослуулан явуулах зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаар Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэснийг “2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлтөд оруулах болон шинэчлэн батлах хүртэл хугацаанд

тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 6 дугаар сарын 25-ны дотор, холбогдох бусад хууль тогтоомжийн өөрчлөлтийг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж өөрчлөх. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал Хишгээгийн Нямбаатар гишүүнээр тасаллаа. Хишгээгийн Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Баярлалаа. Энэ сая Төрийн байгуулалтын байнгын хороо дээр хураасан одоо хураагдах гэж байгаа саналтай холбогдуулаад би зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа. Яагаад гэвэл энэ өмнө нь хөндөгдсөн асуудал, хөндөгдсөн асуудал учраас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн, тэгээд одоо миний оруулж байгаа хүртэл нь баталж мөрдөх хүртэл хугацаанд, баталж мөрдөх хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө гэсэн томъёоллоор санал хураалгая.

Г.Занданшатар: Редакц биш. Энэ асуудал хөндөгдсөн асуудал бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хороон дээр би яг энэ саналыг хэлээд бас эцсийн найруулга дээрээ анхааръя гэж тохирсон учраас, баталж мөрдөх дагаж мөрдөх хугацаа байхгүй бол батлах, мөрдөх хоёрын нөгөө 3 хугацаанд зөрүү гараад байгаа учраас. Сүхбаатар, Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн ч гэсэн бас нэмж үг хэлсэн юм. Тэгэхээр энүүгээр нь Нямбаатар гишүүний үгээр аваад явчихвал Тамгын газар болж байна уу? Та хэд микрофон тодотгол хийчих. Тамгын газрын микрофоныг.

Л.Өлзийсайхан: Улсын Их Хурлын Тамгын газраас Нямбаатар гишүүний

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хэлсэн саналыг бол төсөлд тусгаад аваад явахад бол хууль бол зөрчихгүй.

Г.Занданшатар: Хууль зөрчихгүй.

Ингээд би саяын оруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын дагуу саналын томъёоллыг дахиж уншиж танилцуулъя. 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн батлах хүртэлх хугацаанд гэснийг шинэчлэн баталж мөрдөх хүртэл хугацаанд, хугацаанд гэдгийг нь авах юм уу тийм ээ? Хүртэл, хүртэлх. 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн баталж мөрдөх хүртэл тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 25-ны дотор, холбогдох бусад хууль тогтоомжийн өөрчлөлтийг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэж шийдвэрлэнэ. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Энэ саналын томъёоллоор санал хураалт явуулна. Хүртэл, хүртэлх. Дахин тодруулж хэлье. Холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн батлах, батлах хүртэлх, хүртэл, хүртэл юм байна. Хүртэл тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож, 64 гишүүн дэмжиж, 95,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Тэр нөгөө юутай холбоотой юм чинь яасан билээ, нотлон баталгаа? Эцсийн найруулга дээр. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд

шилжих журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д долоо хоногийн баасан гарагийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийг эцэслэн батлах бөгөөд хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах ирц хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн баталж болно гэж заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг эцэслэн батлах хувилбарыг бэлтгэн, гишүүдэд тарааж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна. Одоо төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Өмнөх нь. Өмнөх нь ч одоо өнгөрчихсөн л байна л даа. Цагийн юм цагтаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т зааснаар нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Энэ дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 66 гишүүн дэмжиж, 98,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. 2 санал хураалтын, 2 хуулийн төсөл эцэслэн батлах санал хураалтын дараагаар эцсийн найруулгыг сонсоно. Гишүүд бас байж байгаарай.

15.48 цаг

Дараагийн асуудалд орно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн батална.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу нийт гишүүний олонхоор бол батлан батална. Хассуурийн Ганхуяг гишүүн сууж байгаарай. Хассуурийн Ганхуяг, Дашдондогийн Ганбат гишүүн, Сайнбуянгийн Амарсайхан сайд суугаарай. Энэ хуулийн төсөл. Санал хураалт явуулъя. Эцэслэн батлахаар бэлэн болсон байгаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хоёрхон. 60 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Энэ хугацаатай учраас 06 сарын 01-ний дотор, 05 сарын 31-ний дотор батлах ёстой.

15.50 цаг

Баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулга дээр Хишигээгийн Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Баярлалаа дарга. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан найруулгын санал гаргаж байна. Хүчин төгөлдөр болсон өдрөөс гэдгийг нотлон баталгаажуулсан өдөр гэж ойлгож ирсэн тул тодорхой болгохын тулд нотлон баталгаажуулах гэсэн үгээрээ найруулгын санал оруулъя гэсэн санал гаргаж байна.

Г.Занданшатар: Энэ найруулгаараа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.3, 16.4-д заасан хуулийг тодруулж

байгаа учраас үүнийг найруулгаар авахаар тогтсугай. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алба байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд үндсэндээ дуусаж байна. Чухал асуудлыг ажил хэрэгч, шуурхай хэлэлцлээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.53 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

Д.ОТГОНДЭЛГЭР

Э.СУВД-ЭРДЭНЭ

Д.УЯНГА

П.ОЮУНГЭРЭЛ